

Лиахоно



Ариун сүм:
Их Эзэн та нарыг
адислахаар энд хүлээж
байна, 12, 18, 20-р хуудас

2018 оны Мючелийн сэдэв: 24, 50-р хуудас

Шинэ сургалтын материал дээрх зөвлөлийн хүч, 28-р хуудас

Яагаад уламжлалт гэр бүлийг хамгаалах хэрэгтэй вэ?, 32-р хуудас

БУРХАНЫ ХАМГИЙН
АГУУ БЭЛГҮҮДИЙН
НЭГ БОЛ **ДАХИН**
ОРОЛДОЖ ҮЗЭХ
БАЯР БАЯСГАЛАН
ЮМ. ЯАГААД ГЭВЭЛ,
БҮТЭЛГҮЙТЭЛ БОЛ
ТӨГСГӨЛ БИШ.

ЕРӨНХИЙЛӨГЧ ТОМАС С.МОНСОН




Тэргүүн Зөвлөлийн захиас бичгээс, хуудас 4.



7

ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Наманчлалын бэлэг**
Ерөнхийлөгч Томас С.Монсон
- 7 Айлчлагч багшийн зарчмууд: Түүнтэй ямар ч цаг үед, хаана ч байсан, бүхий л арга замаар холбоотой бай**
Энэ жилээс эхлэн сар бүрийн захиас бичгийн оронд айлчлагч багшийн зарчмууд дээр анхаарлаа төвлөрүүлэх нь хайрладаг эгч нартаа илүү сайн үйлчлэхэд тань тусална.



ХАВТСАН ДЭЭР

Кристина Смитийн авсан Францын Парис ариун сүмийн таазны цонхны зураг.

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 8 Харж, амьдар**
Ахлагч В.Марк Бассэтт
Бидний сүнс яг миний машины аккумулятортай адил тэнгэрлэг гэр рүүгээ буцаж очихын тулд тогтмол цэнэглэгдэж байх хэрэгтэй.
- 12 Ариун сүм биднийг илүү гүн алсын хараатай болгодог**
Жийн Б.Бингам
Ариун сүмд очих нь амар амгаланг болон мөнхийн талаас харах чадварыг олоход танд хэрхэн туслах талаар олж мэд.
- 20 Ариун сүмд очсоны төлөө амлагдсан адислалууд**
Шэри Эванс
Бид эцэг эхийн хувьд амлалтаа биелүүлэхийн тулд бүтээлчээр сэтгэх хэрэгтэй ч ирэх адислал нь ямар ч золиослолоос агуу билээ.

24 Та нар, өсвөр үеийнхэн, Мючелийн сэдэв
Жэссика Гриффит
2018 оны Мючелийн сэдвийг хичээл, үйл ажиллагаа зэрэгт хэрхэн ашиглах тухай эцэг эх, удирдагчдад зориулсан дараах санаануудтай танилцана уу.

28 Зөвлөлд суух нь
Майкл Маглби
Бид Ням гаргийн Мелкизедик санваарын болон Халамжийн нийгэмлэгийн цуглаанууддаа зөвлөлийн хүчийг тусган хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийг хэрхэн олж авч ашиглах вэ?

32 Гэр бүлийн мөнхийн ач холбогдол
Ахлагч М.Рассэлл Баллард
Бид уламжлалт гэр бүл Тэнгэрлэг Эцэгийн төлөөлөгөөнд хэчнээн чухал болохыг ойлгох юм бол үүнд нэгдэж, дэмжих болно.

БУСАД ӨГҮҮЛЭЛ

- 18 Дуу хөгжим: Ариун сүмд ирцгээ**
Жан Пинберөү, Майкл Ф.Мүүди
- 38 Итгэлийн хөрөг: Аманда Жири**
- 40 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**
- 80 Биднийг дахин уулзах хүртэл: Бүтээх болсон зорилго**
Ерөнхийлөгч Н.Элдон Таннэр



44


44 Төлөвлөснөөсөө эрт гэртээ ирсэн нь

Дэстини Яарбро

Би номлолын талбараас хугацаанаасаа өмнө буцаж ирсний дараа өдөр тутмын үйл ажиллагааныхаа учрыг олоход хэцүү байсан ч өөр олон арга замаар үргэлжлүүлэн үйлчлэх боломжтой гэдгийг ухаарсан.

48 Институт сайн мэдээнээс суралцахад тань хэрхэн тусалдаг вэ?

По Ниэн (Филип) Чоу



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сэжүүр: Та хэнд хандаж хариулт авах боломжтой вэ?



56

50 2018 оны Мючелийн сэдэв: Сургаал ба Гэрээ 19:23

Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

52 Зурагт хуудас: Аврагчаас ирэх амар амгалан

53 Шат шатаар: Сургаал ба Гэрээ 19:23

54 2018 оны Мючелийн уриа дуу: Аврагчаас ирэх амар амгалан
Ник Дэи

56 Аврагчийн үгсийг судал
Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон
Та Христийн талаарх судрын бүх эшлэлийг судалсныхаа дараа гэрчлэл тань хэрхэн өсөж хөгжсөнийг гайхах болно.

60 Хөл бөмбөг, ням гараг ба сүнслэг байдлын хувьд элэгдүүлэх нь
Шарлотт Ларкэбэл
Вилл ням гарагт тоглохгүй байвал багт эзлэх байр сууриа алдахад хүрэх үү?

63 Хачин хөрш
Саманта Бэст
Авга ах, эгч хоёр маань намайг хөрштэйгөө ярихыг хориглон айлгадаг байсан. Гэтэл тэр миний амьдралыг аварсан ч байж магадгүй юм.

64 Бидний орон зай



76

66 Гэрлээрээ гэрэлтүүл: Хөнгөн зуушнаасаа хуваалцаж, инээмсэглэл бэлэглэх нь

68 Люсиад өгсөн хариулт
Мурлин Ваткинс
Багийнх нь заасан зүйл Люсиаг барьц алдуулсан ч хэн түүнд ойлгоход нь туслахыг мэдэж байлаа.

70 Гэрлээрээ гэрэлтүүл
Ерөнхийлөгч Томас С.Монсон
Та үлгэр жишээ үзүүлснээр хэрхэн бусдад гэрэл нь байж чадах вэ?

72 Лукас ба дээрэлхүү хүүхэд
Эрик Б.Мердок
Лукас дээрэлхүүлэх дургүй ч зөв зүйл хийсэн үү?

74 Моронай ба засварчин
Ахлагч Клаудио Р.М.Коста
Манай машиныг эвдрэхэд хүү Моронай маань зөв хүн ирж, бидэнд туслаасай хэмээн залбирсан.

75 Би судруудыг уншиж чадна: Надад зориулсан Бурханы төлөвлөгөө

76 Есүсийн тухай түүх: Бүтээлт
Ким Вэбб Рэйд

79 Будах хуудас: Би үзэсгэлэнт дэлхийн нэгээхэн хэсэг

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: Рассэлл М.Нэлсон,
Даллин Х.Сүкс, М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд,
Дэвид А.Баднар, Квинтин Л.Күк, Д.Тодд Кристоффэрсон,
Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон,
Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Хюго И.Мартинэз

Туслах редакторууд: Рэндэлл К.Бэннэтт, Кэрл Ф.Макконки

Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Бонни Х.Кордон, Бага Лигранд
Р.Куртис, Эдуард Дюб, Шэрон Юбанк, Доналд Л.Холлструм,
Даглас Д.Холмэс, Эрих В.Көпишкэ

Удирдах захирал: Питэр Ф.Эванс

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Крэмилида Амарал

Редакцийн баг: Мэрисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид
А.Эвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр, Гаррэт
Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жон Рэйн Жэнсэн, Шарлотт
Ларкэбэл, Майкл Р.Моррис, Салли Жонсон Оджерк, Жошуа
Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Минди Аннэ
Сэлу, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Талл Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй
П.Андрус, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Дэвид Грийн,
Коллийн Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан Лофгрэн,
Скотт М.Моой, Эмили Чизко Рэмингтон, Марк В.Робисон,
Брэд Тизри, К.Никол Вокзорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэй Анн Пэтэрс

Хэвлэх баг: Ира Глэнн Адэйр, Жюли Бардэтт, Томас
Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Дэрж
Ричардсон

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой К.Вэллинг

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон
үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт

liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол “луужин”
буюу “залагч”) албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга,
украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад
(хялбаршуулсан), чех, швед, эстонч, япон хэлээр нийтлэгддэг.
(Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2018 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн тухай мэдээлэл: Өөрөөр заагаагүй
бол хувь хүмүүс Лиахона сэтгүүлээс арилжааны бус, хувьдаа
(мөн Сүмийн дуудлагат ажилд) ашиглах зорилгоор материал
хувиран авч болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй.
Үзүүлэнгийн материалыг хэрэв зураг чимэглэлийн тухайд
ямар нэг хязгаарлалт тогтоосон бол хуулбарлаж болохгүй.
Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар
хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St.,
FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон
шудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

January 2018 Vol. 19 No. 1. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December) by
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is
\$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals
Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required
for change of address. Include address label from a recent issue;
old and new address must be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.


ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО



Liahona.lds.org гэсэн хаягаар
өгүүлүүдийг уншиж мөн
өөрийнхөө түүхийг явуулна уу.



Сүнснэг өдөөлт бүхий захиасуудыг
facebook.com/liahona (англи,
португал, испани хэл дээр
боломжтой) хаягаар орж үзэж,
бусадтай хуваалцана уу.



Санал хүсэлтээ
liahona@ldschurch.org
хаягаар илгээнэ үү.



Store.lds.org-оор захиална уу.
Аль эсвэл хангамжийн
төв дээр очин, тойргийн
удирдагчаасаа асууж лавлан,
1-800-537-5971 (Америкийн
Нэгдсэн Улс болон Канадад)
дугаараар холбогдоно уу.

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Авралын төлөвлөгөө, 32

Айлчлагч багш, 7

Амар амгалан, 12, 24, 41,

50, 52, 53, 54

Ариун сүм, 12, 18, 20

Боловсрол, 44, 48

Бүтээлт, 76, 79, 80

Гэр бүл, 20, 32

Гэрчлэл, 48, 56, 63, 70, 74

Даруу байдал, 24

Дуудлага, 41

Дуулгавартай байдал, 8, 60

Есүс Христ, 24, 56, 66, 68, 75

Залбирал, 8, 40, 42, 43,

68, 70, 74

Залуу эмэгтэйчүүд, 38,

41, 65

Зөвлөлүүд, 28

Институт, 48

Мючелийн сэдэв, 24, 50,

52, 53, 54, 61

Мөнхийн талаас нь харах

үзэл баримтлал, 12

Наманчлал, 4, 38, 72

Номлолын ажил, 12, 40,

44, 63, 64

Сайхан сэтгэл, 72

Судраас судлах, 8, 24,

48, 56, 68, 70

Сүмийн цуглаанууд, 28

Талархал, 8, 20

Үйлчлэл, 7, 20, 44, 66

Үлгэр жишээ, 65, 70,

72Хайр, 7, 32, 40, 63

Хэвлэл мэдээллийн

хэрэгсэл, 65

Хүндэтгэлийн өдөр, 60

Шашны эрх чөлөө, 32



Ерөнхийлөгч
Томас С.Монсон

НАМАНЧЛАЛЫН БЭЛЭГ

“Бидний үүрэг хариуцлага бол дундаж түвшнээс чадварлаг руу, бүтэлгүйтлээс амжилт өөд өгсөх явдал юм. Бидний үүрэг даалгавар бол өөрсдийгөө байж болох хамгийн сайн түвшинд аваачих явдал юм. Бурханы хамгийн агуу бэлгүүдийн нэг бол дахин оролдож үзэх баяр баясгалан билээ. Яагаад гэвэл, бүтэлгүйтэл бол төгсгөл биш” хэмээн ерөнхийлөгч Томас С.Монсон заасан.¹

Бид ихэнхдээ шинэ оны эхлэлийг зоримог шийдвэр, зорилго зорилттой холбож үздэг. Бид сайжран, өөрчлөгдөж, дахин оролдож үзэхээр шийддэг. Бидний дахин оролдоод үзэх хамгийн чухал арга зам бол ерөнхийлөгч Монсоны нэрлэснээр “наманчлалын бэлгийг”² хүлээн авах явдал юм.

Ерөнхийлөгч Монсон Сүмийн ерөнхийлөгч болсноосоо хойш бидэнд “нүглүүддээ өршөөлийг хүлээж авч болохын тулд мөн зүрх сэтгэл маань ариуссан байж болохын тулд Христийн цагаатгагч цусыг нөлөөлүүл”³ гэх зөвлөгөөг өгсөн билээ.

Өршөөлийн гайхамшиг

“Бид бүгдээрээ буруу сонголт хийж байсан. Хэрвээ бид эдгээр сонголтоо засаж залруулаагүй бол гарах арга зам бий хэмээн би та нарт амлаж байна. Энэ үйл явцыг наманчлал гэдэг. Би та нараас алдаагаа залруулахыг гуйж байна. Та нарт болон надад адислагдсан уг бэлгийг хүртээхийн тулд бидний Аврагч нас барсан билээ. Хэдийгээр зам нь хэцүү боловч ‘Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно.’ [Исаиа 1:18]. ‘Их Эзэн, бибээр тэдгээрийг нь

цаашид санах нь үгүй’ гэсэн амлалт бодит юм [С ба Г 58:42]. Мөнх амьдралаа бүү эрсдэлд оруул. Хэрвээ та нар нүгэл үйлдсэн бол үүнээсээ буцан, зөв зам дээрээ гарч ирснээр өршөөлийн гайхамшгаас ирэх амар амгалан, баяр баяслыг мэдрэх болно.”⁴

Зам руугаа буцаж ор

“Бид ухаалаг сонголт хийх шаардлагатай ч бидэнд ухаалаг бус сонголт хийх үе байдаг. Аврагчийн өгсөн наманчлалын бэлэг нь бидний эрэлхийлж буй селестиеал алдар суу руу удирдах тэр зам дээр биднийг эргэн ирж болохын тулд амьдралаа засаж залруулах боломжийг олгодог.”⁵

Буцах зам

“Хэрэв та нарын зарим нь аян замдаа бүдрэн, алдаа гаргасан бол эргэж ирэх зам байгаа гэдгийг би батлан хэлж байна. Энэ үйл явцыг наманчлал гэж нэрлэдэг. Энэ зам хэцүү ч гэлээ, та нарын мөнхийн аврал үүнээс шалтгаалах болно. Үүнээс илүү үнэ цэнтэй зүйл байдаг гэж үү? Би та бүхнээс бүрэн наманчлахад шаардагдах алхмуудыг хийх шийдвэрийг яг энд, одоо гаргахыг гуйж байна. Та нар үүнийг хэдий чинээ хурдан хийнэ, Исаиагийн өгүүлсэн амар амгалан, нам тайван байдал, баталгааг төдий чинээ хурдан авах болно [Исаиа 1:18-ыг үзнэ үү].”⁶

Хүмүүс өөрчлөгдөх боломжтой

“Хүмүүс өөрчлөгдөж чадна гэдгийг бид байнга санаж явах хэрэгтэй. Тэд муу зуршлаа орхиж чадна.



ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Бид бүгдээрээ төгс бус. Гагцхүү Есүс Христийн золиослолоор дамжин боломжтой болсон наманчлалын бэлгээр дамжуулан бид нүглээсээ цэвэршигдэж, амьдралаа сайжруулах боломжтой. Бид наманчлалаар дамжуулан хэрхэн “амьдралаа засаж залруулах” боломжтойг зааж буй хүмүүстэйгээ ярилц. Тэд амьдралдаа гаргасан эерэг өөрчлөлтүүдээр дамжуулан Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй илүү ойртож байгаагаа хэрхэн мэдэрсэн бэ? Та зааж буй хүмүүсээ шинэ оны сүнслэг зоримог шийдвэрүүдээ бичиж тэмдэглэн, өсөлт хөгжлөө найз нөхөд, хань ижил, гэр бүлийнхээ гишүүнд тайлагнахад урьж болно.

Тэд гэм нүглээ наманчилж чадна. Мөн тэд санваараа зохистой авч явж, Их Эзэнд хичээнгүйлэн үйлчилж чадна.”⁷

Дахин цэвэр болох нь


“Хэрвээ та нарын амьдралд ямар нэг буруу зүйл байгаа бол үүнээс гарах арга зам бий. Зөв шударга бус зүйлс хийхээ зогсоо. Бишоптойгоо ярилц. Ямар ч асуудлыг зөв зүйтэй наманчлалаар шийдвэрлэж болно. Та нар эргээд цэвэр болж чадна.”⁸

Аврагчийн зайлшгүй чухал үүрэг

“Бидний Аврагч, Есүс Христ [авралын] төлөвлөгөөний зайлшгүй нэгэн чухал хэсэг билээ. Түүний цагаатгагч золиослолгүйгээр бүх хүн төөрөлдсөн хэвээрээ үлдэх байсан. Зүгээр л Түүнд болон Түүний номлолд итгэх нь хангалтгүй юм. Бид хөдөлмөрлөж, суралцаж, эрэлхийлж мөн залбирч, наманчилж, өсөж хөгжих хэрэгтэй. Бид Бурханы хуулиудыг мэдэж, тэдгээрийн дагуу амьдрах хэрэгтэй. Бид Түүний авралын ёслолуудыг хүлээн авах хэрэгтэй. Бид эдгээрийг хийснээр л жинхэнэ, мөнхийн аз жаргалыг олж авах болно.”⁹ ■

ЭШЛЭЛҮҮД

1. “The Will Within,” *Ensign*, 1987 оны 5-р сар, 68.
2. “Сонголтууд,” 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 69.
3. Мозая 4:2
4. “Гурван сонголт,” 2010 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 72.
5. “Сонголтууд,” 69.
6. “Зарлигуудыг сахь,” 2015 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 70.
7. “Бусдыг ирээдүйд ямар болсон байхаар нь харж сур,” 2012 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 80.
8. “Санваарын хүч,” 2011 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 73.
9. “Аз жаргалд хүргэх төгс зам,” 2016 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 69.



Наманчлах шийдвэр гарга

Хэдийгээр шинэ оны зорилго нь биднийг өөрчлөгдөн сайжрахад тусалж болох ч өөрчлөгдөх хамгийн сайн арга зам бол наманчлал юм.



Мөн [lds.org/go/1186](https://www.lds.org/go/1186) дээрээс "Eight Myths about Repentance"-ийг үзнэ үү.

Ерөнхийлөгч Монсон: "Бидний үүрэг хариуцлага бол дундаж түвшнээс чадварлаг руу, бүтэлгүйтлээс амжилт өөд өгсөх явдал юм. Бидний үүрэг даалгавар бол өөрсдийгөө байж болох хамгийн сайн түвшинд аваачих явдал юм" хэмээн тайлбарласан. Олон хүн нэгдүгээр сарыг илүү их инээмсэглэх, эрүүл хоол идэх юм уу шинэ ур чадвар эзэмших гэх мэт өөрчлөгдөн сайжрах зорилго, зорилт тавихад зориулдаг. Хэдийгээр эдгээр

зорилго таныг өөрчлөгдөн сайжрахад тусалж болох ч өөрчлөгдөх хамгийн сайн арга зам бол наманчлал юм.

Наманчлах нь хэцүү хэдий ч бэлэг билээ. Бид Есүс Христэд найдаж, нүглээ наманчлах юм бол өсөж хөгжих боломжтой. Ерөнхийлөгч Монсон: "Бидний Аврагч, Есүс Христ [авралын] төлөвлөгөөний зайлшгүй нэгэн чухал хэсэг билээ. Түүний цагаатгагч золиослогчгүйгээр бүх хүн төөрөлдсөн хэвээрээ үлдэх байсан" хэмээн хэлсэн.

Та наманчлалаар дамжуулан өөрийн нүглээс цэвэршүүлэгдэж, Түүнтэй адил болон өсөж хөгжих боломжтой.

Та Аврагчтай адилхан болоход саад болж байгаа ямар нэг зүйлийн талаар бод. Таны үг хэл үү? Эсвэл найз нөхөд, гэр бүлийнхэндээ хандаж байгаа хандлага тань уу? Та сайжруулж болох зүйлийнхээ тухай бодсоны дараа Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, өөрчлөгдөх хүсэлтэй байгаагаа илэрхийлээрэй. Есүс Христ Цагаатгалаараа дамжуулан танд сул талаа ялан дийлэхэд тусална гэдгийг бүү март. Ерөнхийлөгч Монсоны зааснаар: "Аврагчийн хангаж өгсөн наманчлалын бэлэг нь бидэнд амьдралаа засаж залруулах боломжийг олгодог."

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Наманчлал бол бэлэг

Наманчлалын бэлэг нь харж, хүрч болдог бэлэг биш. Харин энэ нь мэдэрч болдог бэлэг. Энэ нь бид буруу сонголт хийсэн үедээ наманчилж, амар амгалан, аз жаргалыг дахин мэдэрч чадна гэсэн үг юм.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр үргэлж бидэнд наманчлахад тусална. Зураг бүрийг наманчлалын өөр өөр алхамтай тохируул.

Бид гэмшдэг.

Бид Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, юу болсныг хэлж, дараагийн удаа илүү сайн сонголт хийхэд туслахыг хүсдэг.

Бид уучлал гуйж, сайжрахыг хичээдэг.

Бид амар амгаланг мэдэрч, өршөөгдсөн гэдгээ мэддэг.





Итгэл, гэр бүл, халамж

Түүнтэй ямар ч цаг үед, хаана ч байсан, бүхий л арга замаар холбоотой бай

Айлчлагч багшаар явах нь үйлчиллэл юм. Есүс ямар ч цаг үед, хаана ч байсан үйлчилдэг байсан. Бид бас ингэж үйлчилж чадна.



“Үйлчлэх” гэдэг нь хэн нэгнийг тайтгаруулах юм уу аз жаргалтай болоход нь тус нэмэр болон үйлчилж, асарч халамжлан, тусламж үзүүлэхийг хэлнэ. Харин айлчлагч багшаар явах нь айлчилж очдог хүмүүстээ үйлчлэх арга замыг олох явдал юм. Есүс Христ бүх хүнд ямар ч цаг үед, хаана ч байсан үйлчилдэг байсан. Тэрээр 5000 хүнийг хооллон, Мариа, Марта хоёрын дүүг нас барахад тэднийг тайтгаруулж, худаг дээр тааралдсан эмэгтэйд сайн мэдээгээ заасан. Тэр тэднийг чин сэтгэлээсээ хайрласан учраас энэ бүхнийг хийсэн.

Бид айлчлагч багшийн хувьд Христийн үлгэр жишээг даган, хайр бол бидний хийж буй бүх зүйлийн үндэс суурь гэдгийг санаж байх юм бол айлчилж очдог эгч бүрээ таньж мэдэн, хайрлах болно. Бид тухайн эгчид үйлчилж, итгэлээ хүчирхэгжүүлэхэд нь хэрхэн

тусалж болохоо олж мэдэхийн тулд сүнслэг удирдамж авахаар залбирвал “тэнгэр элчүүд [бидэнтэй] хамтран ажиллахаас татгалзаж чадахгүй.”¹

1842 онд Халамжийн нийгэмлэг анх зохион байгуулагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэл үйлчилсэн эмэгтэйчүүд олон хүний амьдралыг адисалсаар ирсэн. Жишээлбэл, Жоан Жонсон хэмээх 82 настай бэлэвсэн эмэгтэй айлчлагч багшийн хамтрагчтайгаа 89 настай, уушигны хатгаатай хөрш дээрээ очиж, заадаг. Хөршийндөө сард ганцхан удаа очих нь хангалтгүй гэдгийг тэд олж харсан учраас долоо хоног бүр биечлэн уулзах юм уу утсаар биеийг нь асуудаг болсон.

Өөр айлчлагч багш нарын хувьд хариуцсан эгчдээ урмын үгтэй мессеж бичиж, э-мэйл илгээх нь тухайн сардаа хангалттай байж болно. Хувийн

харилцаа тогтоох, хайраар сонсох хандлага нь айлчлагч багшаар явах ажлын мөн чанар юм. Орчин үеийн техник технологи болон цагаа олж нүүр тулан уулзах уулзалт нь бидэнд энэ ажлыг ямар ч цаг үед, хаана ч байсан, өөр олон арга замаар хийхэд тусалдаг.² Харин энэ бол Христтэй адил үйлчилж байгаа хэрэг юм.

ЭШЛЭЛҮҮД

1. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 563.
2. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 9.5.1-ийг үзнэ үү.



Үүнийг эргэцүүлэн бод


Бид “юу хийвэл” айлчлагч багшаар явсанд тооцох бол гэдэгт санаагаа чилээхийн оронд айлчилж очих эгч нэг бүрд юу хэрэгтэй байна вэ гэдэгт хэрхэн анхаарлаа хандуулж сурах вэ?

Үйлчлэх нь

Энэ хуудсан дээр сар бүрийн тодорхой захиас бичгийн оронд бидэнд нэг нэгэндээ үр дүнтэй үйлчлэхэд туслах өөр өөр зарчмыг танилцуулж байх болно. Та сүнслэг удирдамж эрэлхийлэн залбирвал эгч нэг бүрд хэрэгтэй сүнслэг захиас, үйлчлэлийг олж мэднэ.

Генератор хөдөлгүүртэй холбогддог ба автомашиныг хэвийн ажиллагаатай байлгахад чухал.

Генератор нь механик энергийг тогтмол гүйдлийн цахилгаан энерги болгон хувиргагч эх үүсвэр юм.



Генератороо засварлах эсвэл солихоос нааш аяллаа үргэлжүүлэх боломжгүй байв.





Далын
Ахлагч
В.Марк Бассэтт

Харж, амьдар

*Бид Бурхан руу эргэхдээ
сүнсээ шинэчлэх байнгын
эх сурвалжийг бий
болгодог.*

Намайг бага байхад гэр бүл маань АНУ-ын Хойд Калифорнигоос Юта руу машинаар байнга аялдаг байсан. Бид элсэн цөлөөр аялахдаа биш, харин зорьсон газраа хүрч, тэнд байгаа гэр бүлийн гишүүд дээрээ зочлох дуртай байсан юм.

Бүрэн цагийн номлолд гарахын өмнөх зун би дахин нэг удаа Ютад байдаг хамаатнууд дээрээ зочлохоор аялсан. Тэр удаад би Дэвид дүүтэйгээ хоёулхнаа аялах болсон бөгөөд бид 16, 18 настай байлаа. Бид гэр бүлийнхэнтэйгээ 10 цагийн аяллыг байсхийгээд л хийчихдэг байсан болохоор дажгүй аялж чадна гэдэгтээ үнэхээр итгэлтэй байсан.

Бид авга ах Кэй, авга эгч Дайан, үеэл Мишээл нар дээр зочлон очсон юм. Дэвид тэнд байх хугацаагаа сунгасан ба би шүдний эмчид үзүүлэхээр Калифорни руу ганцаараа буцаж явах ёстой болов.

Намайг Ютагийн Спаниш Форкоос гараад, машинаар явах шөнийн аяллаа эхлэх үед бүрэнхий болж байлаа. Бүх зүйл эхэндээ сайн байсан бөгөөд би өмнөд, хойд зүг рүү явдаг гол замаас гараад, баруун, зүүн зүг рүү явах зам руу оров. Урд гэрлээ асаагаад, Ютагийн баруун хэсэг рүү яаран замдаа гарлаа. Километрийн заалт нэмэгдсээр, элсэн цөлд шөнө харанхуй болох тусам урдах замаа харахад улам бүр бэрхшээлтэй болж байгааг ажиглав. Эцэст нь, би урд гэрэл маань улам сүүмийж байгааг ойлгосон юм. Гэрэл унтарч, хөдөлгүүр зогсон, машин маань гол замын хажууд зогсох нь тэр.

Аккумулятор нурсан байлаа. Машин цаашаа явах боломжгүй боллоо. Би хангалттай түлш хийж, хаана

зогсож шатахуун авахаа анхааралтай тооцоолсон байсан ч цахилгаан нь таг унтарна гэдэгт бэлтгэлгүй байв.

Генератор гэж юу вэ?

Гэр бүлийнхээ машиныг засаж янзалдаг хэмээн өөрөөрөө бахархдаг аав маань намайг өсгөж хүмүүжүүлсэн юм. Тэр бидэнд автомашины механикийн талаар заадаг байсан учраас генераторт асуудал үүсээгүй л бол хөдөлж байгаа машины хэвийн ажиллагаатай аккумулятор хэзээ ч нурахгүй гэдгийг би мэддэг байлаа. Генератор нь хөдөлгүүрээс гарсан механик энергийг цахилгаан энерги болгон хувиргах зориулалттай автомашины цахилгаан энергийн үндсэн эх үүсвэр юм. Энэ нь ажиллаж буй хөдөлгүүрийн кинетик энергийг ашиглан, аккумуляторын батерейг цэнэглэх цахилгаан болдог соронзон энергийг үүсгэдэг. Энэ нь урд гэрэл, радио, агааржуулагч, бусад цахилгаан хэрэгслийг доголдолгүй ажиллах боломжтой болгодог. Энэ нь мөн хөдөлгүүрийг хэвийн ажиллуулдаг.

Одоо харин машинд маань ямар нэгэн асуудал үүсчээд байв. Аяллаа үргэлжлүүлэхээс өмнө үүнийг засварлах эсвэл солих хэрэгтэй байлаа.

Гар утас гараагүй байсан болохоор надад алхаж явах л сонголт байв. Эцэст нь, нэгэн эрэгтэй намайг машиндаа суулгаад, зэргэлдээх хотод хүргэж өгсөн юм. Би ачигч машин дуудахаар төлбөртэй утас ашиглав. Би машин руугаа буцахаар нэг цаг аялахдаа жолоочтой хамт бүхээгт нь сууж явсан бөгөөд машинаа ачуулаад, уг жижигхэн хот руу буцахдаа бас хамт явав. Дөрвөн

цагийн дараа л би авто засварын газарт ирж, онгойхыг нь хүлээнгээ машин дотроо орж унтах боломжтой болсон юм.

Менежер нь ирээд, жижигхэн хотод нь хэрэгтэй зүйлээ байгаа гэж бодсоныг минь шоолон инээв. Тэр захиалж болох ч хоёр эсвэл гурван өдрийн дараа л ирнэ гэж хэлэв. Дараа нь тэр намайг өрөвдөн, аккумуляторыг маань гурван цаг цэнэгээ барихаар цэнэглээд өгч болно гэж хэлсэн бөгөөд энэ нь дараагийн хот хүртэл хангалттай хүрэхээр байв. Тэнд надад хэрэгтэй зүйл байж магадгүй.

Би аккумулятороо цэнэглээд, үнэ цэнтэй цахилгааныг маань дэмий үрэх ямар ч зүйлийг асаалгүйгээр хөдөллөө. Дараагийн хотод очсон ч хэрэгтэй зүйл минь байсангүй. Гурван цаг цэнэглээд, дараа дараагийн хот хүртэл хоёр цаг жолоодно гэх мэтээр аялал үргэлжлэсээр байв. Замд тааралдсан сайн санаат хүмүүсийн ачаар би 30 цагийн дараа л ядарч зүдэрсэн ч аюул осолгүй эцэг эхийнхээ гэрт ирсэн юм.

Сүнслэг талх

Миний аялал Хуучин Гэрээний үеийн израильчуудын элсэн цөл дэх аялалтай төстэй байв. Израильчууд 40 жилийн турш *талх* хэмээх тэнгэрийн хоолоор тэжээлгэсэн. (Египетээс гарсан нь 16-р бүлэг, Тооллого 11-р бүлгийг үзнэ үү.)

Бидэнд ч бас сүнслэг хоол тэжээл буюу тэнгэрийн хоол хэрэгтэй. Аз болж, бид хэрэгтэй “сүнслэг талхыг” маань “авчрах” “сүнслэг генераторыг” бүтээж чадна. Тэнгэр дэх Эцэг, Түүний Хүү Есүс Христтэй харилцах харилцаагаа хадгалснаар бидний сүнслэг хэрэгцээ хангагддаг учраас израильчууд бие махбодын талхыг цуглуулах гэж өдөр бүр цаг гаргадаг байсантай адил өнөөдөр бид залбирч, сайн мэдээг судлан, Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг эрэлхийлснээр сүнслэг маннаг цуглуулах ёстой.

Эцэст нь, израильчууд бие махбодын талхаа цуглуулахаас залхаж, ардаа орхисон зүйлстээ “шунахайрсан” (Тооллого 11:4) юм. Хэрэв бид сүнслэг талхаа цуглуулахаас залхаж эхэлбэл сүнслэг ашиг сонирхолд маань нийцэхгүй зүйлсийг хүсэж эхэлж магадгүй. Бид уурлаж бухимдсан израильчуудтай адил амлагдсан нутагт хүрэх гол зорилгоо мартаж эрсдэлд орно. Бид өөрсдийн

“Египетийг” (Тооллого 11:5–6) орхиогүй байсан ч харамсаж магадгүй. Эцэст нь, бидний сүнслэг генератор ажиллахаа больж, аянаа урагш үргэлжлүүлэх боломжгүй болно. Бид ядуурч хоосрон, өлсөж цанган, аврал эрэх болно.

Гайхамшигийг харах нь

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) “Заримдаа бид судруудтай байгаа нь хэчнээн онцгой зүйл болохыг мөн хэчнээн их адислал болохыг ойлгож, талархдаггүй болохоор судруудад хэт хайнга ханддаг юм шиг санагддаг. Бид энэ дэлхийн туршлагауудаа дасаж, бидэнд заагдаж буй сайн мэдээг сонссоор байгаад дасал болсон тул сайн мэдээ байгаагүй бол ямар байхыг төсөөлж ч чадахаа больсон юм шиг санагддаг” хэмээн заажээ.¹

Судрыг тууштай судлах, залбирах, дуулгавартай байх хэрэгцээгээ хэзээ ч дутуу үнэлж болохгүй. Учир нь эдгээр нь Ариун Сүнсний нөхөрлөлийг хадгалахад бидэнд тусалдаг. Хэрэв бид амьдралынхаа сүнслэгээр цэнэглэх үйл ажиллагаануудыг үл тоомсорлож, залхан, зүгээр л автоматаар хийдэг болчихвол сүнслэг генератор маань бүрэн ажиллахгүй. Бид аажим аажмаар сүнслэг хүчээ алдаж, эцэст нь байгаа үгүй нь ч мэдэхгүй болно. Ийм цаг үед эдгэрэх цорын ганц арга бол Есүс Христ рүү эргэж, наманчлах явдал юм. Есүс Христийн



Цагаатгал, чин сэтгэлийн наманчлалаар дамжуулан бүх зүйл сэргээгдэх боломжтой.

Харж, амьдар

Израильчууд гомдоллож эхэлснээр хоол тэжээлдээ талархахаа больсон. Шийтгэл болгож, “ЭЗЭН ард түмний дунд галт могойнуудыг илгээхэд, тэд ард олныг хатгажээ. Ингэснээр Израилийн олон хүн үхэв” (Тооллого 21:6).

Эцэст нь “ард түмэн Мосе уруу ирж—Бид ЭЗЭН болон таны эсрэг ярьснаас болж нүглийг үйлдэв. Биднээс могойнуудыг зайлуулахаар ЭЗЭНд зуучлан залбираач гэв. Мосе ард олны төлөө зуучлан залбирав.

Тэгтэл ЭЗЭН Мосед—Галт могой хийж, түүнийг шургаагны оройд байрлуулагтун. Тэгвэл хатгуулсан хүн бүр түүнийг хараад амьдрах болно гэв.

Мосе хүрэл могойг хийж, түүнийг шургаагны оройд байрлуулав. Хэрвээ хэн нэгэн хүнийг могой хатгасан байвал, тэр хүн хүрэл могойг хараад амьдарч байлаа” (Тооллого 21:7–9).

Орчин үеийн хүрэл могой

Хүрэл могой нь загалмайд өргөгдсөн Христийн бэлгэ тэмдэг юм (Иохан 3:14–15-ыг үзнэ үү). Бид орчин үеийн бошиглогчдын зөвлөгөөг анхааран сонссоноор Христ рүү хардаг. Учир нь тэдгээр нь бидний анхаарлыг Эцэгийн төлөвлөгөө рүү болон Есүс Христийн гол үүрэг рүү хандуулдаг. Надад аккумулятороо цэнэглэх боломж олгосон сайн санаат хүмүүстэй адил амьд бошиглогч, үзмэрч, илчлэгчид нь биднийг Тэнгэр дэх Эцэгийн хүүхдүүд гэдгийг мөн Түүний ажил, алдар суу нь “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Мосе 1:39) явдал юм гэдгийг сануулснаар биднийг сүнслэгээр цэнэглэдэг. Тэд хүндэтгэлийн өдөр илүү үр дүнтэй шүтэн биширснээр Тэнгэрлэг Эцэгт болон Түүний аз жаргалын төлөвлөгөөнд мөн Есүс Христ, Түүний Цагаатгалд итгэх итгэлээ өсгөнө гэсэн тодорхой зөвлөгөөг бидэнд өгдөг.

Мосегийн болон хүрэл могойн түүхийг Мормоны Номонд бас дурдсан байдаг бөгөөд тэнд “олон нь харж мөн амьдрал” (Алма 33:19; мөн 20–22-р шүлгүүдийг үзнэ үү) гэж хэлсэн байдаг. Гэвч бусад нь харахаас татгалзсан



юм. “Тэдний гүйцэлдүүлэх ёстой ажил нь харах байв; мөн уг замын энгийн байдал эсвэл үүний амархны учир тэдгээрээс эрсэдсэн нь олон байв” (1 Нифай 17:41). Биднийг уг зам амархан учир бошиглогчдыг болон тэдний зөвлөгөөг эсэргүүцсэн гэж хэзээ нэгэн өдөр ярих болов уу?

“Хэрэв та нар эдгээгдэж болохын тулд зөвхөн харц чулуудсанаар эдгээгдэж болдог бол, та нар хурдхан болгоохгүй гэж үү? . . .

. . . Тэгвэл харц чулуудан мөн Бурханы Хүүд . . . итгэж эхлэгтүн” (Алма 33:21, 22).

Биднийг “тэнгэрт хүргэх гол замаар” аяллаа үргэлжүүлэн, бусдыг мөн адил үйлдэхэд урамшуулан дэмжих үед ирдэг адислалуудад би талархдаг. Мөн би замаасаа хазайсан үедээ наманчилж, муу зуршлаа хаян, зөв замдаа эргэж орох боломжтой байгаадаа талархаж байна. Эдгээр адислал бол хэмжигдэшгүй билээ.

Израильчуудын уг туршлагын талаар дурдсан Мормоны Номын өөр нэгэн хэсэг “тэрхүү могойг харсан болгон амьдрах байсны адил, тэрчлэн Бурханы Хүүт итгэлтэйгээр мөн гэмшсэн сэтгэлтэйгээр харсан болгон, бүр мөнхийн болох тэрхүү амьдралаар амьдарч болох бөлгөө” (Хиламан 8:15) гэж төгсдөг.

Орчин үеийн бошиглогчдын зөвлөгөөг анхааран сонсох нь биднийг итгэлтэй байхад сургадаг. Би тэр орой цөлд урагшлах ёстой байсантай адил энэ нь бидэнд аялынхаа сорилт бэрхшээлийг давж гарах хүч чадлыг өгдөг. Бид Тэнгэр дэх Эцэг болон Түүний Хүү рүү харснаар аялаасаа утга учир, зорилго чиглэлийг олно гэдгийг би гэрчилж байна. ■

Та нар энэ өгүүллийн талаарх гэр бүлийн үдшийн санаануудыг lds.org/go/11811-ээс олж болно.

ЭШЛЭЛ

1. *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 61.



Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч
Жийн Б.Бингам

Ариун сүм биднийг илүү

*үн алсын
хараатай
болдог*

Бид залуухан эцэг эх байхдаа Америкийн Нэгдсэн Улсын баруун төв хэсэгт амьдардаг байсан бөгөөд Вашингтон Ди Сигийн ариун сүмд жил бүр очдог байсан маань бидэнд хамгийн тод томруун үлдсэн чухал дурсамж юм. Энэ нь Миссисиппи мөрнөөс зүүн зүгт орших цорын ганц үйл ажиллагаагаа явуулдаг ариун сүм байв. Ариун сүмийн ёслолууд Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдэд нэн чухал гэдгийг мэддэг байсан нь бидэнд хичээл зүтгэл гаргах хэрэгтэй гэсэн мэдрэмжийг төрүүлдэг байлаа.

Та нарын олонхын адил бид бага насны хүүхдүүдээ найз нөхдийнхөө асрамжинд үлдээж, автобус дүүрэн гишүүдтэйгээ хамт шөнийн цагаар аялдаг байв. Эрдэнэ мэт үнэтэй хоёрхон өдрийн дотор бид аль болох ариун сүмийн олон ёслолыг гүйцэтгэж, ням гараг гэхэд ариун ёслолдоо амжиж суухын тулд шөнөжин автобусаараа давхсаар гэртээ буцаж ирдэг байсан юм. Эдгээр аялал бидэнд золиослол шиг санагддаггүй байв. Яагаад гэвэл, бид аяллын дараачийн саруудад бодгалиа тэжээн тэтгэх сүнслэг урам зоригийг тэндээс авдаг байсан учраас энэ нь бидний хувьд үнэ цэнтэй байсан юм.

Үүнээс хойш хэдэн жилийн дараа Канадын Албертагийн Кардстон ариун сүм баригдсанаас хойш Хойд Америкийн төв хэсэгт 62 жилийн дараа баригдсан анхны ариун сүм болох Иллинойн Чикаго ариун сүмийг хүлээн авсандаа бид ихэд баярлаж билээ. Гэрээсээ гараад дөнгөж 45 минут явах газарт ариун сүмтэй болсноор жилд нэгээс олон удаа очиж, сүнслэг хоолоо тогтмол хүртэх боломжтой болсон нь бидний хувьд аз жаргал байв.

Гэвч өнөөдөр бидний зарим нь ариун сүмд үүнээс илүү ойрхон амьдардаг ч тогтмол очдоггүй хэвээр. Ариун сүмд ямар ч асуудалгүй очих боломжтой байгаа нь биднийг “Маргааш цаг зав гарвал очно” хэмээн бодож, өөрсдийгөө тайвшруулахад хүргэдэг бололтой. Тухайн нөхцөл байдалд үүссэн дарамтад сатааран, үүнээс ч илүү чухал боломжоо алдахад тун амархан. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г. Скотт

Зүүн гар талд:
Коннектикутын
Хартфорд
ариун сүмийн
селестиел өрөө

Колумб мужийн Вашингтон
ариун сүм 288 тохой
(88 м) өндөр буюу хамгийн
өндөр ариун сүм юм.





*Ариун сүм нь бидний
нүдэнд үл үзэгдэх одод
руу чиглэсэн дуран
авайн адил илүү гүн,
илүү өргөн хүрээг
хамарсан алсын
харааг оюун ухаанд
маань нээж өгдөг.*



Дээд талд: Аризонагийн
Гилбэрт ариун сүмийн
өнгөт шилэн цонх; Прово
Ситигийн Төв ариун
сүмийн хаалга, цонхнууд;
Солт Лэйкийн ариун
сүмийн хаалганы бариул

Ар талд: Украйны
Киев ариун сүмийн
селестиел өрөө



Германы Фрайбэрг ариун
сүмийн өнгөт шилэн цонхнууд



Миссуригийн Канзас
Ситигийн ариун сүм



(1928–2015) “Би та нарыг ариун сүмийн ёслолуудад байнга оролцох хувийн зорилго тавихад уриалж байна”¹ хэмээн хэлсэн.

Бид ариун сүм рүү бололцооныхоо хэрээр аль болох ойр ойрхон очих боломжоо ашиглахгүй мөн гэрийнхээ яг дэргэд байх ариун сүмд очих боломжиндоо тоомжиргүй хандах юм бол бидний Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүүгийн бидэнд бэлдсэн адислал, боломжийг алдана гэхэд хилсдэхгүй болов уу. “Миний хэлснийг та нар хийхэд Их Эзэн бибээр үүрэг хүлээдэг; гэвч миний хэлснийг та нар үл хийхэд та нарт амлаалт байх нь үгүй” (С ба Г 82:10).

Хоорондоо үгссэн юм шиг л ажил төрөл ундарсаар биднийг ариун сүм рүү явуулахгүй байвал Есүс Христ “Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан” (Иохан 16:33) хэмээн хэлснийг санаарай. Бидэнд саад бэрхшээл тулгарсан ч цөхрөхгүйгээр ариун сүмд очих юм бол *бид* амьдарч буй дэлхийгээ ялан дийлэх тусламжийг Аврагчаас хүлээн авна. Нөхөр бид хоёр нэг удаа ариун сүм рүү явахаар бэлдэж байтал асуудлууд ар араасаа гарч ирсэн юм. Эцэст нь бид яг хаалгаар гарахдаа “ам зөрчихөв”. Бид хоёр машиндаа дуугаа хураан суухад том охин маань дүүдээ “Битгий санаа зов. Тэд ариун сүмээс гэртээ үргэлж аз жаргалтай ирдэг шүү дээ” гэж тайвшруулан хэлэхийг сонсож билээ. Түүний үг үнэн байлаа!

Ариун сүм бидэнд мөнхийн цаг хугацаа гэж юу болохыг сануулдаг

Бид ариун сүмд баяр хөөртэй ирж байна уу эсвэл уйтгар гунигтай ирж байна уу гэдгээс үл шалтгаалан энэ нь сэтгэл зүрхээ нээсэн зохистой гишүүн *бур* урам зориг авч, хүчирхэгжиж болох газар юм.

Би хэцүү нөхцөлд орсон хайртай хүнийг маань адисалсанд гүнээ талархаж, бараг л хөл газар хүрэхгүй ариун сүмд ирж байсан удаатай. Бас алдаа гаргасандаа

Зүүн талаас: Иосеф Смит, Хайрум Смит нарын амь наснаа алдсаны 158 жилийн ойгоор онцгойлон адисалсан Иллинойсийн Науву ариун сүмийн шат; Айдахогийн Айдахо Фоллс ариун сүмийн цэцэрлэгт өрөө; Коннектикутийн Хартфорд ариун сүмийн дотоод засал чимэглэл (ар талд)



гүнээ гашуудан, олон ч удаа нулимс дуслуулан сууж байсан. Би өөр хүнд мөнхөд өсөж хөгжих боломж олгохын тулд өмнөөс нь ёслолуудыг хүлээн авч, үйлчлэл хийж байхдаа сүнслэг удирдамж, заавар авч, тэр байтугай зэмлүүлж ч байсан. Эдгээр туршлага бүгд надад урам зориг өгөн, хүчирхэгжүүлж байсан билээ. Тийм ээ, би “үүрэгт ажил” хэмээн, зүгээр л хүлээсэн үүргээ биелүүлэх гэж ариун сүмд олон цаг сууж байсан удаатай. Тэр ч байтугай өглөөний семинарын багшаар үйлчилж байсан жилүүдээ ариун сүмийн цугларалтын үеэр зүүрмэглэдэг байсан! Гэхдээ ариун сүмд очих болгондоо би адислагддаг байв. Гаргасан хүчин чармайлтыг минь тэр даруй эсвээс дараа нь адисалсан гэдгээс үл хамааран ариун сүмд зарцуулсан цаг мөч бүрийнхээ үр дүнд бид хувь хүнийхээ хувьд ямар нэгэн байдлаар өсөж хөгждөг.

Ариун сүмд байх нь өвөг дээдэс рүүгээ эргэн харж, үр хүүхдүүдтэйгээ урагш харах замаар бидэнд мөнхийн цаг хугацаа гэж юу болох талаар сануулдаг. Хүүхдүүд маань ариун сүмд анхаарлаа хандуулсан нь тэдний мөнхийн алсын харааг ч мөн адил бэхжүүлсэн. Бид тэднийг ариун сүмд ороход буюу мөнхийн өсөлт хөгжилд хүргэх нэн чухал алхмыг хийхэд нь хэрхэн бэлдэх вэ? Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “эцэг эхчүүд хүүхдүүдээ ариун сүмийн ач холбогдлыг эртнээс зааж эхлэх ёстой”² гэж зөвлөсөн. Харин ерөнхийлөгч Спенсэр В.Кимбалл (1895–1985) эцэг эхчүүд хүүхдүүдээ өдөр бүр ариун сүмийг сануулан, салшгүй нэг хэсэг болтол нь ариун сүмийн зургийг өрөөнд нь тавихыг³ зөвлөсөн юм. Та бас ариун сүмд очсоноор хүлээн авсан адислалуудаа мөн тэдэнтэй мөнхийн

харилцаанд орохыг тэсэн ядан хүлээхийн баяр баясгалангийн талаарх гэрчлэлээ хүүхдүүдтэйгээ хуваалцаж болно. Та өсвөр үеийнхнийхээ нас барагсдын төлөө баптисм хийх гэсэн хүслийг урамшуулан дэмжих ёстой. Гэр бүлийн үдшийн хичээл, зааж сургах цаг мөчүүдээ “Ариун сүм бол Сүм дэх бүхий л үйл ажиллагаа, хичээл, аливаа дэвшилтэт алхмын зорилт юм”⁴ гэдгийг бүү мартаарай.


Та хүүхдүүдтэйгээ “Би ариун сүм харах дуртай. Нэгэн цагт тэнд орно. Эцэгтэйгээ гэрээнд орж, дуулгавартай байхаа амална”⁵ хэмээн дуулахдаа Их Эзэний ариун өргөөнд орох хүсэлтэй болоход нь туслах юм. Мөн зүрх сэтгэл тань Тэнгэрлэг Эцэгт болон Түүний авралын төлөвлөгөөнд мөн Аврагчид болон хайртай хүмүүстэйгээ мөнхөд хамт байх боломжийг олгосон Түүний Цагаатгалд талархах талархлаар дүүрнэ. Аврагч бол “энэ амьдралд аз жаргал руу хөтлөх зам бөгөөд ирэх ертөнцөд мөнх амьдрал руу хөтлөх жим юм.”⁶ Харин тэр зам ариун сүм рүү хөтөлж, ариун сүмээр дамждаг.

Ариун сүм бол дэлхийнхнээс хоргодох байр болой

Дэлхийнхний нөлөө биднийг ариун сүмээс холдуулж болно. Миний хайртай нэг найзыг Сүмийн талаар интернэтээс уншсан үзэл бодол, таамаглал нь зовоож байв. Тэр уг асуудлаа шийдэхээс нааш ариун сүмд очихгүй байхаар шийдсэн. Би гэрчлэлд нь нөлөөлөх асуулт гарч ирсэн байж болох хүмүүсийг амар амгаланг авчрах хариулыг олох хүртлээ үргэлжлүүлэн хувиараа залбирч, судраас судлан, ариун сүмд очоорой хэмээн зүрх сэтгэлийнхээ угаас гуйж байна. Ухаалаг хэдий ч худал хуурмаг үзэл санаанд

Зүүн гар талд: Европд баригдсан анхны ариун сүм болох Швейцарийн Берн ариун сүмийг 1955 онд онцгойлон адислахад оролцсон ерөнхийлөгч Давид О.Маккэй, Эмма Маккэй эгч нар болон Сүмийн бусад удирдагч.

Доод талд: Вайомингийн Стар Валли ариун сүмийн өнгөт шилэн цонх




Үйл ажиллагаагаа явуулж байгаа 156 дахь ариун сүм болох Францын Парис ариун сүмийг 2017 оны 5-р сарын 21-нд онцгойлон адисалсан.

Доод талд: Вайомингийн Стар Валли ариун сүмийн өнгөт шилэн цонх



Баруун гар талд: Тахитигийн Папээт ариун сүм; Флоридагийн Форт Лаудердэйл ариун сүм; Коннектикутийн Хартфорд ариун сүмийн дотоод засал чимэглэл

Доор, зүүн гар талд: Хамгийн жижигхэн ариун сүм бол Мексикийн Хуарез суурингийн Чихуахуа ариун сүм юм.



автахгүй байхын тулд сайн мэдээнд анхаарлаа төвлөрүүлээрэй. Хүн биеийн өвчин зовлонгоос ангижрахын тулд хөл бөмбөгийн од тоглогчоос эмчилгээний талаар зөвлөгөө авдаггүйн адил чухал сүнслэг асуултын зөв шийдлийг Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаар хомсхон ойлголттой хүнээс олох боломжгүй. “Бүх зүйлийн үнэнийг” (Моронай 10:5) гэрчилдэг Ариун Сүнс мөнхийн үнэн гэж юу болохыг “оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь чамд ярих болно” (С ба Г 8:2).

Уг Сүнсийг хүчтэй мэдэрч болох газрын нэг бол ариун сүм юм. Хэрэв та Их Эзэний өргөөнд орох зохистой бол (өөрөө болон бишоп тань ийнхүү тодорхойлсон бол) асуултаа сэтгэлдээ тээн, яг одоо бүх зүйлийг мэдэхгүй байгаа ч Их Эзэн мэдэж байгаа гэсэн итгэлийг олж авахаар ариун сүмд ирээрэй. Та мэддэг, ойлгодог зүйлээ санаарай. Таны мэддэг, сүнслэг гэрчийг хүлээн авсан зүйл “Бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх сэтгэл, санаа бодлыг хамгаална” (Филиппой 4:7). Тэнгэрлэг Эцэг тань үнэн рүү чиглүүлж, хөтөлнө гэдэгт үргэлжлүүлэн итгэх юм бол эрэлхийлж буй ойлголт, амар амгалан тань ирнэ гэдгийг би гэрчилж байна.

Ариун сүм бол “шуурганаас. . . хамгаалах хоргодох газар” (Исаиа 4:6) гэдгийг Исаиа бидэнд сануулсан. Ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн дараах үгс мөн адил урам зориг өгдөг. Тэрээр “Бид ариун сүмийн хаалгаар орох үедээ дэлхийн анхаарал сарниулагч зүйлс, төөрөгдлийг ардаа үлдээдэг. Энэхүү ариун нандин газар бид үзэсгэлэн гоо, эмх цэгцийг олж хардаг. Тэнд бид бодгальдаа амар амгаланг авч, амьдралынхаа санаа сэтгэлийн зовиураас

түр зуур амсхийдэг билээ”⁷ хэмээсэн.

Дэлхий дээрх асуудлууд улам бүр өсөн нэмэгдэж, өдөр тутмын амьдралын дарамт ихсэх тусам бид жинхэнэ чухал зүйлсэд анхаарлаа төвлөрүүлэх ёстой. Бичил дуран авайгаар бүтэлгүйтэл, асуудлаа томруулж харах мэт сөрөг зүйлс болон дэлхийн зовлон зүдгүүрт анхаарлаа хандуулах амархан. Ариун сүмд байх нь мөнхийн алсын хараанаасаа салахгүй байхыг бидэнд сануулдаг. Мөн энэ нь бидний нүдэнд үл харагдах одод өөд чиглэсэн асар том дуран авайн адил илүү гүн, илүү өргөн хүрээг хамарсан алсын харааг оюун ухаанд маань нээж өгдөг. Энэ нь бидэнд харах, найдах мөн Тэнгэрлэг Эцэгийн хүсдэг тийм хүн болохын тулд ажиллах боломжийг өгдөг. Түүнчлэн энэ нь биднийг хайрладаг, бидэнд туслахыг хүсдэг Тэнгэрлэг Эцэг, эх болон Тэдний хүүхдүүдийн хувьд бидний жинхэнэ үнэ цэн юу болох, бид “Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христийн хамтран залгамжлагчид” (Ром 8:17) болох чадавхтай гэсэн мөнхийн үнэн дээр анхаарлаа төвлөрүүлэхэд тусалдаг. Ариун сүмд Бурханы төлөвлөгөө заагдаж, мөнхийн гэрээ хийгддэг. Тэнд бидэнд хамгийн дээд, мөнхийн чадавхдаа хүрэх арга хэрэгслийг өгдөг.

Ерөнхийлөгч Монсон: “Биднийг ариун сүмд очиход хүмүүний зүрх сэтгэлд төрж болох аливаа мэдрэмжээс хавьгүй хол давсан сүнслэг байдлын цар хүрээ, амар амгалангийн мэдрэмж бидэн рүү ирдэг. Бид ‘Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. . . . Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай’ [Иохан 14:27] хэмээн Аврагчийн хэлсэн үгийн үнэн утга учрыг ухааран ойлгох болно”⁸ хэмээн зөвлөсөн билээ.



Таны ариун сүмд хийсэн үйлчлэл бусдад нөлөөлнө

Ариун сүмийн үйлчлэлээрээ авчирсан сүнс тань таны хүрээлэлд байх таних танихгүй олон хүнд нөлөөлнө. Вашингтон Ди Си ариун сүмд орчихоод, автобусаар олон бээрийн тэртээх гэр рүүгээ буцаж явахдаа бидний хэсэг гишүүн гэрчлэлээ хуваалцсан юм. Оролцогчид нэг нэгээрээ ариун сүмийн шууд болон мөнхийн адислалд баярлаж, талархаж явдага илэрхийлэв. Эцэст нь манай гишүүн бус жолоочийн тэвчээр барагдсан бололтой чанга яригчаа барьж аваад, бидэнтэй хамт байгаадаа талархаж байгаагаа илэрхийллээ. Дараа нь тэр “Та нарт юу байгааг би сайн мэдэхгүй л дээ. Гэхдээ энд арай өөр уур амьсгал байгааг би мэдэрч байна” гэж хэлсэн. Мэдээж, манай тойргийн номлолын удирдагч түүнтэй холбоо барих мэдээллийг авч, дараа нь номлогчдоод өгсөн.

Би та бүхнийг ариун сүмтэй ойрхон байх энэ бэлгээ боломжийнхоо хэрээр, ойр ойрхон ашиглаж байгаарай хэмээн урьж байна. Их Эзэн дэлхийн гэрэл, амь, найдвар учраас та Түүний өргөөнд хүчирхэгжиж, амар амгаланг олох болно. Амлагдсан ёсоор Их Эзэний эргэн ирэх цаг дөхөх тусам хожмын өдрүүдэд та Түүний гэрлийг хүлээн авч, ариун сүмд нь өгөгддөг итгэл найдварыг мэдрэх болтугай. ■


ЭШЛЭЛҮҮД

1. Ричард Г. Скотт, “Ариун сүмийн шүтлэг нь тусламж хэрэгтэй үед тамир тэнхээ, хүч боломжийг олох эх сурвалж мөн,” *2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 48–50.
2. Рассэлл М. Нэлсон, “Prepare for Blessings of the Temple,” *Ensign*, 2002 оны 3-р сар, 17.
3. *The Teachings of Spencer W. Kimball* (1982), 301-ийг үзнэ үү.
4. Рассэлл М. Нэлсон, “Prepare for Blessings of the Temple,” 17.
5. “I Love to See the Temple,” *Children’s Songbook*, 95.
6. “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл,” *Лиакхона*, 2000 оны 4-р сар, 2.
7. Томас С. Монсон, “Ариун сүмийн адислалууд,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 77.
8. Томас С. Монсон, “Ариун сүмийн адислалууд,” 77–78.
9. Томас С. Монсон, “Ариун сүмийн адислалууд,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 79; онцлон тэмдэглэлт нэмсэн.
10. “Excerpts from Recent Addresses of President Gordon B. Hinckley,” *Ensign*, 1997 оны 7-р сар, 73; онцлон тэмдэглэлт нэмсэн.
11. Ричард Г. Скотт, “Receive the Temple Blessings,” *Ensign*, 1999 оны 5-р сар, 26; онцлон тэмдэглэлт нэмсэн.

ТОДОРХОЙ АМЛАЛТУУД

Бишиглогч, төлөөлөгчид ариун сүмд очдог хүмүүст тодорхой амлалтууд өгсөн. “Бурхан Түүний хэлснийг бид хийхэд Тэрээр үүрэг хүлээдэг, гэвч Түүний хэлснийг хийхгүй бол бидэнд амлалт байх нь үгүй” (С ба Г 82:10-ыг үзнэ үү) гэдгийг санаарай.

- Ерөнхийлөгч Томас С. Монсон: “Бид ариун өргөөнд очиж, тэнд хийсэн гэрээнүүдээ санаснаар, аливаа зовлон зүдгүүр, уруу таталт бүрийг даван туулах хүч чадалтай байх болно”⁹ хэмээн амласан.
- Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли (1910–2008) “Хэрэв та нар Их Эзэний өргөөнд орж байх юм бол адислагдаж, амьдрал тань илүү сайн сайхан байх болно. . . Их Эзэний өргөөнд очих гайхалтай боломжийг өөртөө олгосноор тэндээс хүлээн авч болох бүхий л гайхамшигт адислалуудаас хүртэцгээгээрэй”¹⁰ хэмээн амласан.
- Ахлагч Ричард Г. Скотт: “[Ариун сүмд] тогтмол очих нь таны амьдралыг илүү агуу зорилгоор дүүргэнэ”¹¹ хэмээн амласан.





Калифорнийн Лос Анжелес (зүүн гар талд), Колумби дүүргийн Вашингтон, Вашингтоны Сиэтл, Ютагийн Жордон Ривэр, Мексикийн Мехико Сити зэрэг таван ариун сүм алтан ялтас барьсан Моронай тэнгэр элчийн хөшөөтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг temples.lds.org-оос үзнэ үү.

Ариун сүмд ирцгээ

Бахдалтай ♩ = 63-69

Үгийг Жан Пинбөрөү
Аяыг Майкл Ф.Мүүди





Гэрт тань а - юул - гүй хүр - гэнэ.
Түү - ний а - риун өр - гөөнд ор.




Хойш та - вил - гүй _____ яа - ран орно уу. _____ Мут - раа дэл -



гэн Ав - рагч уг - таж, Энд саата - хыг Тэр хүс - нэ. Зал - бир - лын өр - гөөнд ирц - гээ



нэ үү. _____ Э - зэн адис - ла - хаар энд хү - лээнэ.



сла - хаар энд хү - лээнэ. _____

molto rit.



Ариун сүмд очсоны ТӨЛӨӨ АМЛАГДСАН АДИСЛАЛУУД

*Би ариун сүмд тогтмол очихыг хүсэж
байсан бөгөөд энэ нь гэр бүлийг маань
хэр их адислахыг тэр үед мэдээгүй юм.*

Шэри Эванс

Хэдэн жилийн өмнө гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн ерөнхийлөгч Олдройд надад хэзээ ч мартахгүй нэгэн зүйлийг хэлсэн. Тэр: “Хэрэв та ариун сүмд очих юм бол амьдрал тань *бүхий л* талаараа адислагдана” гэсэн юм.

Би үүний талаар бодоод, ариун сүмд очих нь хэрхэн миний амьдралд бүхий л талаар нөлөөлөхийг сайн төсөөлж чадахгүй байлаа. Гэхдээ би сүмийн цуглааны дараа саналыг нь хүлээн авч, ариун сүмд тогтмол очиж байхаар шийдсэн юм. Би түүний амлалт үнэн эсэхийг шалгахыг хүсэж байлаа. Нөхөр маань ариун сүмд ойр ойрхон очихыг хүсдэг байсан ч би бага насны хүүхдүүдтэй учраас дурамжхан байдаг байв. Бид бүтэн цаг хагас машинаар явж байж АНУ-ын Техасын Сан Антони ариун сүмд очиж, хишиг хүртэх цуглаанд оролцоод, гэр рүүгээ буцаж машинаар ирэх хэрэгтэй байв. Хүүхдүүдийг маань 7-8 цаг харж өгөхийг хүнээс гуйсан ч бүтэлгүйтэв.

Адислалын эхлэл

Эхлээд бид өөр нэгэн гэр бүлтэй хамт нэг нэгнийхээ хүүхдүүдийг ээлжилж харах гэж оролдсон боловч хэн нэг нь өвдөх юм уу ямар нэг ажил гардаг байлаа. Бид бүтэн жилийн хуваарь гаргаад, үзээд *алдахаар* шийдэв. Тэгээд бид “пицца ба тоглоом” гэсэн нэг арга сэдэж олсон юм. Бид ариун сүм рүү машинаар хамтдаа явж байх боллоо. Бид хоёрын нэг нь ариун сүмийн цуглаанд орж байх хооронд нөгөөх нь хүүхдүүдийг пиццанд авч явна. Түрүүчийн удаа хүүхэд харсан хүн нь ариун сүмийн ажлаа хийж байх

хооронд нөгөөх нь хүүхдүүдтэй хамт ариун сүмийн гаднах талбайгаар явдаг болсон юм. Энэ арга харин үр дүнтэй байв. Хүүхдүүд маань ариун сүм бидний хувьд ямар чухал гэдгийг мөн бямба гарагт хийж болох өөр олон зүйл бидэнд байгаа гэдгийг мэддэг байсан. Тэгээд ч бид гэр бүлээрээ цагийг хамтдаа өнгөрүүлэх боломжтой байв.

Ариун сүмд очих нь гэр бүлийг маань хэр их адисалдаг болохыг би тэр үед мэдээгүй юм. Бид ийнхүү жил гаруй тогтмол явсны дараа би ариун сүмийн цуглаанд сууж байхдаа саа өвчтэй нэгэн эрэгтэйг олж

харлаа. Тэр тэнд байгаа нь гайхалтай хэмээн надад бодогдов. Ариун сүмээс гарч явах замдаа түүнийг машины зогсоолын ойролцоо сууж байхыг хараад, би нөхөртэйгөө хамт очиж түүнтэй мэндлэхээр шийдлээ.

Тэр миний нөхөр Чад бид хоёроос утсаар ярихад нь тусална уу гэж гуйсан юм. Бид ч туслахаар зөвшөөрөхөд тэрээр Чадад утас нь хаана байгааг хэллээ. Чад ч утасны дугаарыг оруулаад, утсыг нь түүнд өгөв. Тэр гараа хөдөлгөж чадахгүй байсан ч эелдгээр инээмсэглэлээ. Чад түүний гар тэргэнцрээс бэхлэгдсэн байгааг хараад, утсыг нь чихэнд нь ойртуулж барих хэрэгтэй юм байна гэдгээ даруй ойлгов. Түүнийг ирж авах ёстой байсан хотын үйлчилгээний автобус хоцорч байсан тул бид автобус иртэл түүнтэй цуг байсан юм. Хүнд хэцүү байсан ч гэлээ тэр ариун сүмд ирсэн нь бидний хувьд гайхалтай зүйл байлаа. Тэр маш зөв хандлагатай, сайхан инээмсэглэдэг нэгэн байв. Явахынхаа өмнө тэр холбоо барих мэдээллээ бидэнтэй солилцоход нэрийг нь Макс Пара гэдгийг бид олж мэдсэн юм.

Пара ах өөрийгөө ариун сүмд авчирч чадсан байхад бидэнд ариун сүмд очихгүй байх ямар ч шалтгаан алга!

Пара ахын үлгэр жишээ

Дараачийн сард бид ариун сүм рүү явах замаараа түүн дээр очихоор шийдэв. Түүнтэй урьдчилан утсаар холбогдоход тэр биднийг гэрт нь ирээд, орж болно гэж хэллээ. Бид Сан Антонио руу машинаар явж, Пара ахын жижигхэн байшинг олов. Тэр эрүүтээ хүртэл цагаан даавуугаар биеэ хучин, орон дээрээ хэвтэж байлаа. Тэр толгойгоо хажуу тийш хөдөлгөн бидэнтэй үг сольж байсан





ч инээмсэглэсээр байв. Тэр бидэнд 30 эргэм насандаа дээвэр дээрээс унаж дөрвөн мөч нь мэдээгүй болсноо ярьж, туулж байгаа зовлонгоо бас гэрчлэлээ хуваалцсан юм.

Пара ах дээр нэг удаа зочлон очсон маань өөр олон жилийн айлчлал болон хувирсан билээ. Тэр амьдралын маань нэгэн чухал хэсэг болсон юм. Түүнд олон асуудал байсан учраас бид түүний төлөө юу хийж чадахаа сайн мэдэхгүй байсан ч сайн найзууд байж чадна гэдгээ мэдэж байлаа. Бид түүнд Аврагчийн жижигхэн зураг, Мормоны Номын испани хэл дээрх CD, ариун сүмийн зураг, шинэ ургацын жүрж гэх мэт зүйлс бэлэглэдэг байв. Бид бас гэрт нь ирж, хүүхдийн дуу дуулж өгч, түүний ярихыг сонсдог байсан юм. Энэ нь бидний хувьд гайхалтай туршлага байв. Бид Их Эзэнд зүсэм талх өгвөл тэр хариуд нь бүтэн талх заавал өгдөг.¹

Тэр бидэнд талархалтай байх талаар зааж, харин энэ нь бидний амьдралыг *бүхий л* талаар өөрчилсөн юм. Бид сайн мэдээний талаарх мэдлэг, Бурхан бидний хоорондын харилцаа, авралын төлөвлөгөөний тухай мэдлэг, гэр орон, машин, хоол хүнс, хувцас хунар, бие махбодоо ашиглах чадвар, нийгэмдээ сайн үйлс хийх боломж, хүрээлэн байгаа сайн хүмүүстээ талархах талархал зэргийг сурсан. Пара ах *хэцүү, сорилт* зэрэг үгсийн талаарх бидний ойлголтыг өөрчилсөн юм. Бидэнд олон адислал хүлээн авсандаа баярлах шалтгаан байсан бөгөөд бид тэдгээр адислалаа бусдад урам зориг өгөхөд ашигладаг байсан.

Үйлчилж сурах нь

Нэг удаа Чад өөрийн найзуудын нэг болох Гонзалэс ахтай хамт ариун сүмд байхдаа, Пара ахыг

өөрийг нь авах фургоныг хүлээн ариун сүмийн дэргэд сууж байхыг харав. Пара ах удаан хүлээсэн байжээ. Чад, Гонзалэс ахтай хамт Пара ахыг гэрт нь хүргэж өгөхөөр боллоо. Гонзалэс ах том хар ачааны машинтай байв. Яг тэр үед манай тойргийн машин дүүрэн санваартнууд хажууд ирж зогсоод, хүнд тэргэнцрийг ачааны машины хойно тавьж өгөхөд туслав. Дараа нь тэд Пара ахыг ачааны машинд өргөж суулгаад, түүнийг унагахгүйн тулд сайтар барьж, бүсийг нь зүүж өгсөн. Тэр өдөр Пара ахын хувьд сайхан байсан гэдэгт би итгэлтэй байна. Тэр гэртээ мөрөөдлийнхөө ачааны машинаар хүргүүлнэ гэж зүүдлээ ч үгүй байх!

Бүх талаараа адислагдсан

Нүүхээсээ өмнө хамгийн сүүлчийн удаа Сан Антонио ариун сүмд очиход бидэнд Пара ахынд очих боломж олдсон. Энэ чухал айлчлалын үеэр Пара ах манай гэр бүлийнхнийг бүтэйд нь оройн зоогоор дайлсан юм.


Би ерөнхийлөгч Олдройдын амлалт үнэн эсэхийг туршиж үзсэндээ маш их талархдаг. Бид ариун сүмд очоогүй бол хэзээ ч Пара ахтай уулзахгүй байсан. Би одоо өөр хүн болсон. Би Их Эзэний хүсэж байгаа шиг тийм хүн болж байгаа. Бид Их Эзэнийг нэн тэргүүнд тавьж мөн ариун сүмд очсон учраас амьдрал маань *бүхий л* талаараа адислагдсан билээ. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

Эшлэл

1. Мэвлин Ж.Баллард, Марион Ж.Ромнигийн "Welfare Services: The Savior's Program," *Ensign*, 1980 оны 11-р сар, 93-ыг үзнэ үү.

Та нар, ӨСВӨР ҮЕИЙНХЭН, МЮЧЕЛИЙН СЭДЭВ



*Мючелийн сэдэв хэрхэн
биднийг нэгтгэдэг вэ?*

Жэссика Гриффит

Сүмийн сэтгүүлүүд

Жил бүр Залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл өсвөр үеийнхнийг Тэргүүн Зөвлөлийн баталсан судрын сэдвийг судалж, амьдралдаа хэрэгжүүлэхэд урьдаг. Мючелийн сэдэв дээрх сургаалуудыг судалж, амьдралдаа хэрэгжүүлэх нь итгэл, гэрчлэлийг хүчирхэгжүүлж, чуулга, анги, гэр бүлүүдийг нэгтгэдэг.

2018 оны сэдэв

Энэ жилийн сэдэв нь өсвөр үеийнхэнд Есүс Христээс ирэх амар амгаланг хэрхэн хүлээн авах тухай юм. Сургаал ба Гэрээ 19:23 дээр Их Эзэн **“Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун; миний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхагтун, мөн надаар дамжин амар амгалан чамд байх болно”** хэмээн урьсан байдаг. Эргэлзээ, айдас ноёрхсон энэ дэлхийд энэ нь хүчирхэг амлалт юм.



Энэ судар нь эцэг эх, удирдагч, зөвлөхүүдийг сорилт бэрхшээлтэй цагт өсвөр үеийнхийг хүчирхэгжүүлэх загваруудыг заах боломжоор хангадаг.

Би энэ сэдвийг хэрхэн ашиглах вэ?

Залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл биднийг судруудыг чээжлэх, сургаалыг судлах, зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэхэд урьсан. Эдгээрийг ганцаарчлан хийж болох ч хамтдаа хийвэл өсвөр үеийнхнийг гэр бүлтэй нь нэгтгэн, хүчирхэгжүүлж чадна.

Уг сэдвийг өсвөр үеийнхний амьдралд хэрэгжүүлэх олон арга зам бий. Үүнийг гэр бүлийн үдэш, Сүмийн хичээл, семинар зэрэгт мөн Мючелийн нээлтийн үйл ажиллагааг баяжуулах, өсвөр үеийнхний ариун ёслолын цуглаанд хэлэх үгийн сэдэв болгох зэрэгт эсвэл аялал зугаалга, өсвөр үеийнхний чуулган, нэгдсэн үйл ажиллагаа, Шинэ эхлэл, онцгой цуглалат зэрэг үйл ажиллагаануудын үндсэн хэсэг болгон ашиглаж болно.


Үйл ажиллагааны санаанууд

Мючелийн сэдвийг жилийн туршид хэрэгжүүлэх цөөн санааг доор харуулав.

Илүү олон санааг youth.lds.org-оос үзнэ үү.

“Надаас суралц”

Есүс Христийн тухай судлах нь Есүс Христ дотор амар амгаланг олоход нэн чухал. Түүний ямар болохыг мэдэж, хэрхэн амьдарсныг судлан, бидний төлөө юу хийснийг ойлгосноор амар амгалан, итгэлтэй байдал ирдэг.



Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллыг (1895–1985) 14 настай байхад Библийг уншиж дуусгасан эсэхийг асуужээ. “Би тэр үед хөгжилтэй өгүүлэл, олон ном зохиол уншсан байсан ч миний зэмлэнгүй сэтгэл ‘Спэнсэр Кимбалл гуай, та энэ ариун нандин номыг хэзээ ч уншаагүй шүү дээ. Яагаад? гэж асуусан юм.”¹ Тэр цагаас хойш ерөнхийлөгч Кимбалл “Христийн үгэн дээр найрлахыг” (2 Нифай 32:3) эн тэргүүнд тавих болжээ.



- Өсвөр үеийнхнээс Есүс Христ, Түүний сайн мэдээний тухай судалж байгаа зүйлсээ бичих судлах тэмдэглэл гаргахыг хүс.
- Та “[Судрууд] дээрх Есүсийн хэлж, хийсэн бүх зүйлийг судлахад долоо хоног бүр цаг гарга”² гэсэн ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны уриалгыг хэрэгжүүлэх шийдвэр гаргахад өсвөр үеийнхнийг урьж болно. Анги эсвэл гэр бүлийн үдэш дээр та тэднээс юу сурч байгаагаа мөн тэдгээрийг хэрхэн амьдралдаа хэрэгжүүлж байгаагаа тайлагнахыг хүсэж болно.

Эх сурвалж

- Иаков 1:22; Мосе 1
- “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл *Лиахона*, 2000 оны 4-р сар, 2.
- Рассэлл М.Нэлсон, “Есүс Христийн хүчийг амьдралдаа татан авах нь,” *2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 25.
- Дэвид А.Бэднар, “A Christlike Character,” *Лиахона*, 2017 оны 10-р сар, 50–53.

“Миний үгийг сонс”

Аврагчийн үгийг сонсоно гэдэг нь зөвхөн сонсохыг биш, анхаарч сонсох (буюу дуулгавартай дагах)-ыг багтаадаг. Өөрсдийгөө Түүний сургаалын дагуу амьдарч байгаа гэдгээ мэдсэнээр агуу амар амгалан, итгэлтэй байдал ирдэг.



Ерөнхийлөгч Томас С.Монсон найман настай байхдаа найз Даннитайгаа хамт түүдэг гал асаахаар шийджээ. Тэдний түүдэг асаахыг хүссэн газар хэтэрхий хуурай, өргөс, зэрлэг өвсөөр дүүрсэн байсан нь цорын ганц асуудал байв. Тэр үед залуу ерөнхийлөгч Монсонд нэгэн санаа төржээ. “Би Даннид ‘Энэ зэрлэг өвсийг шатаачихъя!’ гэж хэлсэн. Тэр ч дуртайяа зөвшөөрч, би шүдэнз авахаар гэр рүүгээ гүйв.

. . . Бидний тавьсан гал хэрэгтэй газрыг маань цэвэрлэхээд л илбийн юм шиг өөрөө унтарчих байх гэж бодсоноо би санадаг юм.

Шүдэнзээ чулуунд зурж асаагаад, хатсан хуурай өвсөнд аваачиж тавилаа.” Төд удалгүй гал өөрөө унтрахгүй болохыг ухаарсан хөвгүүд тусламж эрэн гүйсэн бөгөөд галыг хэдэн цаг хөлс хүчээ гаргасны эцэст унтраажээ.

“Тэр өдөр Данни бид хэцүүхэн боловч чухал хэдэн зүйл сурсны нэг нь дуулгавартай байхын ач холбогдол байсан юм” гэж ерөнхийлөгч Монсон хэлжээ.³

- *Миний сайн мэдээг номло*-ын 6-р бүлгээс дуулгавартай байдлын талаар, тэр дундаа бүлгийн төгсгөлд байх зан чанарын үйл ажиллагаанаас дуулгавартай байдал хэсгийг судлахыг өсвөр үеийнхнээс хүс.
- Их Эзэний үгийг сонсоход саад болох зүйлсийн талаар ярилц. Жишээлбэл, өсвөр үеийнхнийг цахим хэрэгсэл дээр зарцуулдаг цагаа судар судлахад зарцуулахад урьж болно.
- Ойлгож мэдсэн зүйлээсээ үүдэн юу хийх талаар өсвөр үеийнхнээс ойр ойрхон асуух боломжийг эрэлхийл.

Эх сурвалж

- Египетээс гарсан нь 20; Матай 5:1–12
- “Дуулгавартай байдал,” *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлд зориулсан удирдамж* (2004), 139.
- Хэдлий Григгс, “Ten Minutes a Day,” *Лиахона*, 2017 оны 9-р сар, 58–61.
- Роберт Д.Хэйлс, “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь,” *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 54.



“Миний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхагтун”

Суралцах, сонсох нь бидний юу хийх хэрэгтэйг тодорхойлдог. Их Эзэний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхах нь бидний үүнийг хийх арга зам юм.

Номхон дөлгөөн байна гэдэг нь “Өвчин зовлонг тэвчээртэй, уурлаж гомдоллохгүйгээр давж гарах”⁴ гэсэн үг бөгөөд хүч чадал, даруу байдлын аль алиныг шаарддаг. 1838 онд Арван хоёрын чуулгын анхны ерөнхийлөгч Томас Б.Марш Сүмийн удирдагчдыг сүүний маргаанд эхнэрийнх нь талд ороогүйд хорссондоо Сүмийг орхисон юм. Амьдралынхаа хожуу үед тэрээр алдсан адислалуудаа харамсан, Сүмд эргэж иржээ. Тэрээр “Би хэзээнээс урваж шарваснаа байнга мэдэхийг хүсдэг байсан бөгөөд Их Эзэний Сүнс зүрх сэтгэлээс минь аддуурсан байсныг мэдсэн. . . Би уур уцаартай, догшин болсон. Их Эзэний Сүнс холдон явсан байсан бөгөөд сударт өгүүлдгээр би сохорсон байсан”⁵ гэж хэлжээ.

- Аврагчийн амьдрал амар хялбар байгаагүй. Есүсийн хүнд хэцүү үедээ номхон дөлгөөн байсныг харуулсан судрууд дээрх жишээг ол. Бид өнөөдрийн тулгарч буй нөхцөл байдалд Аврагчийн үлгэр жишээг хэрхэн хэрэгжүүлж болох тухай ярилц.
- Номхон дөлгөөн болох нэг арга бол бусдад үйлчлэх явдал юм. Өсвөр үеийнхний ганцаараа эсвэл бүлгээрээ хийж болох өөр өөр үйлчлэлийг бодож ол.

Эх сурвалж

- Тит 3:2–5; Моронай 8:26; Сургаал ба Гэрээ 112:13
- Юлиссэс Соарэс, “Хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэлдээ номхон байгтун,” *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 9.
- Нийл А.Максвэлл, “The Holy Ghost: Glorifying Christ,” *Ensign*, 1983 оны 3-р сар, 70.



“Надаар дамжин амар амгалан чамд байх болно”

Эдгэрэх нь боломжтой зүйл гэдэгт найдах, хүнд хэцүү цагт гарах арга зам байдаг гэдэгт итгэх эсвэл зөв зам дээрээ байгаа гэдгээ дахин мэдэрэх зэрэг амар амгалан нь хүмүүсийн хувьд өөр өөр утга учиртай байдаг.



- [Mormon.org/easter](https://www.mormon.org/easter)-оос мөн энэ нийтлэлийн 60, 63-р хуудсаас хүмүүс хэрхэн Христээр дамжуулан амар амгаланг олсон тухай түүхүүдийг олж унш. Та хэрхэн амар амгаланг олсон бэ?
- [Mormon.org/easter](https://www.mormon.org/easter)-ээс “Prince of Peace” 2017 оны Христийн амилсны баярын видео бичлэгийг үз. Христээр дамжуулан хэрхэн амар амгаланг олсон тухай гэрчлэлийнхээ хамт уг видео бичлэгийг онлайнар хуваалцахыг өсвөр үеийнхэнд урьж болно.

Эх сурвалж

- Иохан 14:27; Филиппой 4:7
- В.Кристофер Ваддэлл, “Амар амгалад хүргэх загвар,” *2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 74.
- Квинтин Л.Кук, “Хувь хүний амар амгалан бол зөв шударга байдлын шагнал мөн,” *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 37. ■

ЭШЛЭЛ

1. Спэнсэр В.Кимбалл, “Read the Scriptures,” *Friend*, 1985 оны 12-р сар, нүүрэн талын дотор талын зураг; мөн “What I Read as a Boy,” *Children's Friend*, 1943 оны 11-р сар, 508-ыг үзнэ үү.
2. Рассэлл М.Нэлсон, “Prophets, Leadership, and Divine Law” (Залуучуудад зориулсан дэлхий дахины онцгой цугларалт, 2017 оны 1-р сарын 8), [broadcasts.lds.org](https://www.broadcasts.lds.org).
3. Томас Б.Монсон, “Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг,” *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 104.
4. *Merriam-Webster's Collegiate Dictionary*, 11th ed. (2003), “meekness,” [merriam-webster.com](https://www.merriam-webster.com).
5. Томас Б.Марш, in *Journal of Discourses*, 5:206–7 (мөн “The Faith and Fall of Thomas Marsh,” in *Revelations in Context: The Stories behind the Sections of the Doctrine and Covenants*, Matthew McBride and James Goldberg, eds. [2016], 57–59-ийг үзнэ үү).



ЗӨВЛӨЛД СУУХ НЬ

МЕЛКИЗЕДЕК САНВААРЫН
БОЛОН ХАЛАМЖИЙН
НИЙГЭМЛЭГИЙН
ЦУГЛААНУУДАД ИЛҮҮ АГУУ
ХҮЧИЙГ АВЧРАХ НЬ

Өмнөтгөлийг Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард

Би төлөөлөгчөөр үйлчлэхдээ номлол, гадас, тойрог, туслах бүлгийн зөвлөл зэрэг Сүмийн зөвлөлүүдийн хүч, ач холбогдлын талаар тогтмол онцолдог байсан. Зөвлөлөөр дамжуулан ажиллах нь бодит үр дүнд хүрэх хамгийн үр дүнтэй арга барил гэдэгт би итгэдэг.

Бид энэ сард энгийн боловч чухал өөрчлөлтийг хөтөлбөртөө оруулж байгаа бөгөөд Мелкизедек санваарын чуулга болон Халамжийн нийгэмлэгийн гишүүд тус тусын бүлгээрээ ням гарагт цугларахдаа үүнээс суралцах ёстой. Бид хамгийн сүүлчийн Ерөнхий чуулганы амьд бошиглогчдын үгсээс суралцахын зэрэгцээ хамтдаа “зөвлөлд сууж” (С ба Г 107:89), тулгарч буй асуудал, хэрэгцээгээ ярилцана.

Бид хамтдаа илүү үр дүнтэй зөвлөлдөж сурвал Бурхан биднийг илүү олон илчлэлт, ойлголт болон Өөрийн ажлыг хийж гүйцэтгэх илүү агуу хүчээр адислах болно.

Майкл Маглби

Санваар болон гэр бүлийн албаны сургалтын материал хариуцсан дарга

Энэ дэлхийг бүтээхийн өмнө Тэнгэрлэг Эцэг ажлаа зөвлөлөөр дамжуулан хийдэг байсан (С ба Г 121:32 үзнэ үү). Адам, Евагаас эхлэн Бурханы хүмүүс Түүний зөвлөгөөг зөвлөлөөр эрэлхийлдэг байв. Үнэндээ, Бурхан Өөрийгөө “Зөвлөгөөний Хүн” (Мосе 7:35) хэмээн нэрлэсэн байдаг. Энэ эрин үеийн эхэнд Иосеф Смит “эрт үеийн Зөвлөлүүдийн жаягийг”¹ сэргээж эхэлсэн. Өнөөдөр Сүмийг бүхий л түвшинд зөвлөлүүдээр дамжуулан удирддаг.



Сүүлийн саруудад Сүмийн ерөнхий удирдагчид Мелкизедек санваарын болон Халамжийн нийгэмлэгийн бүлгийн цуглаануудыг хүчирхэгжүүлэх талаар хамтдаа зөвлөлдсөн. Үүний үр дүнд *“Ирээд, Намайг дага—Мелкизедек санваарын болон Халамжийн нийгэмлэгт зориулав”* хэмээх шинэ сургалтын материал гарч ирсэн. Энэ нь Ерөнхий чуулганы захиасыг түлхүү ашиглаж, санваарын чуулга болон Халамжийн нийгэмлэгт зөвлөлдөх хүчийг татан оролцуулах юм.

Энэ өөрчлөлтийг удирдан явуулахад тусалсан Далын ахлагч Кристоффэл Голдэн: “Бид өмнө нь маш их сайн зүйлийг хийсэн. Харин одоо Их Эзэн биднээс урагшлахыг хүсэж байна. Амьд бошиглогчдын үгсийг судлах мөн зөвлөлд суух гэсэн энэ шилжилтийн үр дүнд өсөлт хөгжил ирнэ” хэмээн хэлсэн.

Саяхан Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл болон Далын гишүүд уулзан, зөвлөлдөх нь хэрхэн илчлэлтийг урьж, нэгдмэл байдлыг нэмэгдүүлж, хүчийг авчирдаг талаар ярилцсан билээ. Та нар өөрсдөдөө болон тойрог, салбартаа мөн чуулга болон Халамжийн нийгэмлэгтээ зөв шийдлүүдийг хайж олохдоо эдгээр санааг баяжуулна гэдгийг мэдэж байгаа тул тэд дараах зарчмуудыг санал болгож байна. Тэдгээр нь:

Зорилгод агуулагдсан хүч

“Та нар өөрсдийгөө цуглуулсан учраас, мөн . . . энэ нэг зүйлийн талаар санал нэгтэй байж, мөн миний нэрээр Эцэгээс асуулаа, бүр үүнчлэн та нар хүлээн авах болно” (С ба Г 42:3).

Зөвлөл нь бидний “Их Эзэний хүслийг хамтаараа эрж хайх”² арга зам юм. Өөрөөр хэлбэл, үүнд зөвхөн бодол санаагаа хуваалцах нь хангалтгүй. Харин бид хамтдаа зөвлөлдсөнөөр үүссэн нөхцөл байдалд Их Эзэний биднээс юу хийхийг хүсэж байгааг олж мэдэхийн тулд илчлэлтийг урих явдал юм. Бид дараах зүйлсийг санаж байх юм бол ийм илчлэлтийг амжилттай хүлээн авна. Тухайлбал:

1. *Анхаарлаа төвлөрүүлэх—тодорхой, чухал асуудал, хэрэгцээнээс эхэл.* Дан ганц асуудал, хэрэгцээнд анхаарлаа төвлөрүүлэх нь бидний ач холбогдолтой ахиц гаргах чадварыг нэмэгдүүлнэ. Анхаарлаа төвлөрүүлэх нь нүдэнд харагдах шинж тэмдгээс (юу болж байгаа) цаадхыг харж, уг язгуур учир шалтгааны (ямар нэгэн зүйл яагаад, хэрхэн хүмүүст нөлөөлдөг) талаар ойлгоход бидэнд тусалдаг. Жишээлбэл: Өсвөр үеийнхний компьютерийн дэлгэц харахад зарцуулдаг цагийн талаар ярих биш, харин хэрхэн тэдэнд зааж сурган, тэдэнтэй холбогдох тухай зөвлөлдөж болох юм.

2. *Хэтийн төлөв—асуудал, хэрэгцээг асуултаар илэрхийл.* Сэдвийг асуулт маягаар тавих юм бол сургаалын талаарх ойлголтын тухай ярилцах боломжтой байна. “Бид нөхцөл байдалд хэрхэн тус болох, шийдвэрлэх арга замаар хандаж болох вэ?” эсвэл “Ямар сургаалыг сайн ойлгуулбал уг асуудлыг шийдвэрлэхэд тусалж чадах вэ?” гэж бид асууж болно.

3. *Хүч—илчлэлтийг эрэлхийл.* Зөвлөл нь шийдлийн талаар хамтран хэлэлцэж болох ч энэ нь зүгээр л тэргүүн туршлагын жагсаалт гаргах эсвэл “Миний өмнөх тойрогт ингэж хийдэг байсан” гэж хэлэх биш, харин Бурханы хүсэл юу болохыг олж мэдэх зорилготой. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар бидэнд хурал биш, харин илчлэлтийн туршлага хэрэгтэй хэмээн заасан.³ Хамтдаа хэлэлцсэнээр үйлдэлд хүргэх хүчтэй шийдлийг олдог.

Оролцооны хүч

“Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, мөн хүн болгон тэгш боломжтой байж болохын тулд харин нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог” (С ба Г 88:122).

Зөвлөлд хувь хүн ба тойрог эсвэл салбарын ашиг сонирхол, ялангуяа оролцогчид дараах зүйлийг ойлгодог тохиолдолд өвөрмөц байдлаар нэгддэг. Тухайлбал:

1. *Зөвлөлийн гишүүн бүр чухал үүрэгтэй.* Зөвлөлийн гишүүд зөвлөлд давамгайлалгүйгээр идэвхтэй оролцох ёстой. Паулын зааснаар: “Нүд ‘Чи надад хэрэггүй’ гэж гарт хэлж чадахгүй. Эсвэл толгой ‘Та нар надад хэрэггүй’ гэж хөлд хэлж чадахгүй юм. Бүр сул дорой мэт санагдах эрхтэн харин ч шал өөр байх бөгөөд биед бүр ч их хэрэгтэй

байдаг аж” (1 Коринт 12:21–22).

2. *Зөвлөлийн гишүүд асуудлыг тодотгохыг эрэлхийлдэг.* Бошиглогч Иосеф Смит “хүн бүр зөвлөлөөр хэлэлцэхээр авчирсан асуудлыг эсэргүүцэхээсээ өмнө харанхуй, сөрөг мэдрэмжийг тараахын оронд уг асуудлыг тодотгож, гэрэл гэгээ цацруулах хэрэгтэй. Ингэвэл эсэргүүцэл тань зөв шударга байдал дээр үндэслэгдэх болно”⁴ гэж заасан.

3. *Зөвлөлийн гишүүд нэгдмэл байхыг эрэлхийлдэг.* Зөвлөлийн гишүүд өөр өөр үзэл бодолтой байж болох ч “Ариун Сүнснээс удирдамж хүлээн ав[ахын]”⁵ тулд эв нэгдэлтэй байхыг эрэлхийлдэг. Иосеф Смит нэг удаа зөвлөлийн үеэр: “Илчлэлт болон тэнгэрийн адислал хүлээн авахын тулд бид өөрсдийн оюун ухааныг Бурханд хандуулан, итгэлээ хөгжүүлж, нэг зүрх сэтгэл, нэг оюун ухаантай болох шаардлагатай”⁶ хэмээн хэлсэн.

Хийх ажлын төлөвлөгөөний хүч

“Миний өгсөн ёс суртахууны сонгох эрхийн дагуу хүн болгон ирээдүйд хамаарах сургаал хийгээд зарчимд үйлдэж болохын тулд . . . буюу.” (С ба Г 101:78).

Зөвлөл нь хүлээн авсан илчлэлтийн дагуу үйлдэх төлөвлөгөө гаргахгүй бол үүнийг бүрэн гүйцэд хийсэнд тооцохгүй. Зөвлөлд оролцогчдыг тодорхой үүрэг даалгавар хийж гүйцэтгэх амлалт өгөхөд урьсан байх ёстой. Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Жийн Б.Бингам эгч “Зөвлөлийн хурлын төгсгөлд та нарт даалгавар хүлээлгэн өгсөн байх хэрэгтэй. Хамгийн чухал ажил хурлуудын хооронд хийгддэг.

Удирдагч нь зөвлөлийнхнийг харилцан ойлголцож, тохиролцоход хөтлөн удирддаг. Үүний дараа тэр үүрэг даалгаврыг гаргаж, даалгаж өгсөн ажлаа тэмдэглэн, гүйцэтгэлийг шалгадаг. Халамжийн нийгэмлэгийн

ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Шэрон Юбанк эгч: “Хүч чадал бидэнд бий. Бид үйлдэхийн тулд өөрсдөдөө үүрэг хүлээх юм бол Их Эзэн бидний хичээл зүтгэлийг ариусгах болно” (С ба Г 43:9-ийг үзнэ үү) хэмээн хэлсэн. Сайн дураараа оролцох, үүрэгт ажлаа эргэж тайлагнах нь гэрээт ажлын утга агуулга юм.

Удирдагчийн үүрэг

“Номлогч нь сонсогчоосоо өчүүхэн ч илүү бус ажгуу, бас багш нь сурагчаасаа илүү бус бөлгөө; мөн тийн тэд бүгд адил тэгш байв” (Алма 1:26).

Бид зөвлөлөө сайжруулахын тулд удирдлагын талаарх дэлхийнхний ойлголтоос ангид байх ёстой. Их Эзэний хаант улсад удирдагч нь “бүгдийн боол” (Марк 10:44) билээ. Үүний адил, зөвлөлийн удирдагч тэргүүлэх эрх мэдэлтэн юм уу багш байхаас үл хамааран анхаарлын төвд байдаггүй, харин анхаарлаа хандуулах хэрэгтэй зүйлийг л толилуулдаг. Тэр бусдаас илүү ярьж, зөвлөлийнхний үгийг сонсохоосоо өмнө өөрийн байр суурийг тогтоохоос зайлсхийх ёстой.

Зөвлөлийн удирдагч нь зорилгыг тодорхойлох, ярилцлагад түлхэц өгөх, оролцогчдыг үйлдэх амлалт өгөхөд урихад чухал үүрэг гүйцэтгэдэг. Зөвлөлийн удирдагч сонсож, удирдан залж, урьж, хамгаалж, бататгах юм бол зөвлөл илүү үр дүнтэй ажилладаг.

1. *Сонс.* Сайн сонсогч ярьж байгаа хүнээ болон Ариун Сүнсийг сонсдог. Ахлагч Бэднар “Бид ярихын оронд сонсох юм бол ялган таних бэлэг илүү үр дүнтэй ажилладаг гэдэгт би итгэдэг”⁷ хэмээн хэлсэн.

2. *Удирд.* Зөвлөлийн удирдагч үзэл санаа бүрэлдэн гарч ирэх боломжийг олгох замаар ярилцлагыг хөтөлдөг. Шаардлагатай бол удирдагч ярилцлагын сэдвийг өөр



хүрээнээс танилцуулах юм уу өөр чиглэл рүү эвтэйхэн хандуулна.

3. *Урь.* Их Эзэн илчлэлтийг зөвлөлийн гишүүдийн дунд тарааж өгдөг. Бүгдийг, тэр тусмаа дуугүй суудаг хүмүүсийг санаагаа хуваалцахад урих нь Их Эзэний хүслийн талаар олж мэдэх магадлалыг өсгөн нэмэгдүүлдэг.

4. *Хамгаал.* Зөвлөлийн удирдагч саналаа хуваалцаж буй хүмүүст анхаарал халамж тавьж, шүүмжлэх, шүүгдэхээс хамгаалах замаар тэдэнд амар тайван хуваалцах орчныг бий болгодог. Эмзэг сэдвийг эвтэйхэн удирдан залах хэрэгтэй. Нууц асуудал нууц хэвээр үлдэх ёстой.

5. *Бататга.* Оролцогчдыг бодол санаагаа хуваалцах үед удирдагч оруулсан хувь нэмэрт нь талархаж, холбогдох санааг хооронд нь уялдуулан холбох замаар тэдний оролцоог бататгадаг. Ийнхүү бататгах нь оролцогчдод илчлэлтийн үйл явцын



нэгэн хэсэг гэдгийг мэдэрч, тус нэмэр болгохын тулд өөрөө өөрсдийгөө дайчлахад тусалдаг.

Шинэ сургалтын материал, шинэ үүрэг даалгавар

Шинэ он гарч, шинэ сургалтын материалтай болсноор шинэ үүрэг амлалтын үе ирнэ. Бид Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээгээр адислагдсан. Түүний удирдамжийг эрэлхийлэн, Түүний ажлыг хийх нь бидний үүрэг бөгөөд онцгой эрх юм. Ням гаргийн Мелкизедек санваарын болон Халамжийн нийгэмлэгийн цуглаанд энэхүү алхмыг хийх нь зөвхөн ажлын талаар хичээл заах биш, харин “зөвлөлд сууж” мөн зөв шударга үйлдлийг буюу “олон хүнийг тэргүүн дээрээ үүрдийн баяр баясгалангийн дуунуудтайгаар Сион уруу түлхэх” (С ба Г 66:11) үйлдлийг хөхиүлэн дэмжих явдал юм. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Иосеф Смит, “Minutes, 17 February 1834,” josephsmithpapers.org.
2. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь*, (2010), 2.4.4.
3. Дэвид А.Бэднар, “Panel Discussion” (Дэлхий даяарх удирдагчдын сургалт, 2010 оны 11-р сар), lds.org/broadcasts)-ийг үзнэ үү.
4. *Teachings of the Prophet Joseph Smith*, эмхэтгэсэн Жозеф Фийлдинг Смит, (1976), 94.
5. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь*, 3.3.2.
6. Иосеф Смит, “Minutes, 27-28 February 1832,” 3, josephsmithpapers.org.
7. Дэвид А.Бэднар, “Panel Discussion.”

МЕЛКИЗЕДЕК САНВААРЫН БОЛОН ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЦУГЛААНУУД ХООРОНДОО ЯМАР ЯЛГААТАЙ ВЭ?

С ар бүрийн эхний ням гаргийн Мелкизедек санваарын болон Халамжийн нийгэмлэгийн цуглааны хэлэлцүүлгийг ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эсвэл бүлгийн удирдагч удирдан явуулдаг. Эдгээр цуглаан нь биднийг асуудал, хэрэгцээний талаар хамтдаа зөвлөлдөх үед “зааварлаж мөн сэнхрүүл[дэг]” (С ба Г 43:8) зөвлөл юм. Эдгээр хэлэлцүүлэг нь хувь хүний болон багийн зүгээс үйлдэл хийхэд хүргэдэг.

Бусад ням гаргаар бид хэлэлцсэн ажил, үүрэг даалгавраа тайлагнаж, гүйцэтгэлийн явцыг шалгана. Шаардлагатай бол бид шинэ үүрэг даалгавар гаргаж, тэмдэглэж авна. Эдгээр цуглааны үеэр явагдах хэлэлцүүлэг нь Ерөнхий чуулганы захиасаар заагдсан сургаал болон Сүмийн ерөнхий удирдагчдын сонгосон сэдэвт төвлөрсөн байх бөгөөд ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн, бүлгийн удирдагч эсвэл дуудагдсан багш удирдан явуулна. Эдгээр хэлэлцүүлгийн үеэр төрсөн мэдрэмж бидэнд хувь хүний хувьд үйлдэж, өөрчлөгдөх сүнслэг өдөөлтийг өгнө.





Арван хоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч М.Рассэлл
Баллард

Гэр бүлийн МӨНХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Хожмын үеийн гэгээнтнүүд ариун сүмүүдэд зөвхөн үхэл салгах энэ амьдралд төдийгүй үүрд мөнхөд гэрлэдэг учраас ариун сүм тэдний хувьд маш чухал зүйл юм. 23 жилийн өмнө Сүмийн “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-г тунхагласнаар “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханаас заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг.”¹

Энэ сургаал биднийг гэр бүлд маш их ач холбогдол өгдөг болохыг харуулж байна. Бид мөн бүх хүнийг ойлгож, хайрлан, өрөвч нигүүлсэнгүй хандах ёстой гэдэгт итгэдэг. Юуны түрүүнд би яагаад уламжлалт гэр бүлүүд манай Сүмд

чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг сургаалын талаас тайлбарлана. Хоёрдугаарт, гэр бүлийн талаарх шашны ойлголт, шашны эрх чөлөөний уялдаа холбооны талаар тайлбарлах болно. Эцэст нь, аливаа буруу ойлголт, зөрчилдөөнөөс үл хамааран эргэн тойрондоо байгаа хүмүүст хүрч туслах удирдах зарчмуудыг хуваалцана.

Гэр бүлийн талаарх Сүмийн итгэл үнэмшил

Би гэр бүлийн талаарх Сүмийн итгэл үнэмшлийг дэлгэрэнгүй тайлбарлахдаа хүүхдүүдийнхээ байнга дууддаг “Би тэнгэрт амьдарч байсан” дууны шүлгээс эш татмаар байна. Энэ дуу биднийг хаанаас ирсэн, яагаад энд байгаа болон хаашаа явах талаар товч ойлголт өгдөг. Хожмын үеийн гэгээнтнүүд үүнийг авралын төлөвлөгөө буюу Тэнгэрлэг Эцэгийн мөнхийн төлөвлөгөө гэж нэрлэдэг юм.

*АНУ-ын Юта мужийн
Солт Лэйк Ситид бол-
сон Дэлхийн гэр бүлийн
ес дэх чуулга уулзалтаар
хэлсэн үгэндээ ахлагч
М.Рассэлл Баллард уламж-
лалт гэрлэлтэд итгэдэг
хүмүүс итгэл, гэр бүл, эрх
чөлөөгөө хүчирхэгжүүлэн,
хамгаалахын тулд бүхий
л тусламж дэмжлэгээ
нэгтгэх ёстой гэж хэлжээ.*

*Би эрт дээр үед тэнгэрт амьдарч байсан нь үнэн
Хайрладаг хүмүүстэйгээ хамт байсан. Чи ч
гэсэн адил.*

*Хүмүүнд өгсөн дэлхий, мөнхийн авралын
төлөвлөгөөг*

Тэнгэрлэг Эцэг танилцуулсан.

*Бүгд буцахын тулд өөрийнхөө амьдралыг өгч чадах
Хайраар дүүрэн хэн нэгэн Түүнд хэрэгтэй гэлээ.*

Тэнд алдрыг өөртөө авахыг хайсан нэгэн байсан.

Есүс “Намайг илгээ, алдар суу таных” гэсэн.

*Есүс сонгогдож, Мессиа болон ирсэн,
Өөрийн алдаршсан нэрээр үхэл, хилэнцийг ялж
Намайг хүлээж байгаа аавын орших тэнгэр дэх гэр
Гайхалтай амьдралын итгэл найдварыг өгсөн.”²*

Энэ дууг ашиглан бидний мөнх бус байдал, мөнхийн мөн чанар, гэр бүлийн тухай авралын төлөвлөгөөний хэд хэдэн чухал бүрэлдэхүүн хэсгийг тайлбарлахыг минь зөвшөөрнө үү.

Бид энэ амьдралаас өмнө Тэнгэрлэг Эцэг маань болох Бурхантай хамт амьдарч байсан. Тэрээр бидний сүнсний төрсөн Эцэг бөгөөд бид Түүний сүнсэн хүүхдүүд. Иймээс энэ амьдралд төрсөн хүн бүр сүнсэн ах, эгч, дүүс билээ.

“Бурханы бүх зорилго—ажил болон алдар суу нь Түүний бүх адислалыг эдлэхийг хүн нэг бүрд боломжтой болгох явдал мөн.” Түүний зарлигуудыг дагах, эс дагах сонголт нь бидний мөнхийн хувь заяаг тодорхойлдог. “Есүс Христ бол Бурханы төлөвлөгөөн дэх төв юм. Есүс Христ Өөрийн Цагаатгалаар дамжуулан Эцэгийнхээ зорилгыг хэрэгжүүлж, үхэшгүй байдал, мөнх амьдралыг эдлэх явдлыг хүн нэг бүрд боломжтой болгосон.”³ Хэрэв бид “энэ амьдралд хийгээд үүрд мөнхийн тулд” ариун сүмд гэрлэсэн бол гэрлэлт, гэр бүлийн харилцаа нь санваарын эрх мэдлээр холбогдон, үхлийн дараа ч оршин тогтнох болно (С ба Г 132:7).

Би энэхүү товч дүгнэлт нь бидний шашин шүтлэг уламжлалт гэр бүлтэй хэрхэн бүрэн дүүрэн холбогдог болохыг ойлгоход тань тусална гэж найдаж байна. Нийгэм, хууль, нийтлэг үзэл бодол өөрчлөгдөж болох ч нийгмийн тодорхойлдог гэр бүл Бурханы хүүхдүүдээ зориулсан зорилго, төлөвлөгөөг орлож чадахгүй, орлох ч үгүй.

Гэрлэж, үр хүүхдүүдтэй болохыг чухал гэж үзэхээ больж буй өнөөдрийн дэлхийд Есүс Христийн Хожмын

Үеийн Гэгээнтнүүдийн Сүм ганцаараа уламжлалт гэр бүлийг сургаалынхаа хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болгон зогсоогүй билээ.

Пап Францис “[Бурхан] өөрсдийг нь нөхөн гүйцээх хэн нэгэнтэй аяллаа хамт туулан, хайрлуулах, хайрлахын гайхамшгийг мэдрэн, уг хайр нь хүүхдүүд хэмээх үр жимсийг авчрахыг харан, аз жаргалтай байх заяатай болгон эрэгтэй, эмэгтэйчүүдийг бүтээсэн”⁴ хэмээн хэлсэн юм.

Өмнөдийн баптист сүм “Гэрлэлт гэдэг нь нэг эрэгтэйг өөр нэг эмэгтэйтэй энэ амьдралын туршид гэрээ бүхий амлалтаар нэгтгэхийг хэлнэ. . . . Эхнэр, нөхөр хоёр хоёулаа Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас Бурханы мэлмийд адил үнэ цэнтэй билээ”⁵ хэмээн тунхаглажээ.

Мөнхийн гэр бүлийн талаарх бидний сургаалын итгэл үнэмшил, бусад Христийн шашинтан нэр нөлөө бүхий удирдагчдын хэлсэн мэдэгдэл бид яагаад уламжлалт гэр бүлийг хөхиүлэн дэмжиж, хамгаалахад хамаг чадлаа зориулдаг болохыг ойлгоход тусалдаг.

Шашны итгэл үнэмшлийг дэмжих шашнаас ангид дэмжлэг туслалцаа

Иймэрхүү сургаал, мэдэгдлүүдийг шашны мунхаглал гэж боддог хүмүүс байдаг. Гэсэн ч 2015 оны 6-р сард Нэгдсэн Улсын дээд шүүх үнэнч шударга, ухаалаг хүмүүс ижил хүйстний гэрлэлтийн талаарх асуудлуудад хүртэл өөр үзэл бодолтой байж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх гэж ихээхэн хүчин чармайлт гаргасан.

“Шашнаа дээдлэн хүндэлдэг хүмүүст гэрлэлт нь ариун нандин зүйл байдаг. . . .

Цаг хугацаа, соёл уламжлал, итгэл үнэмшлийн гүүр болсон гэрлэлтийн сайн сайхан байдлын талаарх тоолж баршгүй олон эшлэл шашны мөн гүн ухааны текстүүдэд уран бүтээл, ном зохиол зэрэг бүхий л хэлбэрээр байдаг. Гэрлэлт бол эсрэг хүйсийн хоёр хүний хоорондын нэгдэл хэмээх ойлголт дээр эдгээр нь түшиглэсэн гэж хэлэх нь шударга зүйл бөгөөд ингэж хэлэх шаардлагатай байна.

. . . Гэрлэлт нь мөн чанартаа эсрэг хүйсийн эмэгтэй, эрэгтэй хүний нэгдэл юм. Энэхүү ойлголт энд байгаа мөн дэлхий даяарх үнэнч шударга, ухаалаг хүмүүсийн сайн санаан дээр өнө удаан оршин тогтносон бөгөөд цаашид ч оршин тогтнох болно.”⁶

Улсын дээд шүүх дэлхий дээрх үнэнч шударга, ухаалаг олон хүн уламжлалт гэрлэлтийг хүлээн зөвшөөрсөөр байх болно гэдгийг хүлээн зөвшөөрчээ.



Итгэл, гэр бүл, эрх чөлөө

Үнэнч шударга, ухаалаг хүмүүс гэрлэлтийг зөвхөн эсрэг хүйсийн хүмүүсийн хооронд байдаг гэж үздэг учраас ийм итгэл үнэмшил олон нийтийн санаа бодлоор хүлээн зөвшөөрөгдөж, шашны эрх чөлөөгөөр хамгаалуулах ёстой. Үнэндээ шашны итгэл үнэмшил нь итгэгчдэдээ амьдралын зорилгыг хэрхэн харахад нь нөлөөлдөг учраас иймэрхүү итгэл үнэмшил тэднийг нийгэмтэй хэр харилцаатай болохыг харуулна.

Багш нь бие биедээ дурласан хоёр ханхүүгийн талаарх түүхийг ярьж өгсөн нэгэн хүүхдийн тухай сонин нийтлэл санаанд минь орлоо. Багш материалаа ямар ч сэрэмжлүүлэг, анхааруулгагүйгээр танилцуулжээ. Энэ түүхийг дахиад унших эсэхийг мэдэхийг хүссэн эцэг эхчүүдэд сургууль хариу өгөхөөс татгалзсан байна.⁷

Итгэл үнэмшилтэй нь зөрчилдөх материалыг зааснаас болж хүүхдүүдээ сургуулиас гаргахыг эцэг эхчүүдэд зөвшөөрөхөд сургуулийн захиргаанд тийм хор хөнөөлтэй байсан гэж үү? Энэ сургуулийн шийдвэр хүүхдүүдээ өсгөж хүмүүжүүлэх эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагыг шууд утгаараа уландаа гишгэж байгаа санагдсан юм.

Бид дэндүү эсрэг тэсрэг цаг үед амьдарч байна. Ихэнхдээ харилцан буулт хийхэд хэцүү, боломжгүй санагддаг. Итгэл бишрэлийнхээ дагуу амьдрахыг хичээснээсээ болж мухар сүсэгтэн, гадуурхагч гэж

буруутгагдан, хүлээн зөвшөөрөмгүй байдлаар шийтгүүлж үлдсэн хүмүүсийн түүхийг бид сонсдог.

Нэгдсэн Улсыг оруулаад дэлхийн бараг 200 үндэстэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын гэрээнд гарын үсэг зурахдаа хүүхдүүдээ заах эцэг эхийн эрхийг хүлээн зөвшөөрсөн билээ. Энэ гэрээний 18-р зүйл дээр “Энэхүү хэлэлцээрт оролцогч улс эцэг эхийн үр хүүхдэдээ хувийн итгэл үнэмшлийнхээ дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг хүндэтгэх үүрэг хүлээнэ”⁸ гэж тунхагладаг.

Энэхүү олон улсын хүний эрхийн хамгаалалт нь гэр бүлийн тунхаг дээрх Сүмийн байр суурьтай нийцдэг юм. “Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж, . . . бие биеэ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагахыг зааж сургах нандин үүрэгтэй. Эхнэр нөхөр, эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.”⁹

Бид далайн түрлэгийг сөрөн зогсож байгаа мэт санагдаж болох ч уламжлалт гэрлэлтийн үзэл бодлоо хадгалан үлдэхэд туслах олон дэмжлэг тусалцаа бидэнд бий. Би зөвхөн цөөн эх сурвалж дурдлаа. Үүнээс ч их бий.

Бид итгэл, гэр бүл, эрх чөлөөгөө хүчирхэгжүүлэн, хамгаалахын тулд бүхий л арга замаар дэмжүүлэх ёстой. Зарим хүн бидний эрхийг булаах гэж идэвхтэй зүтгэж байна. Нэгдсэн Улс дахь шашны эрх чөлөөний

хамгаалалтыг буулгаж авах гэж сая сая доллар зарцуулсан гэсэн мэдээ гарсан байсан.¹⁰

Энэхүү заналхийллийн хариуд хамтран зүтгэгч маань болох Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс цагаа олсон хариулт өгсөн гэж би итгэдэг. “Бид номхон дөлгөөн байж, сэргэлдөөнөөс зайлсхийхдээ өөрсдийн ойлгож хүлээн авсан үнэн зүйлст итгэх итгэл үнэмшлээ сулруулах юм уу үүнд бууж өгч болохгүй. Бид байр сууринаасаа эсвэл эрхэмлэх зүйлсээсээ татгалзах ёсгүй.”¹¹

Хэрэв биднийг эсэргүүцдэг хүмүүс хүмүүний өөр хоорондын ялгаатай байдал, эрх тэгш байдлын үнэ цэнийн талаарх итгэл үнэмшилдээ үнэнч байгаа бол бид өрөвч нигүүлсэнгүй сэтгэл, эв найрамдлыг бий болгохын тулд хамтдаа ажиллах боломжтой гэсэн үг. Эцэг эхийнх нь хүсэлтэй зөрчилдөх материалыг хүүхдүүдэд уншиж өгсөнтэй адил өөр нэгний итгэл үнэмшлийг нөгөөд нь тулгах нь хүмүүний өөр хоорондын ялгаатай байдлын ач холбогдлыг бууруулж, эрх тэгш байдлын тэнцвэрийг алдагдуулдаг. Харилцан буулт хийж, ах, эгч, дүүс маань болох Бурханы бүх хүүхдэд хайрын гараа сунгаснаар ёс суртахуун, итгэл үнэмшилтэй амар тайван, олон талт нийгмийг бүтээж чадна.

Нэг нэгнээ хайрлах үндсэн зарчим

Би уламжлалт гэрлэлтийн ач холбогдлыг мөн эрх чөлөөгөө хамгаалах ёстой талаар тайлбарлалаа. Одоо бид яагаад санал зөрөлддөг хүмүүстэйгээ нөхөрсөг байх ёстойг тайлбарлая. Есүс Христ

“Дайснуудаа хайрла, чамайг зүхэх тэднийг адисал, чамайг үзэн ядах тэдэнд сайныг үйлд, мөн чамайг хүнлэг бусаар ашиглах мөн чамайг хавчин гадуурхах тэдний төлөө залбир.

Та нар тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд байж болохын тулд буюу” (Матай 5:44–45) хэмээн зарлигласан.

Бид санал зөрөлддөг гэр бүлийн гишүүдээ үгүйсгэдэггүй мөн үгүйсгэж болохгүйтэй адил биднээс өөр харагдааг, өөрөөр бодож, үйлддэг хүмүүст тэгж хандаж болохгүй. Бид Бурханы бүх хүүхдийг хайрлаж, энэрснээр хамгийн хүнлэг сэтгэлтэйгээ харуулдаг. Бид тулган шаардалтыг эсэргүүцэж, доог тохуу хийсэн нэр хочийг үл тоон, ойлголцол, харилцан хүндлэлээр дамжуулан шударга үр дүнг хүсэж олон нийтэд санаа бодлоо өргөхдөө шавь гэдгээ батлан харуулдаг.

Сүм саяхан ЛГБТ (лесби, гомо, бисексуал, транс-жендер) хүмүүсийн болон уламжлалт шашны ойлголттой хүмүүсийн аль алиных нь эрх ашгийг бодолцсон



хуулийг дэмжсэн. Энэ хууль нь ЛГБТ хүмүүсийг хүйсийн чиг хандлага, өвөрмөц байдлаасаа болж ажлаасаа халагдах эсвэл орон байр олж чадахгүй байхаас хамгаалдаг. Үүнтэй нэгэн адил энэхүү хүчирхэг хууль нь шашны сүсэг бишрэлийг мөн шашны итгэл үнэмшилдээ үнэнч байх эрхийг хамгаалдаг.¹²

Аль аль тал нь хүссэн үр дүндээ хүрээгүй ч бидний ЛГБТ хүмүүстэй мөн Ютагийн хууль тогтоох байгууллагатай хамтран ажилласан нь чухал зарчмууд дээр харилцан буулт хийлгүйгээр нийгмийнхээ санал зөрөлдөөнийг намжаахад тусалсан.¹³ Бид хувь хүний шашны зарчмуудаа хөсөр хаялгүй, нэг нэгнээ хайрлаж чадна. Мөн бид бусдыг дорд үзэлгүйгээр эдгээр зарчмынхаа тухай ярьж болно.

Есүс Христ бусдыг хайрлахын төгс жишээ байсан. Тэрээр бидний хүн нэг бүрийн гэм нүглийн төлөөсийг төлөх хүнд хэцүү үйл явцыг эхлүүлэхээсээ өмнө Дээгүүр өнгөрөх баярт буюу Сүүлчийн зоогонд оролцохоор мөн мөнх бус байдлынхаа хамгийн сүүлчийн зааврыг өгөхөөр төлөөлөгчидтэйгөө уулзжээ. Түүний сургаалд “Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна” (Иохан 13:34) гэх амьдралыг өөрчлөх тунхаг байв.

Бид өөр өөр үзэл бодолтой хүмүүсийг хүндэлж эсвэл тэднийг гомдоолгүйгээр эмэгтэй, эрэгтэй хүний



хоорондын гэрлэлтийн ашиг тусын талаар тодорхой мөн үнэн сэтгэлээсээ ярьж чадна. Итгэл үнэмшил, зан заншлаасаа үл хамааран ах, эгч, дүүсийн хувьд бид нэг нэгнээ ойлгохыг хичээх хэрэгтэй. Эцсийн эцэст, гэрлэсэн байна уу эсвэл ганц бие байна уу хамаагүй, бид бүгд Бурханы гайхамшигт төлөвлөгөөний нэгэн онцгой хэсэг билээ.

Дүгнэлт

Бошиглогч Иосеф Смит болон түүний ах Хайрум 1844 оны 6-р сарын 27-нд мужийн түр саатуулах байранд байхдаа танхайрагчдад алуулжээ. Тэднийг нас барсны дараа хавчлага, дарамт, танхайрал Сүмийн гишүүдийг Науву ариун сүмийг барьж байх үед заналхийлж байв. Тэд ариун сүмийг орхиж явна гэдгээ мэдэж байсан ч үргэлжлүүлэн барьсаар байсан. Танхайрагчдыг хөөхөөс өмнө тэд гэр бүлээрээ мөнхөд нэгдэхийн тулд ариун нандин амлалтуудыг өгөхөөр ариун сүмд өдөр, шөнөгүй орж байлаа.¹⁴

Аав, ээжийн маань талын элэнц эцэг, эх Солт Лэйк Валли руу аянд гарахаасаа өмнө зовлон шаналал, сорилт бэрхшээлийн агуу их төлөөсийг төлсөн юм. Анхдагч гэр бүлүүд үхэл хагацлыг үзэж, үр хүүхэд, хань ижил, эцэг эх, өвөө эмээ, найз нөхдөө эзгүй цөлд буушлан явсан ч аянаа үргэлжлүүлсэн.

Биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн зохиосон тэнгэрлэг төлөвлөгөөнд итгэх итгэл нь тэдэнд аймшигт сорилттой тулгарах зоригийг өгсөн билээ. Тэд хавчлага дарамтгүйгээр Бурханыг хайрлаж, Түүнд үйлчилдэг гэр бүлийг өсгөн хүмүүжүүлэх газрын эрэлд гарсан юм. Өмнөх замыг маань харуулсанд би тэдэнд талархдаг.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн сургаал, шашны номлол гэр бүлээр эхэлж, гэр бүлээр төгсдөг. Би түрүүнд хэлсэн зүйлээ давтан хэлье. Бид энэ дэлхийд төрөхөөсөө өмнө Бурханы сүнсэн хүүхдүүд болж, мөнх бус байдлын өмнөх гэр бүлд амьдарч байсан бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн хувьд бид энэ дэлхийд байхдаа Бурханы зарлигуудыг сахидаг хүмүүст амласан адислалуудыг хүлээн авахаар буцаж явахад бэлтгэх ёстой гэдэгт итгэдэг.

Энэхүү мэдлэг нь биднийг нас барсныхаа дараа Бурханы ариун нандин оршихуй руу эргэж очин, бидний төлөөх Түүний төлөвлөгөөний жинхэнэ зорилгыг баттай мэдэх гэр өдөрт бэлтгэх болно. Мөн гэр бүлийн тунхагт тэмдэглэсэнээр “Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах арга замыг ямагт хэрэгжүүлэгтүн хэмээн уриалан дуудаж байна”.¹⁵ ■

2015 оны 10-р сарын 27-нд хэлсэн үгээс эш татав.

ЭШЛЭЛҮҮД

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Liahona*, 2010 оны 11-р сар, 129.
2. “I Lived in Heaven,” *Children’s Songbook*, 4.
3. *Миний сайн мэдээг номлол: Номлолчийн үйлчлэлд зориулсан удирдамж* (2004), 53.
4. “Pope Francis’s Homily at the Family Synod’s Opening Mass,” *Catholic Herald*, 2015 оны 10-р сарын 4, catholicerald.co.uk.
5. “Basic Beliefs: Family,” Southern Baptists Convention, sbc.net/aboutus/basicbeliefs.asp.
6. *Obergefell et al. v. Hodges*, 576 U.S. (2015), supremecourt.gov.
7. “Teacher, School Sued over Gay Fairy Tale,” NPR, 2006 оны 4-р сарын 27, npr.org-ийг үзнэ үү.
8. “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын гэрээ,” 18-р зүйл, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, ohchr.org.
9. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” 129.
10. Кэвин Жөүнс, “LGBT Grant-maker Wants to Win Religious Liberty Fight within Three Years,” Catholic News Agency, 2015 оны 7-р сарын 29, catholicnewsagency.com.
11. Далин Х.Өүкс, “Бусдыг хайрлаж, өөр үзэл бодол бүхий хүмүүстэй хамт амьдрах нь,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 11-р сар, 28.
12. Дэннис Ромбой, “LDS Church, LGBT Advocates Back Anti-Discrimination, Religious Rights Bill,” 2015 оны 3-р сарын 4-ний *Deseret News*-ийг үзнэ үү.
13. “Utah Lawmakers Introduce Bill Balancing Religious Freedom and Nondiscrimination Protections,” 2015 оны 3-р сарын 4, mormonnewsroom.org-ийг үзнэ үү.
14. *Church History in the Fulness of Times Student Manual*, 2 дахь хэвлэл (Сүмийн Боловсролын Системийн гарын авлага, 2003), 302-304-ийг үзнэ үү.
15. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” 129.





ИТГЭЛИЙН ХӨРӨГ

Аманда өсвөр настай байхдаа амьдрал хүнд хэцүү болох тусам Сүмээс холдож, шинэ зүйлс туршиж болжээ. Хэдэн жилийн дараа Амандагийн сэтгэл эзгүйрсэн мэт санагдах болов. Аз жаргал олох замнал нь нэгэн чухал асуултаас эхэлсэн байна.

КОДИ БЭЛЛ, ГЭРЭЛ ЗУРАГЧИН

Аманда Жири

Өмнөд Африк, Кэип Таун

Би ойролцоогоор 8 жил идэвхгүй явсан. Тэр үед би буруу хүмүүстэй нөхөрлөж, ээж минь бас эдгэшгүй өвчнөөр өвчилсөн. Би сэтгэлээр ихэд унаж, зүрх сэтгэлээ хоосон оргиж байгааг мэдсэн юм. “Би хэзээ хамгийн сүүлд үнэхээр аз жаргалтай байсан бэ?” гэж би бодох болов.

Харин дараа нь би Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт байснаа бодсон юм. Яг тэр үед би хамгийн сүүлд үнэхээр аз жаргалтай байснаа ухааран ойлгов. Дараагийн ням гарагт би Сүмд буцаж очихоор шийдлээ. Би салбарын ерөнхийлөгчтэй уулзаж, наманчлалын замаа эхлүүлсэн.

Хэсэг хугацааны дараа намайг Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт ажиллуулахаар дуудав. Залуу эмэгтэйчүүдийн уриагаа унших үед би тэр даруй санасан! Өнөөдөр ч гэсэн би энэ уриаг унших болгонд Сүм бол миний байх ёстой газар гэсэн баталгааг хүлээж авдаг.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Аманда аз жаргалыг хэрхэн эрэлхийлсэн талаар liahona.lds.org-оос үзнэ үү.

Хэрхэн аз жаргалтай болох талаар lds.org/go/11839 дээрх ерөнхийлөгч Монсоны үгээс илүү ихийг суралцана уу.

НЭГ НЭГНИЙХЭЭ ЗАЛБИРАЛД ХАРИУЛСАН НЬ

Би Иллинойн Чикагогийн Өмнөд Номлол дахь номлолоо дуусгаж байхдаа өмнө нь үйлчилж байсан бүсдээ зочлон очиж, Трэмилогийн гэр бүлтэй оройн хоол идэх онцгой зөвшөөрөл авсан юм. Би тэдний тойрогт бүтэн жил үйлчилсэн бөгөөд тэдэнтэй ойртож дотноссон байлаа.

Оройн хоолны үеэр Трэмило ах намайг гэртээ харих замдаа ядаж нэг аз жаргалын захиас хуваалцаарай хэмээн урамшуулав. Их Эзэн онгоцонд маань миний тусалцаа хэрэгтэй хэн нэгнийг суулгана гэж тэр хэлсэн юм. Би ч түүнд хуваалцана гэдгээ амлав.

Би тэр үеэс эхлэн Чикагогоос явах хүртлээ номлолд үйлчлэхийн тулд гаргасан золиослолыг маань Их Эзэн хүлээн авсан гэсэн баталгааг авахаар залбирч байсан билээ.

Гурван долоо хоногийн дараа би гэрт маань хүргэх онгоцондоо орлоо. Суудалдаа дөхөж очтол

хажуу талын суудал дахь хүн над руу хараад, “Үгүй байлгүй дээ! Итгэмээргүй юм!” гэв.

Би ч дотроо “Өө, за за. Тэр ч мормончуудыг үзэн яддаг бололтой” гэж бодлоо. Намайг суухад тэр өөрийг нь Кэлли гэдэг мөн саяхан хөрвөгдсөн гэдгээ хэлэв. Хажууд нь номлогч суусанд тэр ямар их баярлаж байгаагаа бас илэрхийллээ. Кэлли надад хамгийн сүүлд хажууд нь суусан хүн мормончуудын эсрэг үзэлтэй, түүний шинээр олсон итгэлийнх нь талаар үзэл бодлоо хуваалцахдаа найрсаг бус байсан тухай хэлэв. Сэтгэл санаа нь тавгүйтсэн байсан ба асуух зүйл ч байлаа. Тэр хариулт олж, сэтгэл санаагаа тайвшруулахаар залбирч байсан аж.

Би дотроо залбираад, сайн мэдээ үнэн болохыг мөн Бурхан түүнийг болон үр хүүхдүүдээ хайрладаг талаар гэрчиллээ. Би бас Тэрмило ахын өгсөн зөвлөгөөг түүнд


уламжлав. Бурхан энэ онцгой мөчийг зөвхөн түүнд зориулан бэлдсэн гэдгийг би хэллээ.

Кэллигийн нүдэнд нулимс хуран, надад талархаж байгаагаа илэрхийлсэн юм. Тэр бас надад “Чи сайн номлогч байсан гэж надад харагдаж байна. Их Эзэн чиний золиослолыг хүлээн авсан” гэж хэлэв. Яг тэр агшинд би намайг гэх Бурханы агуу хайрыг мэдэрсэн юм. Харин энэ удаад би уйлж билээ. Би нулимс дуслуулан, Кэлид баярлаж талархсанаа илэрхийлж, түүнийг залбирлын минь хариулт байсан гэдгийг хэлэв. Би түүний өөр хэдэн асуултад хариулаад, э-мэйл хаягаа солилцсон юм.

Онгоц ч газардаж, түүнийг дараагийн онгоцондоо суухад бид гараараа даллан үдсэн билээ. Тэнгэрлэг Эцэг биднийг ийм сэтгэл уярам байдалаар адисалсанд би үргэлж талархаж байх болно. ■

Лэви Кэмптон, АНУ, Аризона

Суудалдаа дөхөж очтол хажуу талын суудал дахь хүн над руу хараад, “Үгүй байлгүй дээ!” гэв.



ӨВЧТЭЙ ХҮҮХДЭЭ АСРАНГАА ДУУДЛАГАТ АЖЛАА ХИЙСЭН НЬ

Би тойргийнхоо Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн зөвлөхөөр үйлчлэхээр дуудагдахдаа дуудлагыг хүлээн авсан ч, хэрхэн хийх вэ гэдэгтээ санаа зовж байлаа. Надад бэлэн биш юм шиг санагдаж байсан бөгөөд би сорилт бэрхшээлтэй тулгараад байв.

Уг дуудлагыг хүлээж авахаас гурван сарын өмнө амь насанд ихэд халгаатай жирэмслэлтийн дараа бяцхан хүү Николас маань мэндэлсэн юм. Түүнд байнгын эмнэлгийн асаргаа хэрэгтэй байв. Төрснөөс нь хэдэн долоо хоногийн дараа нүдний давхраа дээр нь жижигхэн улаан толбо гарч, бага багаар томорсон юм. Хүүхдийн эмч маань энэ нь хоргүй хавдар бөгөөд Николасыг нэг нас хүрэхэд аяндаа алга болно гэж бидэнд хэлэв. Харин хавдар хурдацтай томорч байлаа. Хавдар нь нүдний ухархайгаар тарж, эмчлүүлэхгүй бол хараагүй болгох байв.

Бид химийн эмчилгээ хийлгэх хэцүү шийдвэр гаргасан. Николасын турьхан биенд эмчилгээ таарахгүй байв. Тэр өдөр бүр халуурч, байнгын халдвар авч, жин нь байх ёстойгоосоо бага байлаа. Эмчилгээнээс болж тэр их уйлах болсон юм. Энэ нөхцөл байдалд дуудлагаа хийх улам бүр хэцүү болов. Би яаж хийхээ ч сайн мэдэхгүй байлаа.

Аз болж нөхөр маань намайг дэмжив. Үргэлжлүүлэн хийх нь зөв болохыг бид хамтдаа мэдэрсэн.

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч ч бас намайг дэмжсэн. Тэр бол итгэлтэй, тэвчээртэй эгч байсан. Тэр надаас өөртөө байгааг ч мэдэхгүй байсан тэр зан чанаруудыг олж харж мөн бодож байгаагүй арга замаар үйлчлэхэд минь тусалсан юм.

Долоо хоног бүр залуу эмэгтэйчүүдтэй байх нь надад тариа, үзлэг, эмч гэх мэт нэг хэвийн байдлаас гарахад тусалсан. Энэ нь намайг өөрөө өөрийгөө өрөвдөх эсвэл яагаад ийм зүйл миний бяцхан тэнгэр элчид тохиолдож байгааг асууж цагаа дэмий үрэхээс холдуулсан билээ. Миний дуудлага адислал байсан бөгөөд нэг л мэдэхэд Николас маань өсөж томрон, эмчилгээ хийгдэж дууссан байв. Николас эрч хүчээр дүүрэн, аз жаргалтай, эрүүл саруул хүү болсон юм.

Тэнгэрлэг Эцэгийн энэ зоригт охидод үйлчилснээр надад сэтгэл дундуур байдлаасаа салж, найз нөхдийн мөнхийн харилцааг үүсгэж, авьяасаа нээн, эх болон эхнэр хүн гэсэн үүрэг хариуцлагаа ухамсарлан, илүү сайн ажиллахад тусалсан билээ.

Их Эзэн биднээс сорилт бэрхшээлийг үргэлж холдуулаад байдаггүй ч нүүр тулах хүч чадлыг өгөхөд үргэлж бэлэн байдгийг би бүхий л сэтгэл зүрхээрээ мэднэ. ■

Ариэл Куэроз Майэр Фишер,
Бразил, Санта Катарина



Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн дуудлагаа хийхэд улам бүр хэцүү болов. Би яаж хийхээ ч сайн мэдэхгүй байлаа.

ДЭЭВЭР ДЭЭР ЗАЛБИРСАН МИНЬ

Намрын нэгэн бороотой өдөр би байшингийнхаа дээврийн өрөөнд ороод, ус гоожиж байгааг харав. Ус хоёр яс модны дундах дээврийг тогтоосон хадааснаас дусалж байлаа. Жилээс жилд би байшиндаа олон удаа засвар хийж байсан бөгөөд шинэ төсөл эхлүүлэхээс айхгүй байв. Гэхдээ тэр үед би хувийн асуудалтай тулгарч, өөрөө өөртөө итгэх итгэл дутаж байсан юм. Хэдийгээр өвөл болохоос өмнө ямар нэгэн арга хэмжээ авах хэрэгтэй гэдгийг би мэдэж байсан ч ус гоожиж байгаа дээврийн хэсгийг засах ажлыг хийх сэтгэл зүйн бэлтгэлгүй байв.

Нэг, хоёр долоо хоногийн дараа би цаасны хутга, шпатель, дээврийн давирхай хийж дүүргэсэн силиконы буутай дээвэр дээрээ гарлаа. Гоожиж байгаа газрыг олоод, давирхайг түрхэхэд л болчихно гэж би бодсон юм. Гэхдээ би хаанаас

гоожиж байгааг нь мэдэх аргагүй байлаа. Би ч сэтгэлээр унав. Би түр зогсоод, гоожиж байгаа газрыг янзлахын тулд Их Эзэнээс зөв газрыг зааж өгөхийг хүсэж залбирсан юм. Би Түүнийг тэр газрыг шууд зааж өгнө байх гэж бодов. Яг тэр үед миний толгойд “шалгаж үз” гэж хэлэх шиг болсон.

Энэ нь миний хүсэж байсан хариулт биш байсан ч би эргэн тойрноо шалгаж эхэллээ. Миний харц агааржуулагч дээр тусав. Би агааржуулагчийн хажуу талын хоёр шургаагийг авч, гоожиж байгаа газрыг оллоо. Хуучирч хатсан давирхайг хусан, шинээр ахиухан түрхэв. Би бас шургааг моднуудыг солин, цаг ч хүрэхгүй хугацаанд ажлаа хийж дуусгаж билээ. Сэтгэл санаа сэргэж, асуудлыг шийдэхийн тулд хийсэн ажлаараа өөрөөрөө бахархав. Дараа нь бороо орох үед дээвэр өөд харахад хуурай байлаа!

Би “Асуухаас өөрөөр санаа тавиагүй” (С ба Г 9:7) Оливер Каудеригийн талаар бодов. Яг түүнтэй адил би Их Эзэнээс залбиралд маань надаас юу ч шаардалгүйгээр шууд хариулахыг хүсэж байлаа. Дараа нь би хичээл зүтгэл гарган, “тунгаан бодо[ж]” (С ба Г 9:8), шалгаж үзэхэд сэтгэл маань хэрхэн сэргэсэн талаар бодсон юм. Би Их Эзэн бидний өмнөөс бүхнийг хийхгүй гэдгийг мэдэж авсан. Тэрээр бидэнд тусалж, удирдан залах ч, бид хувь хүний хувьд өсөж хөгжихийн тулд өөрсдийн зүгээс чадах бүхнээ хийх ёстой. ■
Валиант К.Жеүнс, АНУ, Мичиган

Би гоожиж байгаа газрыг олох хэрэгтэй байсан ч хаана байгааг нь мэдэхгүй байсан учраас түр зогсон, залбирав.



АМЬДРАЛ МИНЬ ИНГЭЭД ТӨГСЛӨӨ ГЭЖ ҮҮ?

Би хоёр хөөрхөн хүүхэдтэй эрүүл саруул аав мөн гайхамшигтай, ажилсаг эхнэрийн нөхөр нь байлаа. Би тогтмол орлоготой сайхан ажилтай байв. Амьдрал төгс санагдаж байсан ч намайг тархи, хүзүү орчмын ховор төрлийн хавдар болох хамар залгиурын хавдартай гэж оношлох үед амьдрал орвонгоороо эргэж эхэлсэн.


Тэр үед би бишопын зөвлөхөөр үйлчилж байсан бөгөөд сүм дээр жил тутмын сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж байхдаа хүчтэй өвдөж эхэлсэн юм. Би эмчид үзүүлж, лабораторийн олон шинжилгээ өгсний дараа тэр надад хамар залгиурын 4-р шатны хавдартай болохыг мэдэгдэв. Миний санаа зовж мөн айж байлаа. Амьдрал минь ингээд төгслөө гэж үү, нас барсны минь дараа гэр бүл маань яах бол гэж би шаналж байлаа. Би зөвхөн Тэнгэрлэг Эцэгт залбирснаар удирдамж, тайтгарал авч байв.

Би гурван өдрийн турш тасралтгүй залбирсны эцэст нэгэн намуун зөөлөн дуу хоолой “Бүү ай” гэж хэлж байгааг мэдэрсэн юм.

Тэр үеэс хойш үхлийн тухай айдас оюун санаанаас минь арилж билээ. Надад хэцүү хэвээрээ л байсан. Хоол идэж чадахгүй, унтаж ч чадахгүй хүчтэй өвдөх үе байсан ч би хэзээ ч бууж өгөөгүй бөгөөд Бурханаас нүүр буруулаагүй. Тэр надад тусалсан.

Би хавдартайгаа 18 жил гаруй хугацааны турш тэмцэж байна. Бурхан намайг хэр удаан амьдрахыг зөвшөөрөхийг би мэдэхгүй ч ах, эгч нартаа үйлчлэх боломжтой байгаадаа баяртай байна. Тэнгэрлэг Эцэг хэзээ ч биднийг орхидоггүй. Хэрэв бид Бурханаас адислал авахыг хүсэж байвал Түүнийг орхиж болохгүй. ■

Самсон Хо, Хятад, Хонконг



Төлөвлөснөөсөө эрт гэртээ ирсэн нь

Дэстини Яарбро

Аав, ээж хоёр маань хоёулаа номлолд үйлчилсэн. Би хүүхэд байхдаа тэдний номлолын түүхүүдийг сонсож, бүрэн цагийн номлогчоор Их Эзэнд үйлчлэх өдрийг мөрөөддөг байлаа.

Номлолдоо бэлтгэж байсан цаг амьдралын минь хамгийн сайхан үе байсан. Би Их Эзэнд урьд урьдынхаас илүү ойртсон. Би Унгарын Будапешт номлолд номлолын дуудлагаа хүлээн авсан бөгөөд өөрийгөө бүхэлд нь Тэнгэрлэг Эцэгт зориулах шийдвэр төгс Провогийн Номлогчийг Бэлтгэх Төвд (НБТ) орсон юм.

НБТ-д байсан хугацаа маань үнэхээр сүнслэг туршлага болсон. Би Их Эзэнд ойртох тусмаа Түүний хүссэн бүх зүйлийг хийхэд бэлэн байгаага мөн унгар хүмүүсийг бүх зүрх сэтгэлээрээ хайрлах болно гэдгээ амласан юм.

НБТ-д байх хугацаа дуусахаас өмнө бие маань өвдөв. Биеийн байдлаа дээрдүүлэх гэж хэсэг хугацаанд гэртээ байсны дараа би Унгар дахь номлолоо үргэлжлүүлэх боломжтой болсон. Их Эзэний өдөр

тутам үзүүлдэг нигүүлсэл, гайхамшгуудыг хэрхэн таньж мэдэхийг заасан Саншайн Нэстор хэмээх гайхалтай сургагч надтай таарсан юм.

Хэдэн сарын дараа би дахиад л өвдөв. Нэстор эгч бид хоёр чадах чинээгээрээ ажиллаж байсан ч дахиад л гэртээ харих шаардлагатай болсон.

Би номлолдоо “бүрэн” үйлчлээгүй учраас Их Эзэнийг сэтгэлээр унагасан байх гэж бодож байлаа. Өвдөөгүй байсан бол зааж “болох байсан” унгарчууд байсаар байгаа гэдэгт би итгэлтэй байв. Их Эзэн номлогчдоо хамгаалдаг учраас би эдгэрэх хангалттай итгэлтэй байж чадаагүй юм болов уу ч гэж гайхаж байлаа. Их Эзэнд өгөх золиослол маань жил хагас ч болж чадахгүй мөн хүсэн хүлээсэн номлолоо орхих хэрэгтэй болно гэж би хэзээ ч бодож байгаагүй.

Гэртээ утга учир, зорилго чиглэлтэй байхыг эрэлхийлсэн нь

Би онгоцноос буугаад гэртээ харихдаа амьдралынхаа хамгийн

Гэртээ номлолоосоо эрт буцаж ирсний дараа Их Эзэнд үргэлжлүүлэн үйлчилж, утга учир, зорилго чиглэлтэй байх олон арга байдаг.

чухал ажлыг номлолын талбарт үлдээгээд явлаа гэж бодож байлаа. Хэдийгээр хугацаа орсон ч би амьдралыг маань утга учиртай болгох ажил гэрт маань ч бас байгаа юм байна гэдгийг ойлгосон юм.

Номлолоосоо эрт ирсэн шалтгаан чинь ямар байх нь хамаагүй, энэ туршлагаа өсөлт хөгжлийг чинь хойш ухраах бус *урагиш* ахиулах алхам болгох шийдвэрийг өнөөдөр гарга. Би эрүүл мэндийн

шалтгаанаар гэртээ ирсэн ч зарим хүн зөрчил гаргасан зэрэг олон янзын шалтгаанаар гэртээ ирсэн байдаг. Иймээс, зарим нэг санаа нь та нарын нөхцөл байдалд тохирохгүй байж болно. Гэрээсээ Их Эзэнд үйлчлэх арга замуудыг олохын төлөө Түүнд хандан залбир. Жишээлбэл, хэрэв та зөрчил гаргасан мөн ариун сүмд орох зохистой болоогүй байгаа бол ариун сүмийн эргэн тойрноор алхаж, нэгэн өдөр Түүний ариун өргөөнд орох амлаал өгснөөр утга учир, зорилго чиглэлтэй болж болно.

Судар унших, залбирах, сүмд явах зэргээс гадна аяллын маань дараах алхам бүр эдгэрэхэд чухал байсан.

1. Холбоотой байх

Амьдралаа утга учиртай болгосон эхний алхам маань Унгар дахь гэгээнтнүүд, номлогчидтой холбоотой байх явдал байсан. Би удаан хугацааны турш бэлтгэлийн өдрүүдээрээ Нэстор эгч болон НБТ-ийн хамтрагчдаасаа э-мэйл хүлээн авахыг тэсэн ядан хүлээсэн. Зарим үед

хамтрагчдынхаа номлолын талаар уншихад эсвэл санан бэтгэрч байгаа унгарчуудтайгаа ярихад амар хялбар байгаагүй гэдгийг би хүлээн зөвшөөрөх ёстой. Гэхдээ эргээд харахад, тэнд болж байгаа гайхамшгуудын талаар сонсох нь эдгэрэхэд маань нэн чухал байсныг би ухаарсан юм.

2. Онлайнаар индексжүүлэх

Миний дүү ухаалаг ээжийн маань найрсаг уриалгыг хүлээн аваад, намайг индексжүүлж эхлэхэд ятгасан. Эхэндээ би түүнийг баярдуулахын тулд л олон нэр индексжүүлж байсан ч нэгэн өдөр унгар нэрсийн бүртгэл дэлгэцэн дээр маань гарч

ирэх тэр үед Сүнс намайг бүрхэн авч, хөшигний *нөгөө* талд байгаа унгар сүнснүүдэд туслах боломжтой хэвээр байгааг надад заасан.

3. Зорилго тавих

Номлолын дараа миний номлолын өмнө тавьсан бүх зорилго эрүүл мэндийн байдлаас болж биелэхгүй юм шиг санагдаж байв. Би хэвтэрт байх үедээ ч гүйцэлдүүлэх боломжтой зорилгууд байгаа гэдгийг ухаарсан. Би *Есүс Христийн тухай* унших зэрэг “хэвтэрт байхдаа ч хийх” зорилгууд тавьсан бөгөөд өдөр бүр зорилгынхоо төлөө ажиллаж байв.



4. Сургуульдаа явж эхлэх

Номлолын өмнөх миний нэг зорилго бол коллеж төгсөх байлаа. Өвчтэй мөн эмчид байнга үзүүлэх шаардлагатай байдаг учраас хичээлдээ очиж суух боломжгүй байсан бөгөөд аав намайг Бригам Янгийн Их Сургуулийн бие дааж судлах онлайн хичээлүүдийг авахад урамшуулан дэмжсэн. Үүнээс гадна хэвтэрт байхдаа биелүүлэх боломжтой олон зорилго надад байсан бөгөөд би урьд нь боломжтой гэж бодож байснаасаа илүү олон номлолын өмнөх зорилгоо биелүүлэх чадвартай гэдгээ ухаарсан.

5. Онлайн номлолд үйлчлэх

Нэгэн өдөр сүм дээр нэг эгч ээж дээр маань ирээд, “Дэстини индексжүүлэх онлайн номлолд үйлчлэх боломжтой гэдгийг та мэдсэн үү?” гэж асуув. Энэ гэнэтийн асуулт залбирлын минь хариулт байлаа. Би индексжүүлэхэд туслах Сүмийн үйлчлэлийн номлогчоор есөн

сарын хугацаанд Их Эзэнд үйлчлэх боломжтой байсан. Миний хийж чадах номлол энэ байсан юм!*

6. Номлолд бэлтгэх ангид заах

Би эрүүл мэндийн байдлаа илүү сайн зохицуулж сурснаар онлайн номлолоо хийх явцад техникийн коллежид суралцаж эхэлсэн. Мөн надаас ойролцоох институтэд номлогчийг бэлтгэх ангид заахыг хүссэн юм. Ингэж заах нь надад номлогчийн ажлыг хийх урам зориг минь дундраагүй бөгөөд хэдийгээр богинохон ч гэсэн номлол минь суралцагчдад үнэ цэнтэй байх олон туршлагыг надад өгснийг ухаарсан.

7. НБТ-д сайн дурын ажил хийх

Би гэрийнхээ ойролцоох коллежид нэг улирал амжилттай суралцсаны дараа БЯИС-д суралцахаар АНУ-ын Юта руу нүүсэн юм. Анх би Провогийн Номлогчийг Бэлтгэх Төвийн хажуугаар явахдаа гэнэтийн сэтгэл хөдлөлөө мэдрэхгүйгээр явж чадахгүй байв. Гэвч би НБТ-д долоо

хоног бүр сайн дураараа ажиллаж эхэлсэн бөгөөд хайрт Унгар улс руу маань томилогдсон гайхалтай номлогчидтой уулзах нь намайг анагааж байлаа.

8. Ариун сүмийн ажлыг хий

Бараг 150000 нэрийг ариун сүмд зориулан бэлтгэсэн Унгарын эгч Эдит надаас ариун сүм рүү зарим нэрээ авч явахыг хүссэн юм. Эдгээр унгар хүнд авралын ёслолыг хийлгэнэ гэдэг үнэхээр баяр баясалтай хэрэг байсан!

Түүний ажлаар дамжуулан аажим аажмаар эдгэрсэн нь

Номлолд үйлчилнэ гэдэг нь амьдралын минь хамгийн чухал мөрөөдөл байсан бөгөөд зорьсноосоо эрт гэртээ ирээд сэтгэлээр унах нь мэдээж юм. Хэсэг хугацаанд надад номлолын талаар ярихад хүнд байсан. Би бүтэлгүйтсэн гэсэн мэдрэмжийг даван туулахын тулд хичээх хэрэгтэй байлаа. Би хугацаанаас



илүүтэй, үйлчлэх хүслээрээ номлолын үнэ цэнээ үнэлж цэгнэхийг сурах ёстой байсан. Би тухайн үед үүнийг ойлгоогүй ч амьдралаа утга учиртай болгох эдгээр алхам намайг эдгээсэн юм.

Хэдэн жилийн турш би Унгар руу буцаж явахад сэтгэл санааны хувьд хэцүүхэн байх болно гэж санаа зовниж байлаа. Эцэст нь тийшээ очсоныхоо дараа хоёр дахь өдөр нь би эмзэглэхгүй байгаага мөн буцаж ирсэндээ баяртай байгаагаа ухаарсан юм. Тэнгэрлэг Эцэг надад Аврагчийн Цагаатгалын эдгээх хүчийг мэдрэх боломжийг олгосон гэдгийг би мэдсэн. Би Есү Христийн Цагаатгалаар дамжуулан бүх зүйл эцэст нь сайнаар төгсөх болно гэдгийг мэднэ. ■

Зохиогч нь АНУ-ын Аризонад амьдардаг.

*Хугацаанаасаа өмнө ирсэн олон номлогч Сүмийн үйлчлэлийн залуу номлогчоор үйлчилж байна. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг бишоп, салбарын ерөнхийлөгчөөсөө авна уу.



ХҮЛЭЭН АВАГДАХУЙЦ ӨРГӨЛ

“Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлж байна, миний нэрэнд ажил хийлгэхээр хүмүүний үрсийн хэнд нь ч би зарлиг өгөхөд, мөн хүмүүний тэдгээр үрс өөрсдийн бүхий л хүчин чадалтайгаар мөн тэдэнд байгаа бүхэнтэйгээр одож, мөн хичээл зүтгэлээ үл орхин уг ажлыг гүйцэтгэхэд, мөн дайснууд нь тэдэн дээр ирж мөн уг ажлыг гүйцэтгэхэд нь тэдэнд саад учруулах үед, болгоогтун, хүмүүний тэдгээр үрсийн гараас уг ажлыг цаашид үл шаардан, харин өргөлүүдийг нь хүлээн авах нь миний хүсэл зориг болой.”

Сургаал ба Гэрээ 124:49.

ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Дараах зүйлс бол бодож үзэх зүйлсийн жагсаалт юм.

- Номлогчид гутрах болон эдгэрэх цаг өг.
- Номлогчид хэр их хайртайгаа ойр ойрхон хэл.
- Түүнийг гадасны ерөнхийлөгч, бишоптойгоо ойр ойрхон уулзаж байхад урамшуулан дэмж.
- Номлогчоос гэртээ ирсэн шалтгаанаа хүмүүст мэдүүлэхийг хэр их хүсэж байгааг нь асуу.
- Бусдад уг номлогчийг гэртээ ирэх гэж байгааг мөн түүнтэй дахин уулзахаар сэтгэл догдлон хүлээж байгаагаа хэл.
- Номлолын сайхан бөгөөд хүнд хэцүү цаг үеийн аль алиных нь тухай ярилцах цагийг номлогчид гаргаж өг.
- Номлогчийг цаашид юу хийх талаараа залбирахад урамшуулан дэмжээд, номлолдоо буцаж очих эсэх талаар ямар ч шийдвэр гаргасан бай, түүнийг дэмж.

ТОЙРГИЙН ГИШҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Хугацаанаасаа өмнө гэртээ ирсэн номлогчид юу хэлэхээ бодож олох нь хэцүү байдаг. Тэдэнд гэртээ тавтай морилохыг урьж, хайраа илэрхийлэн, хийсэн үйлчлэлд нь талархсанаар өөрчлөгдөхөд нь тусалж болно.

Та номлогчийн гэртээ ирсэн шалтгааныг мэдэхгүй байж болох бөгөөд шалтгаан нь таны таамаглаж байснаас огт өөр байж болно. Тэдний эдгэрэх үйл явц өөрсдийнх нь төдийгүй Их Эзэн болон тэдний хоорондох зүйл бөгөөд тэдэнд тусламж дэмжлэгээ үзүүлэх хэрэгтэй гэдгээ санаж яваарай.

Номлогчид номлолын туршлагаа аюулгүй орчинд хуваалцах хэрэгтэй. Тэдэнд номлолынхоо тухай ярих хүртэл хугацаа хэрэгтэй гэдгийг ойлгоорой. Хэрэв та номлогчоос ангид түүхээ хуваалцахыг хүсэх гэж байгаа бол тэднээс хуваалцахад ямар байхыг урьдчилан асуугаарай.

ҮЙЛЧЛЭЛИЙН МАТЕРИАЛУУД

Удирдагчид хугацаанаасаа өмнө ирсэн номлогчдод туслах ойлголт, арга замуудыг ministering.lds.org-оос олж үзэж болно.

Институт сайн мэдээнээс суралцахад тань хэрхэн тусалдаг вэ?

Шашны институтийн ангиасаа илүү ихийг сурч мэдэх дараах гурван арга замыг туршаад үзээрэй.

По Ниэн (Филип) Чоу
Институт ба семинар

Өнөөдөр дэлхий олон талаараа . . . өмнө байснаасаа илүү их сорилттой болсон байна. Манай залуу эрэгтэй, эмэгтэйчүүдэд номлол, ирээдүйн аз жаргалтай амьдрал хоёрын аль алинд нь бэлтгэх замаас нь гажуудуулах илүү олон саад бэрхшээл тулгарч байна” гэж Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард хэллээ. Өнөөдөр бид урьд урьдынхаас илүү “Ариун Сүнсний өдөөлтийг хэрхэн сонсож, хариулахаа мэддэг”¹ болоход суралцах хэрэгтэй байна.

Сүнслэгээр илүү мэдрэмтгий болоход тань туслахаар Сүм шашны институтийг санал болгосон юм. Институт нь “Бурханы үгээр дамжуулан илүү утга учиртай [хувийн] туршлагатай болох”² боломжоор хангаж чадна.

Та институтийн хэд хэдэн ангиас сонгон суралцах боломжтой. Залуучуудын хэрэгцээ болон асуултуудыг ойлгодог багш нар судруудаас болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудаас суралцахад тань тусална.

Институтэд хийгдсэн шинэ хэн өөрчлөлт танд суралцахуйгаа өндөрт гарган, Есүс Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлэхийн тулд (1) курсийн судлах тэмдэглэл, (2) курсийн асуултууд, (3) хувийн суралцах төсөл зэргийг ашиглах боломж олгоно. Энэ гурван судлах сонголт нь танд сайн мэдээг судлах арга барилаа өөрийн болгож, Сүнс хэрхэн ажилладаг болохыг сурахад тусална.

Курсийн судлах тэмдэглэл

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г. Скотт

(1928–2015) бидэнд хүлээж авсан сүнслэг мэдрэмжээ бичиж тэмдэглэхийг уриалсан юм. “Сүнснээс суралцсан чухал зүйлсээ аюулгүй газарт бичиж авч бай. Та үнэ цэнтэй сэтгэгдлээ бичих тусам тийм сэтгэгдэл илүү олноороо төрөхийг харах болно.”³

Суралцагчид судруудыг судлах явцад төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэхийн тулд судлах тэмдэглэлийг (цаасан хэлбэрээр мөн Gospel Library апп байж болно) анги дээрээ мөн гэр орондоо ашиглаж болно. Филиппиний институтийн суралцагч Жэйми Дэнз судлах тэмдэглэл хөтлөхийн ач холбогдлыг олж харжээ. “Би судрын хэсэг, бошиглогчдын хэлсэн үгийн захиасыг бичиж тэмдэглэхгүй байж чаддаггүй. Яагаад гэвэл эдгээр нь миний сайн мэдээг судлах цар хүрээг тэлдэг.”

Японы Нагоя дахь Сэйчи Такахаши ахын институтийн суралцагчид тэмдэглэл хөтлөх дуртай. Учир нь энэ бол “суралцах үйл явцыг аяндаа бий болох” боломжоор хангадаг бөгөөд суралцагчдад



ангидаа суралцах мөн оролцох илүү их хүсэлтэй ирэхэд тусалдаг.

Өмнөд Италийн Таисиа Бартоломео “Би сурсан зүйлээ бичиж тэмдэглэснээр хэрэгтэй ойлголтуудаа хэрэгтэй үед нь илүү сайн санах боломжтой байдаг” гэж хэллээ. Ангийнх нь суралцагч Мариатэраса Санторо “Би тодорхой сүнслэг ойлголт, хувийн илчлэлтийг эргэн санахын тулд тэмдэглэлээ хардаг” гэж нэмж хэлэв.

Курсийн асуулт

Курс эхлэхэд өгдөг асуултууд суралцагчдыг курсийн турш тунгаан бодож, судлах сэдвээр хангадаг. Төгсгөлд нь суралцагчид хувийн болон Сүнсээр өдөөгдсөн хариу-туудаа бичээд, багшдаа хураалгадаг.

Өмнөд Италийн суралцагч Илариа Бэлломо “Эдгээр асуулт өөрийн амьдралыг, харин институ-тээс суралцсан зүйлс Есүс Христийг илүү сайн мэдэхэд тусалдаг гэсэн гэрчлэлээ тунгаан бодоход хүргэдэг” гэж тайлбарлав.

Солонгосын институтийн суралцагч Жинсэоп

Жэонг “Асуултууд надад сурсан зүйлээ илүү гүнзгий тунгаан бодож, үнэлж цэгнэхэд тусалсан. Энэ нь ойлгож мэдсэн зүйлээ дүгнэн, тунгаан бодож, тогтоох чухал цаг үе байсан” гэж хэллээ.

Суралцагчдын сүнслэг өсөлт хариултаас нь харагдаж байна. Солонгосын гадасны институтийн багш Сэонсим Канг эгч “Суралцагчдынхаа гэрчлэл, бодол санааг уншиж, тэндээс суралцах нь үнэхээр сайхан туршлага болсон” гэж хэллээ.

Суралцах хувийн төсөл

Институтийн олон суралцагч утга учиртай төслийг сонгон хийхийн тулд залбирдаг. Дэлхий даяарх суралцагчид хүсэл, сонирхолдоо тулгуурлан сайн мэдээтэй холбоотой урлагийн бүтээл, дуу хөгжим, видео бичлэг, олон нийтийн мэдээллийн

хэрэгслийн нийтлэлүүдийг бүтээсэн. Эдгээр төсөл суралцагчдыг ангид ойлгож мэдсэн зүйлсээ үйлдэл болгоход урьдаг. Жишээлбэл, нэг суралцагч “Есүс Христ ба үүрдийн сайн мэдээ” курсийн хавсралт болгон Аврагчийн хөрөг зургийг зурахаар шийдсэн байна.

“Мөнхийн гэр бүл” курсэд хамрагдсан нэгэн суралцагч “эмээтэйгээ мөн ойрын гэр бүлийн гишүүдтэйгээ хамт хичээлийн хагас жилийн турш бэлтгэснээр ариун сүмийн 40 лацдан холболтыг хийлгэхээр ариун сүм рүү аялах боломжтой болгож, мөн гэр бүлийг маань илүү ойр дотно болгосон” ариун сүм, гэр бүлийн түүхийн төслийг бүтээжээ.

Филиппиний институтийн суралцагч Синиа Авила Органис суралцах хувийн төсөл дээр ажиллах нь Бурханы үгийг судлах мөн авьяас чадвараа ашиглан Сүнс мэдрэх эрх чөлөөг олгосноор суралцагчдад “уян хатан байдлыг” санал болгодог гэдгийг онцоллоо.

Өндөр үр дүн

Эдгээр суралцах арга барилыг ашигласнаар таны сайн мэдээг судлах чадвар өсөж, гэрчлэл тань гүнзгийрэх болно. Та институтийн курсээр дамжуулан сайн мэдээг гүн гүнзгий судалснаар хэрхэн Бурханы үгийг амьдралдаа хэрэгжүүлж, бусдын амьдралыг адислахаа илүү сайн ойлгох болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. “Залуучуудын хамгийн агуу үеийнхэн,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 55.
2. “Teaching with Power,” lds.org/si/objective/elevate-learning/teaching-with-power.
3. Ричард Г. Скотт, “To Acquire Knowledge and the Strength to Use It Wisely,” *Лиахона*, 2002 оны 8-р сар, 12.



2018 ОНЫ МЮЧЕЛИЙН СЭДЭВ

ХРИСТЭЭС ИРЭХ АМАР АМГАЛАН



Ерөнхийлөгч Бонни Л.Оскарсон (голд); нэгдүгээр зөвлөх Кэрол Ф.Макконки (зүүн гар талд); хоёрдугаар зөвлөх Нийл Ф.Марриотт (баруун гар талд)



Ерөнхийлөгч Стэфэн В.Өүэн (голд); нэгдүгээр зөвлөх Дуглас Д.Холмс (зүүн гар талд); хоёрдугаар зөвлөх М.Жозэф Браф (баруун гар талд)

Нөхцөл байдал тань ямар байгаагаас
үл хамааран та үргэлж Есүс Христээс
амар амгаланг олж авч чадна.

Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлүүд

Үймээн самуун, маргаантай үзэл баримтлал, уруу таталт, төөрөлдүүлэх философоор дүүрсэн дэлхийд амар амгаланг олох амаргүй. Гэхдээ Сургаал ба Гэрээ 19:23 (2018 оны Мючелийн сэдэв) дээрх “Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун; Миний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхагтун, мөн надаар дамжин амар амгалан чамд байх болно” гэсэн Аврагчийн өгсөн амлалт амар амгаланд хүрэх тодорхой арга замыг өгдөг.

Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлүүдийн хувьд бид үүнийг үнэн гэдгийг гэрчилж байна. Бид үүнийг өөрсдийн амьдрал дээр харсан бөгөөд хэрэв та нар энэ загварыг дагавал Бурхан амьдралд тань амар амгаланг өгнө гэсэн амлалтаа биелүүлэх болно.

Та нарын дундаас олон хүн ирээдүйнхээ талаар санаа зовж байгаа байх. Мөн олон хүн гадаад төрх, чадвар, чадавхынхаа талаар боддог байх. Гэхдээ та нар юутай ч тулгарсан бай, амар амгаланг олох боломжтой. Энэ нь бүхий л асуулт, асуудлууд тэр даруй сарнин алга болно гэсэн үг биш ч та нар бүх зүйл шийдэгдэнэ гэсэн баталгааг сэтгэлдээ мэдэрч чадна. Хамгийн чухал нь та Есүс Христийн зөвхөн таныг гэсэн хайрыг мэдрэх бөгөөд энэ нь агуу их амар амгаланг авчирдаг.

Энэ шүлгийн хэсэг бүрийн тухай ярилцацгаая.

НАДААС СУРАЛЦ

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг мэдэх нь та нарын амьдралын аяны нэн чухал хэсэг юм. Их Эзэн: “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” (Иохан 17:3) хэмээн хэлсэн. Та нар Христийг илүү сайн танин мэдэх үедээ Түүний хэчнээн сайн, ухаалаг, сайхан сэтгэлтэй, хайраар дүүрэн болохыг ойлгоно. Түүнд итгэх итгэл тань өсөж, та нар Түүнийг болон Тэнгэрлэг Эцэгийг дагах илүү их хүсэлтэй байх болно.

МИНИЙ ҮГСИЙГ СОНС

Есүс Христ бидэнтэй судар, амьд бошиглогчид болон Ариун Сүнсээр дамжуулан ярьдаг. Бид эдгээр үгэн дээр найрлан, тунгаан бодож, амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Мормоны Ном “энэ дэлхий дээрх бусад бүх номоос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуур чулуу, түүнчлэн бусад ямар ч номоос илүүгээр, түүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох”¹ учраас та нар Аврагчийн үгсээс судлахдаа Мормон Номон дээр төвлөр. Ерөнхийлөгч Томас С.Монсоны 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр өгсөн Мормоны Номыг өдөр бүр унших урилга биднийг Христийн үгийг сонсож ойлгоход туслах болно.²

МИНИЙ СҮНСНИЙ ДАРУУ БАЙДАЛД АЛХ

Аврагчийн үгсийг сонсох нь зөвхөн Түүний үгэнд дуулгавартай

байлгахад биднийг өөрчилж эхэлдэг. Үүний тулд бид даруу байх хэрэгтэй. Энэ нь биднээс өөрсдийн замыг орхин, Түүний замаар алхахыг шаарддаг. Заримдаа бид өөрсдийнхөө замыг илүү сайн гэж боддог. Гэхдээ бид даруу байж, хаашаа ч хөтөлсөн бай Түүнийг дагах юм бол үргэлж хамгийн сайн зам дээр байх болно.

НАДААР ДАМЖИН АМАР АМГАЛАН ЧАМД БАЙХ БОЛНО

Энэ бол агуу амлалт: Хэрэв та нар суралц, сонс, Аврагчтай хамт алх гэсэн гурван зүйлийг хийвэл амьдралдаа амар амгаланг олно. Та нар хэчнээн их айдастай, итгэлгүй, сул дорой байлаа ч гэсэн Бурхан дэргэд тань байж, та нарыг харж халамжилна гэдгийг баттай мэдэх болно. Та нар өөртөө төдийгүй Есүс Христ, Түүний хайр, хүчинд итгэлтэй байж чадна.

Бид Сүмийн бүх өсвөр үеийнхнээс энэ шүлгийг чээжлээрэй хэмээн урьж байна. Үүнийг амьдралынхаа хөтөч болгон ашигла. Харанхуй манан та нарыг хүрээлэн, давшгүй мэт санагдах үед энэ шүлгийг дотроо санаж, загварынх нь дагуу Есүс Христийн бат бөх бөгөөд тодорхой суурин дээр өөрсдийн зангуут тавиарай. ■

ЭШЛ ЭЛҮҮД

1. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 303
2. Томас С.Монсон, “Мормоны Номын хүч,” 2017 оны 4 дүгээр сарын Ерөнхий чуулган, 73.




АВРАГЧААС
ИРЭХ АМАР
АМГАЛАН

НАДААС СУРАГТУН, МӨН МИНИЙ ҮГСИЙГ АНХААРАГТУН;
МИНИЙ СҮНСНИЙ НОМХОН ДӨЛГӨӨН БАЙДАЛД АЛХАГТУН,
МӨН НАДААР ДАМЖИН АМАР АМГАЛАН ЧАМД БАЙХ БОЛНО.

СУРГААЛ БА ГЭРЭЭ 19:23

Сургаал ба Гэрээ 19:23

Есүс Христээр дамжин амар амгаланг хүлээн авах хэд хэдэн түлхүүрийг Их Эзэн Иосеф Смитэд илчилсэн.



1 НАДААС СУРАЛЦ

“Бид энэ ‘Бурханаас ирсэн багш’ [Иохан 3:2] энгийн багшаас хавьгүй дээр нэгэн

байсан гэдгийг мэддэг. Бидэнд Их Эзэн Бурханаа бүх зүрх, сэтгэл, хүчин чадал хийгээд оюун ухаанаараа хайрлахыг мөн хөршүүдээ өөрсдийн адил хайрлахыг заасан Тэрээр Агуу Багш бөгөөд төгс амьдралын Үдгэр жишээ үзүүдэгч юм.

Бид Их Эзэний ‘Надаас суралц’ гэсэн эелдэг урилгад хариулснаараа Түүний бурханлаг хүчийг хүртэгчид болдог.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Learn of Me,” *Liahona*, 2016 оны 3-р сар, 4, 6.

2 НОМХОН ДӨЛГӨӨН БАЙДАЛ


Номхон дөлгөөн байдал нь “зовлон бэрхшээлтэй тулгарахад тэвчээртэй” (Судруудын удирдамж, “Номхон дөлгөөн, номхон дөлгөөн байдал,” scriptures.lds.org) байхыг багтаадаг.

Бид зовлон бэрхшээлээ гомдоллохгүйгээр мөн номхон дөлгөөн байдалд тэвчиж даван туулбал хөрвөгдөөд зогсохгүй, Тэрээр биднийг эдгээх болно (С ба Г 112:13-ыг үзнэ үү).

3 АЛХАГТУН

Есүс Христийг үнэн сэтгэлээсээ дагахад суралцах, сонсох аль аль нь чухал байдаг. Гэхдээ тэдгээр нь дан ганцаараа хангалтгүй. Бид сурсан, сонссон зүйлийнхээ дагуу алхаж, үйлдэх хэрэгтэй.

“Түүний замаар амьдрах нь ямагт зөв байдаг төдийгүй хэзээ ч оройтохгүй” (Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, “Шавь болох зам,” 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 85).



23 Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун; миний Сүнсний “номхон дөлгөөн байдалд” алхагтун, мөн надаар дамжин “амар амгалан чамд байх болно.

4 МИНИЙ СҮНС

Номхон дөлгөөн байдал нь “Ариун Сүнсний айлчлалыг” (Моронай 8:26) авчирдаг ба “Сүнсний үр жимс” (Галат 5:22–23-ыг үзнэ үү) юм.



5 НАДААР ДАМЖИХ

АМАР АМГАЛАН

“Амар амгаланг агуу эд баялаг, эрх мэдэл, хүч, алдар нэрээр олдоггүй.

Амар амгаланг баяр наадам, зугаа цэнгэл хөөж, амралт чөлөөт цаг ихтэй байснаар олж авдаггүй. Эдгээр зүйлийн алинд нь ч хамаг цагаа зориулаад төгсөшгүй аз жаргал болох амар амгаланг олж чадахгүй.

... Аврагч ... бол амар амгалангийн эх сурвалж бөгөөд бүтээгч нь юм. Тэр бол ‘Энхийн Жонон’ [Исаиа 9:6].”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Квинтин Л.Кук, “Хувь хүний амар амгалан бол зөв шударга байдлын шагнал мөн,” 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 34.

6 МИНИЙ ҮГСИЙГ АНХААРАГТУН

Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхэд сонсох чадвартай байх нь чухал. “Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17).

“Бурханы хүүхдүүд эхлээд сонсож сураад, дараа нь Их Эзэний үгээс суралцахын тулд сонсох хэрэгтэй” (Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон, Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч, “Listen to Learn,” *Ensign*, 1991 оны 5-р сар, 24).

АВРАГЧААС ИРЭХ АМАР АМГАЛАН

Бодлогоицронгуй ♩ = 72

Үг, аяыг Ник Дэй

Piano introduction in 4/4 time, key of B-flat major. The melody is in the right hand, and the accompaniment is in the left hand. Chords are indicated above the staff: Ab, Eb, Ab, Cm, Ab, Bb.

5

1. Ав - раг-чаас сур - вал Ам - га-ланг мэ - дэрнэ. Бид - ний нуг-лийг
 2. Га - ли - лын гуд - маар Ие - ру - са - лим руу Түүн - тэй хамт-даа

5

Ab Eb Ab Eb Ab Cm Ab

(хоёр дахь удаа тоглохдоо жижиг нотуудыг тоглоно)

8

үү - рэ - хэд Хай-рыг нь мэ - дэрнэ. Түү - ний үг - сийг сонсч Амьд - рал - даа ав -
 ал - ха - хад Ам - га-ланг мэ - дэрнэ. Ну - лим-сыг ар - чиж, Найд - ва - рыг тү -

8

Eb Bb Ab Eb Ab Eb Ab

11

чирья. Ав - раг - чийг бид таньж мэд-вэл, Ам - га-ланг мэ - дэрнэ. Найд-вар ү -
 гээж, Ав - рагч шиг амьд - рах юм бол Ам - га-ланг мэ - дэрнэ.

11

Cm Ab Eb Bb Ab Eb

14

гүй Хүч ч ү - гүй үед Тэр бид бү - хэнд Найд - вар, хүч өг -

14

Ab Cm Bb Eb Ab Cm

17

дөг. Хүнд хэ - цүү үед Христ Бид - нийг хам - гаал - даг. Дэл - хий энх тай - ван

17 B \flat E \flat A \flat B \flat Cm7

20 Coda руу буцна Φ 1. 2.

биш ч Ам - га - лан Түүнд буй. буй.

20 A \flat B \flat E \flat A \flat E \flat

23 A \flat B \flat E \flat A \flat B \flat E \flat A \flat B \flat

28 D.S. al Coda 31 Φ CODA

28 Cm E \flat A \flat B \flat E \flat Найд - вар ү- буй. Дэл - хий энх тай - ван

31 Cm E \flat

32 биш ч Ам - га - лан Түүнд буй.


32 A \flat B \flat E \flat A \flat Cm A \flat B \flat A \flat E \flat

©2017 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.

Энэ дууг ашгийн бус зорилгоор гэрт болон сүмд ашиглахаар хуулбарлан олшруулж болно.

Энэ мэдэгдлийг олшруулсан хуудас бүрд оруулна уу.





Арван хоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

АВРАГЧИЙН ҮГСИЙГ судал

Одоо Их Эзэн Аврагч, Есүс Христийн талаарх миний гэрчлэл өсөн нэмэгдэхийн зэрэгцээ би Иосеф Смитийн Мормоны Номыг орчуулахдаа ашигласан систем Бурханы бэлэг байсан талаарх итгэлийнхээ баталгааг дахин нэг удаа хүлээн авсан юм.

Би 2017 оны 1-р сарын залуучуудад зориулсан дэлхий даяарх онцгой цугларалтыг үзэж суугаа хүмүүсийг долоо хоног бүр дараах зүйлсийг хийж, Аврагчийн талаарх гэрчлэлээ нэмэгдүүлэхэд уриалсан. Үүнд:

- Хуучин Гэрээнд цэдэглэсэн Есүсийн хэлсэн, хийсэн бүхнийг судлах
- Шинэ Гэрээнд цэдэглэсэн Түүний зарлигуудыг судлах
- Мормоны Номонд цэдэглэсэн сургаалуудыг нь судлах
- Сургаал ба Гэрээнд цэдэглэсэн Түүний үгсийг судлах зэрэг юм.

Үүнийг сонссон хүмүүс боломжийнхоо хэрээр Есүс Христийн талаар судлах юм бол Түүнийг болон Бурханы зарлигийг хайрлах хайр нь төсөөлөхийн аргагүй өсөн нэмэгдэнэ гэдгийг би амлаж байна.

Би үг хэлж байхдаа уг даалгаврыг өөрийн биеэр анх удаа хийж байсан болохоор энэ амлалт үнэхээр биелдэг гэдгийг дурдаагүй.

2016 оны 12-р сард би шинэ судрууд аваад, дараа нь 1-р сард залуучуудад өгөх даалгавраа биелүүлж эхэлсэн билээ. Уг даалгаврыг зургаан долоо хоногийн дараа хийж дуусгах үед би дөрвөн судраас нийт 2200 гаруй эшлэлийг харж, тэмдэглэсэн байв.¹



Зургаан сарын дараа ерөнхийлөгч Нэлсон даалгавраа хийж дуусгасан.

“Би 93 наслахдаа олон ч цагийг Аврагчийн талаар суралцахад зориулсан ч энэ зургаан долоо хоногийн дотор сурсны адил ийм их зүйлийг сурч байсан нь ховор.”

Та [lds.org/broadcasts](https://www.lds.org/broadcasts)-ийн “Дэлхий даяарх онцгой цугларалт” дээр дарж, ерөнхийлөгч Нэлсоны 2017 оны 1-р сарын онцгой цугларалтыг үзэж эсвэл уншина уу.

Миний хувьд энэ даалгаврыг хийж дууссан маань сэтгэл хөдөлгөм үйл явдал байсан.

Аврагч бидэнд Өөрийнхөө талаар Хуучин Гэрээний болон Шинэ Гэрээний үе, Сэргээлийн болон бидний үе гэх мэт өөр өөр цаг үед хэлж байсан нь хамгийн сургамжтай зүйл байсан юм. Судрын бүх номын түүх болон түүхийг өгүүлж буй хүмүүс нь адилхан байсан.

Би 93 наслахдаа олон ч цагийг Аврагчийн талаар суралцахад зориулсан ч энэ зургаан долоо хоногийн дотор сурсны адил ийм их зүйлийг сурч байсан нь ховор. Үнэндээ би ийнхүү суралцсанаар энэ талаар маш их зүйл ойлгож мэдсэн бөгөөд сурсан зүйлээсээ дараа дараагийн хэлэх үгэндээ хуваалцахаар бэлдэж байгаа.²

Би энэ даалгаврыг хийж эхлэхдээ энэ нь надад Иосеф Смитийн бурханлаг ажлын талаар шинэ гэрчлэлтэй болоход тусална гэж бодоогүй ч гэрчлэлтэй болж чадсан! Иосеф Смитийн цэдэглэсэн илчлэлт, Библи дээрээс олж мэдсэн зүйлүүд нь хоорондоо гайхалтай сайхан нийцэж байсан. Суралцаж байхдаа үүнийг олж харсан минь миний билгийн мэлмийг нээж өгсөн билээ.

Мормоны Номыг ийнхүү хурдацтай орчуулж байхдаа номоо Библитэй уялдуулан холбож, солбицсон эшлэл болгон оруулах цаг Иосеф Смитэд байгаагүй нь гарцаагүй атал ийнхүү орсон байлаа!


Тиймээс Их Эзэн хийгээд Аврагч, Есүс Христийн талаарх миний гэрчлэл өсөн нэмэгдээд зогсохгүй, би Иосеф Смитийн Мормоны Номыг орчуулахдаа ашигласан систем Бурханы бэлэг байсан талаарх итгэлийнхээ баталгааг дахин нэг удаа хүлээн авсан юм.

Тэгэхлээр, та нарын зарим нь ийм даалгаврыг хийх цаг зав надад гарахгүй байх гэж дотроо бодож байгаа байх.

Та нарт юу бодогдож байгааг би мэднэ. Би ч гэсэн энэ бүхнийг хийх цаг зав надад байхгүй гэж бодож байсан. Иймэрхүү үгс итгэлийг өсгөн нэмэгдүүлэхгүй гэдгийг би өөртөө сануулах хэрэгтэй байсан юм. Харин “Надад үүнийг хийх цаг зав байхгүй гэдгийг мэдэж байгаа ч цаг зав гаргана. Байгаа цагтаа амжуулж хийнэ” гэх нь итгэлийг өсгөн нэмэгдүүлэх үгс юм.

Виллийн хувьд ням
гарагт хөл бөмбөг
тоглохгүй байх нь
хамгийн сайн хөл
бөмбөгийн багт
тоглож чадахгүй
гэсэн үг байв.





ХӨЛ БӨМБӨГ, НЯМ ГАРАГ БА СҮНСЛЭГ БАЙДЛЫН ХУВЬД ЭЛЭГДҮҮЛЭХ НЬ

Шарлотт Ларкэбэл

Сүмийн сэтгүүлүүд

Намайг хүүхэд байхад найзууд маань “үсэр эсвэл шумба” гэдэг нэг тоглоом тоглодог байлаа. Үүнийг тоглоход гүнзгий усан сан юм уу нуур, үсрэх тавцан гэх мэт үсэрч болох зүйл л хэрэгтэй байв. Тоглохын тулд үсрэх тавцангаас доош үсэрдэг байсан юм. Яг үсрэх гэж байхад хэн нэгэн нь “үсэр” гэж хашгирвал, хөлөөрөө үсэрч ус руу орох, харин “шумба” гэвэл ус руу гараараа түрүүлэн орж шумба гэсэн үг байв.

Агаарт байхдаа хөдөлгөөнөө өөрчлөх гэвэл сарвалзаж эсвэл элгээрээ цохиулан, маш их өвдөлтийг мэдэрнэ.

Амьдралд “үсэр эсвэл шумба” гэсэн тоглоом байхгүй. Та урьдчилан шийдвэр гаргаснаар сүнслэг байдлын хувьд элэгдүүлэхээс сэргийлж болно. Хуучин Гэрээний бошиглогч Иошуа “хэт оройтохынхоо өмнө сонголтоо хий” гээгүй. Тэр “Хэнд үйлчлэх вэ гэдгээ *өнөөдөр* өөрсдөө сонго” (Иошуа 24:15; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн хэлсэн.

АНУ-ын Калифорнийн Сан Францискод 14 настай В.Вилл эцсийн мөч ирэхээс өмнө сонголтоо хийх хэрэгтэй гэдэгт итгэдэг тул сүнслэг байдлын хувьд тийм ч олон удаа элэгдүүлээд байдаггүй байх.

Тэр: “Аливаа зүйл тохиолдохын өмнө хийх эсвэл хийхгүй байх сонголтоо хийх нь асуудлыг хялбарчилна. Үдэслэгт очиход хэн нэг нь танд согтууруулах ундаа өглөө гэж бодъё. Яг тэр мөчид авах эсэхээ шийдэх хэрэгтэй бол авчихъя гэсэн уруу таталтад орж болох юм. Харин та үгүй гэж хэлэх сонголтоо эртнээс хийсэн бол хэн нэгэн согтууруулах ундаа өгвөл өөртөө хамаагүй итгэлтэй байна. Танд уруу таталтад орох боломж гарахгүй. Та бүр эртнээс шийдвэрээ гаргасан тул үгүй гэж хэлэх нь мэдээж” гэв.

2018 оны Мючелийн сэдэв “Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун; миний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхагтун, мөн надаар





дамжин амар амгалан чамд байх болно” (С ба Г 19:23) юм. Виллийн хувьд амар амгалан нь зөвийг итгэлтэйгээр сонгож, бусад хүний хэлэх сөрөг үгэнд ач холбогдол өгөхгүй байх явдал юм. Харин энэ амар амгалан нь Виллд Есүс Христийн үгийг эртнээс сонсож, дагах шийдвэр гаргаснаар ирсэн билээ.

“Заримдаа хүүхдүүд миний хийдэг эсвэл хийдэггүй зүйлээс болж намайг хэцүү байдалд оруулдаг. Гэхдээ би олон жилийн өмнөөс ингэж амьдарна гэдгээ шийдсэн болохоор надад хэцүү санагдахаа больсон” гэж тэр хэлсэн юм.

Вилл болон түүний гэрийнхэн Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихаар олон жилийн өмнөөс шийджээ. Харин энэ нь Виллд дээд зэрэглэлийн хөл бөмбөгийн багт ороход түвэг учруулсан юм. Гэхдээ Нифайн хэлснээр: “Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” (1 Нифай 3:7).

Виллийн хувьд хөл бөмбөг амь, амьдрал нь байв. Эжийнх нь хэлснээр “Тэр идэж, ууж, унтдаг бас хөл бөмбөгт маш дуртай. Хөл бөмбөг түүний сонирхол бөгөөд тэр маш сайн тоглодог” байна.

Харин Вилл бүсийнхээ хамгийн дээд зэрэглэлийн багт орж чадсандаа баярлаж байв. Ганц асуудал нь уг баг ихэнх тоглолтоо ням гарагт хийдэг байсанд байлаа. Ихэнх баг ням гаргийн тоглолт бүрийг алгасдаг тоглогчийг хүлээн зөвшөөрдөггүй. Ням гарагт тоглохгүй байх нь багт эзлэх байр сууриа алдана гэсэн үг байв.

Харин Вилл шийдвэрээ олон жилийн өмнө гаргасан байлаа. Тэр Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихаар шийдсэн байв.

Вилл гэр бүлийнхэнтэйгээ хамт залбиран, Тэнгэрлэгт Эцэгт зарлигуудыг нь дагахыг хүсэж

байгаагаа хэлээд, Түүнээс тусламж гуйсан аж. Дараа нь Вилл, ээжтэйгээ хамт багийнхаа дасгалжуулагчтай өөрсдийн шашин шүтлэгийн талаар ярьсан байна. Харин дасгалжуулагч нь ням гарагт тоглохгүй байсан ч Виллийг багтаа үлдээх хүсэлтэй байсан нь тэднийг гайхшируулсан юм.

“Би Хүндэтгэлийн өдрийг сахих юм бол адислагдана гэдгээ мэднэ. Би бусадтай адил олон тоглож чадахгүй ч ням гаргийн тоглолт гэнэт өөр өдөр болж хойшлох гэх мэт адислалуудыг харж байсан. Бас нэг өдөр амардаг болохоор би өөрийгөө илүү сайн тоглодог гэж боддог” гэж Вилл хэлэв.

Илүү сайн зүйл тохиолдсон нь Виллийн багийн нэг гишүүн нь бас Сүмийн гишүүн гэдгийг тэр олж мэдсэн аж. Хэдэн сар хамтдаа тоглосны эцэст тэр хүү ч гэсэн Виллийн үлгэр жишээг даган, ням гарагт тоглохоо больжээ.

Хэрэв танд дуулгавартай байдлын адислалыг авахгүй байна гэсэн бодол төрж байвал та Тэнгэрлэг Эцэгийн өөрт тань зориулан бэлдсэн зүйлийг харахгүй байна гэсэн үг. Христийн үгсийг сонсож, Их Эзэнд үйлчлэхээр шийдэх нь ямагт зөв шийдвэр байх учраас шийдвэрээ яг одоо гаргаарай!

“Биднийг Тэнгэрлэг эцэгтэй цуг мөнх амьдрахад хүргэх тэр замаас гажихгүй байх төгс шийдвэрийг та нар яг одоо, энд гаргаасай гэж би та нараас хүсэж байна” хэмээн ерөнхийлөгч Томас С.Монсон хэлсэн (“Гурван сонголт,” 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 69).

Амьдралаа “үсэр эсвэл шумба” гэдэг тоглоом бүү болго. Сүнслэг байдлын хувьд болон өөр төрлийн элэгдүүлэх эрсдэлд бүү ор. Есүс Христийг дагах шийдвэрийг яг одоо гаргаж, Түүний амьдралд тань авчрах амар амгалангаас хүрт. ■



ХАЧИН ХӨРШ

Саманта Бэст

Хэдэн жилийн өмнө би ярилцах ч хүн байхгүйгээс болж сэтгэлээр унасан байлаа. Гэр бүлээсээ хол, найз нөхөдгүй байсан учраас надад цаашид хэрхэн амьдрах талаар төсөөлөгдөх ч үгүй байв.

Би авга ах, эгч хоёртойгоо амьдардаг байсан бөгөөд тэд зөвхөн хөрштэйгөө ярилцахыг л огт зөвшөөрдөггүй байв. Тэд түүнийг хачин гэж хэлдэг байсан бөгөөд намайг айлгах гэж түүний тухай түүхүүдийг хүртэл зохиож байсан.

Гэвч нэгэн бямба гарагт хөрш маань өсвөр насны хоёр охинтойгоо хамт надаас хашаа барихад туслахыг хүссэн юм. Би ч зөвшөөрч, ажилдаа оров.

Охидыг ажигласны эцэст би тэднийг сайн хүмүүс болохыг мэдэрсэн ба тэдэнтэй үг сольж эхэлсэн нь биднийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн талаар ярилцахад хүргэсэн юм. Тэд миний олон асуултад хариулсан. Би ч сонирхож эхлэв. Хөрш маань надаас маргааш сүм рүү хамт яваад, таалагдах эсэхээ мэдэхэд урив. Би амьдралынхаа хамгийн хүнд хэцүү үед байсан учраас алдах зүйлгүйгээ ойлгосон.

Маргааш өглөө нь би Сүмийн хаалгаар алхан орохдоо, ойлгоход хэцүү дотоод сэтгэлийн амар амгаланг гэнэт мэдэрсэн бөгөөд энэ сүм бол миний байх ёстой газар гэдгийг мэдсэн. Тэр өглөө надтай номлогчдыг танилцуулж, тэд Сүм үнэн гэдгийг хэрхэн мэдсэн болохыг би олж харсан.

Би номлогчдоос хэд хэдэн хичээл авав. Тэнгэрлэг Эцэг хайраар дүүрэн, халамжтай мөн сүнслэг тэдгээр номлогчийг яг зөв цагтаа над руу илгээсэн. Би номлогчдын тусламжтайгаар тэдэнд байсан сайн мэдээний тухай мэдлэгийг олж авсан.

Тэнгэрлэг Эцэгийн тухай мэдэж авснаар зовлон бэрхшээлтэй үед нь тэдэнд хэрхэн тусалсан тухай сонсоод, би тэдний хэлсэн зүйл үнэн эсэхийг мэдэхээр залбирах хэрэгтэй гэдгээ мэдэрч билээ. Би залбирсныхаа дараа сэтгэл дотроо аз жаргал, амар амгалангийн мэдрэмжийг хүчтэй мэдэрсэн. Би тэр орой хариултаа Ариун Сүнсээр дамжуулан хүлээн авсан гэдгээ мэдэж байв.

Ийм мэдлэг олж авснаар миний гэрчлэл маш хурдан өсөж байлаа. Би 2013 онд Сүмд нэгдсэнээсээ хойш Тэнгэрлэг Эцэгийн тухай мэдлэгтэй болсноор надад өгсөн олон олон адислалыг харж байсан. Би тэр номлогчдоод болон намайг Христэд ирэхэд урьсан хөршдөө талархдаг. ■

Зохиогч нь Австралийн Викториад амьдардаг.

Би амьдралынхаа хамгийн хүнд үеийг туулж байсан бөгөөд хөрштэйгөө сүмд явснаар бүх зүйл өөрчлөгдсөн.



БИ ИТГЭЛЭЭ БОДИТ БОЛГОСОН

Найз Эрфрийтэйгээ ширээний теннис тоглож байх үед түүний хаалгыг хэн нэгэн гурвантаа тогшин бидэнд саад болов. Нутгийн маань аялга болох хилигаунонаар муухан ярьдаг нэгэн танил бус дуу хоолой сонсогдлоо.

Эрфрий тэднийг хүлээж байсан гэлтэй хаалга руу яарав. “Алив ээ” гэж тэр надад хэллээ. “Би чамайг найзуудтай минь уулзаасай гэж хүсэж байна!”

Тэд цагаан цамц, зангиатай байсан бөгөөд Эрфрийгийн дүүт баптисмд бэлтгэхийн тулд уулзахаар иржээ. Би тэдэнтэй

англиар ярилцсан бөгөөд намайг Эрфрийгийн дүүд хичээл заах үед орчуулаад өгч чадах англи хэлтэй гэж үнэлсэн учраас надаас орчуулж өгөхийг хүссэн юм.

Миний зорилго бол зүгээр л идэвхгүй хэлмэрч байх явдал гэж би бодож байлаа. Гэвч тэдний үг зүрх сэтгэлд минь нэвтэрч эхлэхэд би идэвхтэй хэлмэрч болсон юм. Надад урьд өмнө хэзээ ч төрж байгаагүй, тайлбарлашгүй мөн удаан үргэлжилсэн аз жаргалын мэдрэмж төрсөн.

Тэр явдлын дараа би номлогчдоос гэр бүлд маань заахыг хүссэн юм. Гэхдээ тэднийг ирсний дараа эцэг эх

маань хэзээ ч гэр бүлдээ мормон хүн байлгахгүй гэж хатуу шийдсэн.

Би баптисм хүртэхийг хүсэж байсан учраас итгэлээ бодит болгов. Би мацаг барьж, залбирч, тэдэнд үлгэр жишээ байхыг хичээсэн.

Хоёр жилийн дараа энгийн хичээл зүтгэл, Тэнгэрлэг Эцэгийн хайраар дүүрэн дэмжлэгийн ачаар аавын минь зүрх сэтгэл зөөлөрч, баптисмын зөвшөөрлийн хуудсан дээр гарын үсэг зурсан юм. Сэргээгдсэн сайн мэдээний талаарх гэрчлэл минь миний хамгийн үнэтэй эд хөрөнгө гэдгийг хэлэхдээ би таатай байна. ■
Арнэл М, Нэгрос, Филиппин, Оксидентал

ХҮҮХДИЙН ХЭСГЭЭС ЗАЛУУ ЭМЭГ- ТЭЙЧҮҮДИЙН АНГИ РУУ

Надад шинэ нөхцөл байдалд дасахад үргэлж хэцүү байдаг. Иймээс би Хүүхдийн хэсгээс гараад, Залуу эмэгтэйчүүдийн анги руу орохдоо сандарч байсан. Эхлээд хөтөлбөр нь надад хачирхалтай санагдсан. Залуу эмэгтэйчүүд тэр чигээрээ өөр ертөнц байсан. Дуу дуулахгүй, хуваалцах цаггүй. Мөн долоо хоногийн дундуур Мючелийн арга хэмжээтэй.

Би зохицож, тав тухтай байхыг хүсэж байсан учраас шинэ хөтөлбөртөө дасан зохицохыг хичээж байлаа. Би маш их залбирсан ба улмаар шинэ хэвшилдээ дасан зохицож, бусад залуу эмэгтэйтэй нөхөрлөж эхэлсэн.

Өдөр хоног өнгөрөхийн хэрээр би яагаад Залуу эмэгтэйчүүдийн хөтөлбөрт хамрагдсанаа ойлгосон юм. Би сайн мэдээний талаар илүү сайн судалж, долоо хоног бүр арай илүү сайн байх илүү их боломжийг эдлэн, ариун сүмд орж, Их Эзэний өргөөнд Түүний Сүнсийг мэдрэх боломжтой байсан.

Одоо би Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт үнэхээр их талархаж байна. Би дасан зохицох боломжтой байсандаа мөн Тэнгэрлэг Эцэг маань надад тусалсанд баяртай байна. ■
Бэтани В, АНУ, Флорида

ЦЭВЭР АРИУН СҮНС БОЛ ТЭМЦЭЭН УРАЛДААНДААС ИЛҮҮ ЧУХАЛ

Би наймдугаар ангид байхдаа номын клубт явдаг байсан. Бид сар бүр нэг номны тухай ярилцахаар уулздаг байсан бөгөөд жилийн эцэст хэний баг уг номны талаар хамгийн сайн мэдлэгтэй байгааг тодруулах тэмцээн зохиодог байлаа. Бидний дагаж мөрддөг цорын ганц дүрэм нь зөв зохистой ном унших явдал байсан юм.

Нэгэн удаа би дараачийн номоо уншиж эхлэхдээ зөв зохисгүй болохыг нь мэдэрсэн. Хэрэв би багаа ялаасай гэж хүсэж байгаа бол унших л хэрэгтэй байлаа. Би тэдний урмыг хугалж болохгүй. Хэдэн бүлэг уншсаны дараа байдал бүр дордож эхлэв. Эцэст нь би уншихаа больсон юм. Би унших ёсгүй гэдгээ мөн миний сүнслэг цэвэр ариун байдал тэмцээнд ялахаас илүү үнэ цэнтэй гэдгийг ойлгосон.

Гэхдээ би багийнхандаа хэлэхээс санаа зовж байлаа. Клубын уулзалтын өмнөх орой би тэдэнтэй ярилцах зориг өгөхийг Тэнгэрлэг Эцэгээс гуйн залбирсан юм.

Маргааш нь санаа минь маш их зовж байсан бөгөөд багийнхантайгаа хамт суулаа. Уулзалт эхэлсний дараа би уг номыг уншиж чадахгүй болсноо хүн бүрд хэлэх гэж байтал намайг хэлэхээс өмнө удирдагч босоод, уучлал хүсэв. Тэрээр номын жагсаалтад уг номыг оруулахаасаа өмнө уншиж үзээгүй гэдгээ мөн дотор нь юу бичсэн байгааг мэдээгүй гэдгээ тайлбарлаж, энэ номыг жагсаалтаас хасах болно гэж хэлсэн юм. Би гэртээ хариад, Тэнгэрлэг Эцэгт талархсан билээ.

Жишгүүддээ үнэнч байгаа үед Их Эзэн биднийг харж ханддаг гэдгийг би мэднэ. Тэр надад тусалсан шиг ийм нөхцөл байдал бүрд үргэлж санаа тавиад байдаггүй ч бидэнд зөв шийдвэр гаргах боломжийг үргэлж өгдөг. ■

Ашлэй А, АНУ, Юта



ОДОО ТАНЫ ЭЭЛЖ

Лиахона таныг сайн мэдээний дагуу амьдарснаар олж авсан туршлага, төрж буй сэтгэгдлээ ирүүлнэ үү хэмээн урьж байна. Та түүхээ бидэн рүү liahona.lds.org вэбсайтаар ("Submit an Article" дээр дарж) илгээнэ үү.

ХӨНГӨН зуушнаасаа хуваалцаж, ИНЭЭМСЭГЛЭЛ БЭЛЭГЛЭХ НЬ

Биднийг Сэм, Анастасия

гэдэг бөгөөд бусадтай
хуваалцах замаар ГЭРЛЭЭ
ГЭРЭЛТҮҮЛЭХИЙГ
хичээдэг.



1

Бид яаж туслах вэ?


Бид АНУ-ын Флоридад амьдардаг бөгөөд тэнд гэр оронгүй олон хүн байдгийг харж болно. Бид тэдэнд хэрхэн туслах талаар бодсон юм. Есүс өлссөн, хоол унд хэрэгтэй хүмүүсийг хооллодог байсан. Тиймээс бид онцгой нөхцөл байдалд зориулсан хөнгөн зуушны цутлуулга бэлдэхээр шийдэв.



2

Хүнсний зүйлс худалдаж авсан нь

Бидний найз Жоа нэг долларын дэлгүүрээс хоол хүнс худалдаж авахад маань тусалсан.



3

Цуглуулга хийсэн нь

Бид үр тарианы жигнэмэг, бяслагтай савхан талх, өөр бусад амттай зуушны цуглуулга хийсэн. Сэм бүр идэж үзсэн гээч!



Гайхалтай!

4

Цуглуулгаа хуваалцсан маань бидэнд инээмсэглэл хайрласан юм. Зарим хүн “Баярлалаа!,” “Гайхалтай!” гэж хэлсэн.



5

Илүү олон цуглуулга

Ээж маань төслийн талаар интернэтэд оруулахад энэ тухай ганц бие залуучуудын салбарынхан олж мэдсэн байлаа. Тэд манай орон

нутгийн гэр оронгүй хүмүүсийг орогнуулах газарт зориулан 100 цуглуулга нэмж хийсэн. Орогнуулах газар тэдгээрийг гэр оронтой болоход туслах хөтөлбөрт хүмүүсийг хамруулахаар урихдаа ашигласан байв. Үүнд бид хэчнээн их баярласан гээч!

ТА ХЭРХЭН ГЭРЭЛТҮҮЛЖ ЧАДАХ ВЭ?

- Гэр бүлийнхэнтэйгээ хамтарч үйлчлэх төслөө сонго.
- Аравны нэгийн өргөлийн дугтуйндаа мацгийн өргөл хийж өг. Таны мөнгийг хэн нэгэнд туслахад хэрэглэнэ.

БИДЭНД ОД ИЛГЭЭНЭ ҮҮ!

Та Есүсийн биднээс хүссэний дагуу гэрлээ хэрхэн гэрэлтүүлж чадах вэ?

Өөрийн түүх, зургийг эцэг эхийнхээ зөвшөөрлийн хамт одонд хийн, бидэнд илгээгээрэй. Дэлгэрэнгүй мэдээллийг 71-р хуудсаас авна уу.



Мурлин Ваткинс

Бодит түүхээс сэдэвлэв

“Би ариун судруудыг унших дуртай. Унших бүрдээ би Сүнс зурх сэтгэлийг минь дүүргэж байгааг мэдэрч, гэрчлэл маань үнэн гэдгийг мэддэг” (Children’s Songbook, 109).

Люсиа нулимсаа арчив. Тэр бусад хүүхдэд нулимсаа харуулахыг хүсэхгүй байлаа. Тэр сургуулийнхаа орчноос холдоод, гэр рүүгээ яарав.

Люсиа үзэсгэлэнтэй, жижигхэн арал дээр амьдардаг. Тэр сургуулийнхаа цорын ганц Сүмийн гишүүн бөгөөд бусад хүн бүгд өөр нэг сүмд явдаг. Тэд Люсиаг өөр учраас гадуурхаж, хамт тоглодоггүй.

Энэ нь цорын ганц асуудал байсангүй. Заримдаа Люсиаг гараа өргөхөд багш нар нь үл тоомсорлодог байв.

“Тэхдээ өнөөдөр үүнээс ч дор зүйл боллоо!” гэж тэр бодов. Тэр замын чулууг өшигчин явав. Хичээл дээр багш нь Люсиагийн ойлгохгүй Библийн шүлгүүдийг уншиж өгөв. Тэгэхэд Тэнгэрлэг Эцэг, Есүс, Ариун Сүнс гурвыг нэг хүн гэж хэлэх шиг сонсдов. Тэгээд багш нь Библийн заасан зүйлст итгэдэггүй зарим сүм байдаг гэж хэлээд, Люсиа руу харав. Ангийнхан бүгд шоолж инээдлээ.

Люсиа бүр төөрөлдөж орхив. Тэнгэрлэг Эцэг, Есүс, Ариун Сүнс гурав тусдаа биес биш гэж үү? Юу болоод байна аа?

Түүнд гэнэт сайхан санаа төрөв. Тэр номлогчдоос асууж болно шүү дээ! Тэд Люсиагийн тосгонд өдөр бүр ирдэг. “Тэд яаж туслахаа мэднэ” гэж тэр боджээ.

Люсиа гэртээ ирээд, Браун, Руйз гэдэг хоёр эгчийг харав. Тэд дээвэр дээрх усны сав руу ус

ЛЮСИАД ӨГСӨН



юүлэхэд тусалж байлаа.

Люсиа шуудхан асуув. “Яагаад Библи Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрыг нэг хүн гэж заадаг юм бэ?”

Браун эгч инээмсэглээд, “Энэ чинь их сайхан асуулт байна. Өдрийн хоолны дараа тус болох хэдэн судар харцгаая” гэж хэлэв.

Люсиа ээжийнхээ хийсэн амттай *ropa vieja* жигнэсэн махыг арайхийн идлээ. Тэр хариултаа авахыг л хүсэж байв!

Өдрийн хоол арай гэж нэг юм дууслаа. Люсиа номлогчидтой хамт судраа нээв. Тэд Иосеф Смитийн үзэгдлийн тухай, дараа нь Есүсийн баптисмын тухай уншлаа. Хоёр судар хоёулаа Тэнгэрлэг Эцэг, Есүс, Ариун Сүнс гурвыг тусдаа гэж зааж байв.

“Тэгвэл яагаад өөр бусад судар тэднийг нэг гэж заадаг юм бэ?” гэж Люсиа асуулаа.

Браун эгч хуудсуудыг эргүүлэв. “Иохан 17-г

уншицгаая. Энд Есүс төлөөлөгчдийнхөө төлөө Тэнгэрлэг Эцэгт залбирч байна.”

Тэд ээлжлэн уншив. Судруудад Есүс төлөөлөгчдөө өөртэйгөө болон Тэнгэрлэг Эцэгтэй адил “нэг” байгаасай гэж залбирдаг. Люсиа ингэж гурван удаа хэллээ гэж тоолов.


“Төлөөлөгчид бүгд нэг хүн шиг болж чадахгүй шүү дээ” гэж Руйз эгч хэллээ. Гэхдээ тэд итгэж, хийж байгаа зүйлээрээ нэг болж *чадна*. Ингэж л Тэнгэрлэг Эцэг, Есүс, Ариун Сүнс гурав нэг болдог.

Люсиад халуун дулаан мэдрэмж төрөв. Энэ нь Ариун Сүнс гэдгийг тэр мэдэж байсан. Ариун Сүнс Руйз эгчийн хэлсэн зүйл үнэн гэж хэлж байлаа.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр нэг хүн биш. Гэхдээ тэд хэлж, хийж буй зүйлээрээ нэг юм. Тэд хоёул өөрт нь хайртайг Люсиа мэдэж байлаа. ■
Зохиогч нь АНУ-ын Калифорнид амьдардаг.

Люсиа багшийнхаа хэлсэн зүйлийг ойлгохгүй байв. Хэн тусалж чадах вэ?

ХАРИУЛТ



СУДРААС ИРДЭГ ТУСЛАМЖ


Хүүхдийн хэсгийн багш маань судруудаас асуултынхаа хариуг олоход надад тусалдаг. Нэгэн удаа би “Өнөө үед яагаад том том гайхамшгууд болохгүй байгаа юм бэ?” гэж асуусан. Тэр надад өнөөдөр гайхамшгууд тохиолдсоор байгаа талаар хэлсэн судрыг олоход туслав. Би судруудаас хариултаа олох дуртай.

Эмили И, 10 настай, Англи, Самэрсэт



Ерөнхийлөгч
Томас С.Монсон

Гэрлээрээ ГЭРЭЛТГҮҮЛ



Бидний хүн нэг бүр дэлхий дээр Христийн **гэрэлтэй** ирсэн. Бусдад харагдаж, тэднийг байлдан дагуулахаар **гэрлээ** тод гэрэлтүүлэх эсэх нь биднээс шалтгаална. Хэрэгтэй байгаа итгэлээ хадгалж үлдэх нэг арга зам бол судруудыг судалж, залбирах явдал юм.

Та нар гэрчлэлийнхээ галыг бадрааснаар бусдад зөв шударга байдлын **гэрлэн дохио** байх болно. Аврагч “хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг” (Матай 5:16) гэж хэлсэн билээ.

Бидний гэрлээрээ гэрэлтүүлэх боломж хязгааргүй. Тэдгээр боломж өдөр бүр биднийг

хүрээлэн байдаг. Бид Аврагчийн үлгэр жишээг дагаснаар гэр бүлийн гишүүн, найз нөхөд эсвэл огт танихгүй ч байхамаагүй, эргэн тойрныхоо хүмүүсийн амьдралд **гэрэл** болдог.

Бид дэлхийн **гэрэл** болж чадна. Харанхуйд **гэрлээ** асаахад **гэрэл** өрөөг дүүргэдэг шиг зөв шударга байдлын жишээ болох нь улам бүр харанхуйлж байгаа дэлхийг **гэрлээрээ** гэрэлтүүлэхэд тусалж чадна.

Найзууд аа, төлөөлөгч Паулын хэлснээр бид “итгэгч хүмүүст үлгэр дуурайл” (1 Тимот 4:12) болж чадна. Бид үргэлж Христийн дагалдагчид гэдгээрээ танигдаж, дэлхийн “**гэрэл мэт**” (Филиппой 2:15) үзэгдэж чадна. ■



*“Be a Light to the World”
(Бригам Янгийн Их Сургууль
дээрх онцгой цугларалт,
2011 оны 11-р сарын 1),
speeches.byu.edu.*

ӨӨРСДИЙНХӨӨ ОДЫГ БИДЭН РҮҮ ИЛГЭЭ!

Та нар Есүсийн хүссэнээр гэрлээ хэрхэн гэрэлтүүлж чадах вэ? Та нар сайн үлгэр жишээ үзүүлж, хөршдөө үйлчлэн, гэрчлэлээ хуваалцдаг уу? Өөрсдийн түүх болон одыг илгээснээр *Лиахона* руу хариултаа илгээнэ үү.

1. Цаасан дээр од зураад, сайн үлгэр жишээ болж, бусдад тусалснаар хэрхэн тод гэрэлтэж байгаагаа бич.
2. Одоо хайчлаад, зургийг нь ав. Аль эсвэл одоо барьж байгаад зургаа авахуул.
3. Эцэг эхийнхээ тусламжтайгаар үүнийг ("Submit an Article" дээр дарж) liahona.lds.org руу илгээ.



3 Нифай 17:7, 9

3 Нифай 17:21

Иохан 8:10-11

СУДРЫН ОДОД

Есүс Христийн үлгэр жишээний тухай өгүүлсэн судар бүрийг уншихдаа одыг буд.

3 Нифай 11:13-15

Иохан 11:33-44

Марк 10:46-52

Лукас ба ДЭЭРЭЛХҮҮ ЗАН

Лукас Пэдрогийн царайны
хувирлыг харах хүртлээ хэлсэн
зүйлдээ сэтгэл хангалуун байв.

Эрик Б.Мердок

Сүмийн сэтгүүлүүд

Бодит түүхээс сэдэвлэв

“Бүгдээрээ гэртээ байвч, хаа ч явж байсан бие биедээ эелдэг үг хэлицгээе” (Hymns, д. 232).

“Ө, үгүй ээ! Пэдро ирж байна”

Сургууль дээрх хүн бүр Пэдрог дээрэлхүү гэдгийг мэддэг. Тэр том биетэй бас догшин ширүүн зантай хүүхэд! Тэр хүүхдүүдийг доромжилж, өдрийн хоолыг нь булааж, сургуулийн хашаагаар тэднийг хөөдөг. Хэн ч түүний эргэн тойронд байхыг хүсдэггүй.

Пэдро Лукас, түүний найз Артур хоёрын хажуугаар зөрөв. Тэр тэднийг “азгүй амьтад” гэж дуудан, Артурыг түлхлээ.

Лукас догшин ширүүн зантай Пэдрогоос залхаж байв. Тэр бодох ч сөхөөгүй “Болиоч, Пэдро!” гэж хашхирлаа.

Лукас өөртөө ч итгэсэнгүй. Тэр сургуулийн хамгийн дээрэлхүү хүүхдийг эсэргүүцлээ шүү дээ!

Пэдро Лукас руу ухасхийн очоод, заамдан авав. “Чи юу гэж хэлсэн бэ?” Лукасын зүрх амаар нь гарах шахуу хурдан цохилж байлаа. “Би та нарт нэг л анхааруулга өгнө” гэж Пэдро хэлээд, “Та нар анхааралтай л байгаарай!” гэв. Тэр Лукасыг түлхээд, цаашаа яваад өгөв.

Лукас үргэлж Пэдрогоос зайдуу байхыг хэр чадлаараа хичээж байсан ч Пэдро түүнийг олчихдог байжээ. Тэр Лукасыг савлуур дээр тоглуулахгүй, гар бөмбөг тоглох үеэр болон хоолны газар түлхэж унагаан, байнга бүдүүлэг үг хэлдэг байлаа.

Нэг өдөр Лукас, Артур хоёр Артурын хөл бөмбөгөөр тоглож байв. Пэдро модны цаанаас гарч ирээд, бөмбөгийг булаав.

“Өгчих тэгэх үү?” гэж Артур хэллээ.

“Хэн надаас авч чадах юм бэ?” Пэдро Лукасыг мод руу түлхээд, шоолж инээв.

Лукас туйлдаа хүртэл сэтгэлээр уналаа. Тэр маш их уурласан байв. “Юу

гээч, Пэдро?” гэж Лукас хэлээд, “Чи бол миний мэдэх хамгийн муу хүүхэд! Хэн ч чамд дургүй. Хүн бүр чамайг үүрд яваасай гэж хүсдэг!” гэв.

Пэдро инээхээ болив. Лукас Пэдрогийн царайны хувирлыг харах хүртлээ хэлсэн зүйлдээ сэтгэл хангалуун байв. Тэр уйлах гэж байна уу даа? Пэдро доош ширтсээр цааш явлаа.



Тэр даруй Лукаст муухай санагдав. Лукас тэр өдөр хэчнээн хичээсэн ч энэ муухай мэдрэмжээсээ салж чадахгүй байлаа. Мөн орой нь тэр унтаж чадахгүй хөрвөөсөөр байв. Тэр Пэдрогийн хэчнээн гунигтай харагдсан тухай бодсоор байлаа.

“Пэдрод муухай санагдах ёсгүй” гэж тэр бодов. “Тэр бусад хүүхдэд дээрэлхүү хандаж байгаадаа санаа нь зовдоггүй. Би ямар нэгэн зүйл хэлэх ёстой биз дээ?” Лукас энэ тухай бодох тусам өөрийнхөө мөн найзуудынхаа төлөө зогсох нь зөв байсан гэдгийг ухаарав. Гэхдээ эелдэг бус зүйл хэлсэн нь түүний буруу байлаа.



Лукас өвдөг сөгдөн, Тэнгэрлэг Эцэгээс өршөөхийг гуйв. Тэр дахиад хэнийг ч гомдоохыг хүсэхгүй байгаагаа Тэнгэрлэг Эцэгт хэллээ. Тэр эелдэг байхыг хүссэн. Лукас “амэн” гэж хэлэхдээ юу хийх ёстойгоо ойлгожээ.

Дараагийн өдөр нь өдрийн хоолны үеэр Лукас хана налан ганцаар зогсож байгаа Пэдрог олов. Лукас сандарч байлаа. Пэдро яах бол? Лукас гүнзгий амьсгаа аваад, урагш алхлаа.

“Өчигдрийн болсон явдалд намайг уучлаарай.”

Пэдро гайхсан байдалтай харагдав. “Чи уучлаа гуйж байгаа юм уу?”

“Тийм ээ. Би үнэхээр муухай зүйл хэлсэн бололтой. Тэгэх ёсгүй байсан юм. Уучлаарай.”

Пэдро гутал руугаа ширтэв. “Зүгээр ээ.”


Хонх дуугарлаа. Лукас анги руугаа буцаад алхав. Түүнд арай дээр болж байгаа санагдлаа. Гэхдээ тэр дахиад нэг зүйл хэлэхийг хүсжээ. Тэр эргэж харав. “Хэрвээ чи хүсэж байвал хоёулаа маргааш завсарлагаанаар хөл бөмбөг тоглож болох юм.”

Пэдрогийн нүүрэнд инээмсэглэл тодров. “Сайхан санаа байна.”

Энэ бүхний дараа Пэдро дээрдэв. Тэр зарим үед дээрэлхдэг хэвээрээ байсан ч урьдынх шиг ширүүн дориун байхаа болив. Тэр завсарлагаанаар хэд хэдэн удаа Лукастай хамт тоглосон байна. Үнэхээр хөгжилтэй байсан! Сургууль амарсны дараа Пэдро Лукаст нүүх гэж байгаагаа хэлэв. Дараа нь тэр Лукасыг гайхшируулсан нэг зүйлийг хэллээ.

“Эелдэг бус байсан ч гэсэн надтай найзалсанд баярлалаа” гэж Пэдро хэлэв.

Лукасын зүрх сэтгэлд мэдрэгдсэн халуун дулаан мэдрэмж эелдэг байх нь үргэлж зөв сонголт байх болно гэдгийг батлав. ■



ҮРГЭЛЖ ЭЕЛДЭГ ҮГ ХЭЛЦГЭЭЖ БАЙЯ

“Эргэн тойрон дахь хүмүүсээ сэтгэл санаагаар дэмжиж, туслах үг хэллэг хэрэглэ.”

Ерөнхийлөгч Томас С. Монсон, “The Lighthouse of the Lord,” *Ensign*, 1990 оны 11-р сар, 97.



Далын
Ахлагч
Клаудио Р.М.Коста

Моронай ба засварчин



*“Мөн бяцхан хүүхэд тэднийг хариулах болно”
(2 Нифай 30:12).*

Олон жилийн өмнө манай гэр бүл хамаатнууд дээрээ очсоныхоо дараа Бразилийн Сан Пауло дахь гэр рүүгээ машинаар буцаж байлаа. Яг өгсүүр зам руу орон явж байтал машин маань эвдрэв.

Бид машинаа асаах гэж хэд хэдэн удаа оролдсон ч ассангүй. Машинууд бидний хажуугаар өнгөрсөөр. Хэн ч зогсож, бидэнд тусалсангүй.

Эцэст нь би гэр бүлийнхэндээ залбирах хэрэгтэй гэлээ. Манай зургаан настай хүү Моронай “Аав аа, битгий санаа зов. Би аль хэдийн залбирчихсан” гэлээ.

“Чи юуны төлөө залбирсан бэ?” гэж намайг асуухад,

“Би зөв хүн ирж, бидэнд туслаасай гэж Тэнгэрлэг Эцэгт хандан залбирсан” гэв.

Удалгүй хоёр тод гэрэл машины ард тусах нь тэр. Тэр нь автомашин ачдаг ачааны тэрэг байлаа. Жолооч нь засварчин байв.

“Та нар их азтай юм аа. Би ажлаа дуусгаад гэртээ харьж явсан юм” гэлээ.

Тэр бидний машиныг засав. Дараа нь гэрт маань асуудалгүй хүргэхийн тулд биднийг дагаж явсан юм.


Би Моронайгаас энэ үйл явдал ямар онцгой болохыг мэдэж байна уу гэж асуув. “Мэдээж. Тэнгэрлэг Эцэг миний залбирлыг сонссон. Тиймээс би одоо өөрийн гэсэн гэрчлэлтэй боллоо! Би таны гэрчлэлийг зээлэх хэрэггүй боллоо” гэсэн юм. Моронайн итгэлийн талаар үзүүлсэн үлгэр жишээ миний сэтгэлийг хөндөв.

Одоо Моронай өсөж том болсон ч бага насандаа үзүүлсэн үлгэр жишээгээ санадаг. Та хүүхэд байсан ч гэр бүлийнхэн, найз нөхдөдөө үлгэр жишээ үзүүлж чадна. ■

Надад зориулсан Бурханы ТӨЛӨВЛӨГӨӨ

Судрын хэсгийг уншсаныхаа дараа зурган дээрх амьтдыг өнгийн харандаагаар буд.

1. Абрахам 3:24–28
2. Мосе 2:1–13
3. Мосе 2:14–25
4. Мосе 2:26–31
5. Абрахам 5:1–7
6. Еврей 5:8–9; Алма 12:33
7. Мосе 1:39
8. Дуулал 82:6; Ром 8:16.



Иехова

Иехова бол дэлхийг бүтээхээс өмнөх Есүсийн нэр. Тэр Тэнгэрлэг Эцэгийн ууган хүү, бидний ах юм. Тэр Тэнгэрлэг Эцэгт дэлхий, ургамал, амьтдыг бүтээхэд тусалсан. Тэр бас бидэнд Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиход туслахаар дэлхийд ирсэн.

- Исаиа 26:4-ийг уншиж, чээжилнэ үү.
- Scripturestories.lds.org дээрээс Хуучин Гэрээний 1, 2-р бүлгийг үзнэ үү.
- Тэнгэрлэг Эцэг болон Иеховагийн бүтээсэн зүйлсийг хайрлаж байсан үеэ тэмдэглэлийн дэвтэртээ бич эсвэл зур.
- Би дараах байдлаар Бурханы бүтээсэн зүйлийг анхааран арчлах болно. Тухайлбал...

БҮТЭЭЛТ

Ким Вэбб Рэйд

Намайг төрөхөөс олон
жилийн өмнө Бурхан
надад зориулан, амьдрах
үзэсгэлэнт газрыг
бүтээсэн.



Тэр дэлхийг бүтээхдээ эхлээд өдрийг шөнөөс салгасан. Тэр мөн намайг
үргэлж хөтлөн гэрэлтүүлэх нар, сар, оддыг бүтээсэн.



Бас тэнгэр, далай, газрыг
бүтээж, дэлхийг төрөл
бүрийн ургамлаар хучсан.




Тэнгэрт нисэх шувуу,
далайд сэлэх загас, газар
дээр амьдрах амьтдыг
бүтээсэн.



Бурханы бүтээсэн зүйлсийг харах болгонд надад Түүнийг хүндэлж, хайрлах сэтгэл төрдөг. Би Түүнд энэ дэлхийг надад зориулан бүтээсэнд талархдаг. ■

Би үзэсгэлэнт дэлхийн нэгдэхэн хэсэг



ЗУРАГ ЧИМЭГЭЛЭЙМТ АПРИЛ СТОТ



Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх
Ерөнхийлөгч Н.Элдон
Таннэр (1898–1982)

БҮТЭЭХ БОЛСОН ЗОРИЛГО

Бидний хүн нэг бүр гэр орноо дэлхий дээрх диваажин болгох боломжтой.

Бүтээгээр . . . дэлхийг бүтээх болсон зорилгыг авч үзье.

Судруудад энэ нь . . . Бурханы охид, хөвгүүдэд мөнх бус оршихуйд амьдарч, зарлигуудыг дагаснаар Бурханы оршихуйд буюу ирсэн газраа буцаж очих зохистой гэдгээ батлах зорилготой хэмээн тодорхойлсон.

Дэлхийг бүтээснийхээ дараа “Бурхан, Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгөө адилхан хүнийг бүтээе. . . .

Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.

Мөн Бурхад хэлэв: Бид тэднийг адислах болно. Мөн Бурхад айлдав: Бид тэднийг үр төлтэй байж мөн өсөн үржиж, мөн дэлхийг бүрхэн, мөн үүнийг захирах болно” (Эхлэл 1:26–28) хэмээн хэлсэн.



Бурхан эмэгтэй хүнийг бүтээж, эрэгтэй хүнд авчраад:

“Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох ажгуу” (Эхлэл 2:24) хэмээн айлджээ.

Тийм ээ, гэрлэлт нь Бурханаас томилогдсон бөгөөд эхнэр, нөхөр хоёрын талаар анх дурдагдсанаас хойш эрэгтэй, эмэгтэй хүн гэрлэх ёслол хийж эхнэр, нөхөр болдгийн нотолгоог судраас дахин дахин олж болно. Бид энд зүгээр л “ид[эж], уу[n], мөн баяс[ахын]” (2 Нифай 28:7) тулд ирээгүй. . . .

Бурхан бол мөнх бөгөөд Түүний бүтээсэн зүйлс, үнэн нь мөн адил

мөнх гэдгийг судруудаас суралцаж болно гэдгийг бид ойлгох нь чухал. Тиймээс Тэрээр Еваг Адамтай гэрлүүлсэн бөгөөд уг холбоо нь мөнхийн билээ. . . .

. . . Эцэг эхчүүд шууд утгаараа Тэнгэрлэг Эцэгийнхээ сүнслэг үр хүүхдүүд гэдгээ мөн бусдад мөнх бус махбодыг өгөх үүрэгтэй хэмээх амьдралынхаа зорилгыг ойлгох юм бол гэрт нь ирэх хүүхэд бүрийг Бурхантай хамтарч бүтээсэн гэдгээ ухааран ойлгож, үр хүүхэд төрүүлэх гайхамшигт үйлсэд баярлах болно.

Бидний хүн нэг бүр Есүс Христийн сайн мэдээ болон Бурханы зарлигуудыг сахиж, Түүнтэй хийсэн гэрээгээрээ дамжуулан өөрийгөө болон үр хүүхдүүдээ Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиход бэлдэх явцдаа гэр орноо дэлхий дээрх диваажин болгох боломжтой гэдгийг би мэднэ. ■

“He Slumbers Not, nor Sleeps,” Ensign, 1980 оны 5-р сар, 15–18-аас авав. Үг үсэг, цэг тэмдгийг стандартын дагуу болгов.



**ҮНЭ ЦЭНТЭЙ ХАЙР,
КЭЙТ МАЛЛЭТТ**

Бурханы аз жаргалын агуу төлөвлөгөө нь Түүний хүүхдүүдийн хувьд бидний хүн нэг бүрийг мөнх бус бие махбодтой болохын тулд дэлхийд ирж, гэр бүлийн харилцаа нь эв нэгдэл, хайраар цэцэглэн хөгжих тийм гэр бүлд амьдрах боломжоор хангадаг. Бид дэлхий дээрх гэр орондоо өөрсдийгөө болон хүүхдүүдээ Тэнгэрлэг Эцэг рүү буцаж очиход бэлддэг. (Эхлэл 1–2; Мозая 18:21; Алма 42-ыг үзнэ үү.)

Мөн энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Төлөвлөснөөсөө эрт гэртээ ирсэн нь

44-р
хуудас



Хэрэв та төлөвлөснөөсөө эрт номлолоосоо буцаж ирсэн бол үргэлжлүүлэн үйлчилж, өсөж хөгжсөөр байх найман зөвлөгөө энд байна.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

2018 ОНЫ МЮЧЕЛИЙН СЭДЭВ

Надаар дамжин амар амгалан чамд байх болно. Яаж гэдгийг энэ жилийн Мючелийн уриаг судалснаар олж мэд.

ХРИСТЭЭС
ИРЭХ АМАР
АМГАЛАН

52-р
хуудас

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ



Гэрлээрээ гэрэлтүүл

Энэ жил гэрлээрээ хэрхэн гэрэлтүүлж байгаагаа бидэнтэй хуваалцана уу?

54-р
хуудас



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ